



**ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

3 дугаар баг, Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (+976) 7053 3719, 7053 2307,  
Цахим шуудан: umnogoviemg@gmail.com  
Цахим хуудас: om.mohs.gov.mn

2024.12.16 № 988  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлан хүргүүлэх тухай

Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, албан хаагчдыг хөгжүүлэх сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг тус тус хүргүүлж байна.

Хавсралт Б.б хуудастай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

• 462408751

МОНГОЛ УЛС  
ӨМНӨГОВЬ АЙМАГ



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төлөвлөгөө тайлана хянасан: **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

**Аймгийн Засаг дарга** ...../Н.Энхбат/

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.12.09 (огноо)

Тэмдэг.....

Төлөвлөгөө тайлагнасан: **Төсвийн Шууд захирагч**

**Эрүүл мэндийн газрын дарга** ...../Ц.Жавзандулам/

(албан тушаал)

(гарын үсэг)

2024.12.09 (огноо)

Тэмдэг.....



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<p><b>Стратегийн зорилго-1: Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх, эрүүл зөв дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино.</b></p>							
<p><b>Зорилт 1.1. Халдварт өвчний тархалт, сэргийлэлт бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авах, дархлаажуулалтын арга хэмжээг хүртээмжтэй болгож, халдварт өвчний тархалтыг бууруулна.</b></p>							
1.1	<p><b>Арга хэмжээ 1.1.1</b> Томуугийн харуулдан тандалтын тогтвортой байдлыг хангаж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын тандалтыг нэгтгэх, үйл ажиллагааг бэхжүүлэх</p>	Орон нутгийн төсөв	Коронавируст халдварын өвчлөл 10000 хүн амд эзлэх хувь	46,3	40,0	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаалын дагуу Томуугийн харуулдан тандалтын тогтолцоонд Коронавируст халдварын тандалтыг аймгийн хэмжээнд 18 эрүүл мэндийн байгууллагаас авч 7 хоног бүр мэдээллийг Томуугийн үндэсний төвийн flu.mn программд 52 удаа бүртгэж оруулсан. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн байгууллагуудын 2024-2025 оны улирлын томуугийн бэлэн байдлын төлөвлөгөөг 4 чиглэлээр 73 үйл ажиллагаа төлөвлөн батлуулж бүх ЭМБ-д хүргүүлсэн. Төлөвлөгөө томуугийн улиралд 95,6 хувийн хэрэгжилттэй, үр дүнтэй хэрэгжиж байна. Аймгийн 2023/2024 оны томуугийн улиралд бүртгэгдсэн томуу, томуу төст өвчин, амьсгалын замын цочмог хүнд халдвар болон вирус судлалын тандалтын тоон мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд 10,000 хүн амд ТТӨ-ний 5585,4 тохиолдол бүртгэгдэж өмнөх жилээс 2472, сүүлийн 5 жилийн дунджаас 4,4 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. 2024 онд ТТӨ-с сэргийлэх зөвлөмжийг сумын эрүүл мэндийн байгууллагуудад 2 удаа, Боловсролын газар, сургууль цэцэрлэгүүдэд 2 удаа, томуугийн харуулдан тандалтын нэгжийн эмч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа нийт 54 эмч, мэргэжилтнүүдийг оролцуулан зохион байгуулсан. БОЭТ-ийн томуугийн лаборатори, хүүхдийн тасагт ЭМГ-ын ЭТҮХ, НЭМТ хамтран дэмжлэгт хяналтыг 2 удаа хийж, удирдлага аргазүйгээр ханган зөвлөмж хүргүүлсэн ба</p>	100

						<p>хүүхдийн тасгийн үндсэн 17 ор, нэмэлтээр Мэдрэлийн тасгийн уламжлалт эмчилгээний тасагт 25, эрчимт эмчилгээнд 4, халдвартын тасагт 8, гэмтлийн тасагт 20 нийт 74 ор дэлгэж ажиллахаар төлөвлөсөн. Үүнээс одоогоор 50 ор ашиглаж байна.</p> <p>Байгууллагын цахим хуудсанд 10 төрлийн санамж байршуулж 1,200 гаруй хандалтыг авсан. Коронавируст халдвар 2023 онд 296 бүртгэгдэж 10,000 хүн амд 40,1 байсан бөгөөд 2024 онд 17 бүртгэгдэж 10,000 хүн амд 2,3 байна. Одоогоор хувилбарын шинжилгээнд сорьц илгээх шаардлагагүй байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 1.1.2</b> Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх, тандах чиглэл хөтөлбөр, төслийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах</p>	Улсын төсөв	Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд	186,4	170.0	<p>Халдварт өвчнөөс сэргийлэх 2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 45 үйл ажиллагаа төлөвлөн баталж ЭМГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 70 тоот албан бичгээр бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн, хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 95.2 хувьтай үр дүнтэй хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Аймгийн хэмжээнд 2024 онд хүүхдийн байгууллагад гарсан халдварт өвчний 11 голомтод ажиллаж, зөвлөмжийг боловсролын байгууллагуудад хүргүүлсэн. Ялангуяа салхинцэцэг, гар хөл ам, томуугийн өвчлөл дэгдэлт байдлаар бүртгэгдэж, голомтод холбогдох хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэн голомтыг цомхотгон хүндрэл эрсдэлээс сэргийлж ажилласан. 2024 онд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй хоол хүнсний шалтгаант хордлого уул уурхай, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуй нэгжид голомтлон гарч 348 хүн өвчилсөн. Голомтлон гарсан хоол хүнсний шалтгаант хордлогын үед эрүүл мэндийн байгууллагаас хариу арга хэмжээг үр дүнтэй зохион</p>	100	

					байгуулж 6500 гаруй ажилчид, иргэнийг халдвар авах эрсдэлээс таслан сэргийлж, голомтыг цомхотгож ажилласан. 2024 оны 11 сарын байдлаар 1416 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 27 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 29.9%-г БЗДХ, 46,0%-г салхинцэцэг, 1,2%-г Ковид-19 өвчин, 6,1%-г хоолны хордлого, 4,4%-г цусан суулга, 1,4%-г улаан эсэргэнэ, 7,6%-г гар хөл амны өвчин, 0,7% ёлом, 0,9%-г сүрьеэ, 0.01%-г бүслүүр үлд, 0.07%-г вируст С гепатит, 0,8%-г арьсны мөөгөнцөртөх өвчлөл зэрэг өвчнүүд тус тус эзэлж байна. Хүн амын өсөлттэй холбоотой халдвар өвчин нэмэгдэж байна.  Халдварт өвчний тохиолдол 10000 хүн амд-187,6 байна.	
<b>Арга хэмжээ 1.1.3. “Эрүүл элэг”, Элэг бүтэн монгол</b> хөтөлбөрийг хэрэгжүүлж элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж илэрсэн өвчлөлийг эмчилгээнд хамруулах, В вирус эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулах	Орон нутгийн төсөв 100.0	Элэгний эрт илрүүлгийн хувь	81.0%	82.0%	“Элэг бүтэн монгол” арга хэмжээ, “Эрүүл элэг” орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд зорилтод насны хүн амын 60,3 хувь буюу 18015 иргэнийг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Эрт илрүүлгийн үр дүнд 0.1% буюу 16 тохиолдол нь С вирустэй, 0.1 % буюу 25 тохиолдол нь В вирустэй иргэдийг илрүүлэн эрүүл мэндийн байгууллагын хяналтад авсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд молекул биологийн шинжилгээний шинэ аппаратыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн анх удаагаа орон нутагт гепатит вирусийн идэвхжил тоолох шинжилгээг хийж эхэлсэн. Арга хэмжээний үр дүнд нийт 906 хүн шинжилгээ хийж HCV вирус 37,8% буюу 343 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 184 (53.6 %) идэвхтэй 159 (46.4%), HBV вирус 43,9% буюу 398 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 279 (70.1%) идэвхтэй 119 (29.9%) , HDV вирус 18,3% буюу 255 хүнд ачаалал үзэхэд идэвхгүй 147 (57.6%) идэвхтэй 108 (42.4%), HBV&HDV хавсарсан вирустэй (11.1 %) хүмүүс хамрагдсан байна. Элэгний С вирусийн эмчилгээнд хамрагдах шаардлагатай 159 иргэнээс 81 иргэнийг эмчилгээнд бүрэн хамруулж, 44 хүн эдгэрсэн байна. Үүнээс жирэмсэн 7 хүн эмчийн хяналтад орсон байна. Элэгний В вирусийн эмчилгээнд 75 хүн шинээр хяналтад орж нийт 30 хүн эмийн эмчилгээнд тасралтгүй хамрагдаж байна. Үүнээс жирэмсэн 10 эх эмчийн хяналтад байна. Элэгний В	85
		Эмчилгээнд хамрагдалтын хувь	30%	40%		

						<p>вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад 1067 хүн тун хийгдэж, үүнээс 298 хүн бүрэн тунд хамрагдаад байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Фиброскан аппарат ашиглалтад орсноос хойш 183 хүнд тусламж үзүүлснээс F1 зэргийн элэгний хатууралтай 2, F2 зэргийн элэгний хатууралтай 3, F3 зэргийн элэгний хатууралтай 5, F4 зэргийн элэгний хатууралтай 4 зэргийн оношлон шаардлагатай тусламж үйлчилгээг хүргээд байна. Мөн элэгний өөхлөлттэй 34 иргэдийг шинээр оношлон, эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.</p> <p>Эрт илрүүлгийн хувь-60,3</p> <p>Эмчилгээнд хамрагдалтын хувь-50,9</p>	
	<p><b>Арга хэмжээ 1.1.4.</b> Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх урьдчилан сэргийлэх болон хавьтлын үзлэг, сорьц тээвэрлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	Төсөл хөтөлбөр	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин 10000 хүн амд	3,1	3.0	<p>Аймгийн хэмжээнд 2024 онд сүрьеэгийн эрсдэлт бүлгийн судалгааг шинэчлэн нийт 2,921 хүнийг бүртгэн мэдээллийг цуглуулсан. Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын 23,7%-ийг илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулсан байна. ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт сэргийлэлтийн албанаас хяналт үнэлгээ хийхтэй холбоотой 12 сум, өрх буюу 70,5 хувьд нь дэмжлэг хяналт хийж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан. ХӨСҮТ-өөс Тубис программын цахим бүртгэлтэй холбоотой хяналт үнэлгээг 2 байгууллагад хийж, ажлын байрны дагалдан сургалт, мэдээллийг зохион байгуулсан. Аймгийн 17 сум, өрхийн эрүүл мэндийн төвийн сүрьеэгийн асуудал хариуцсаӨэртн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил зүйн арга зөвлөгөөг ажлын байран дээр нь өгч, ажлын байранд нь сургаж мэргэшүүлсэн. Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн сайн дурын ажилтан буюу олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх үндэсний хэмжээний сургалтад 1 сургагч багш бэлтгэгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Улаан загалмайн хороо, сумын эрүүл мэндийн төвтэй хамтран урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх явуулын үзлэг оношилгоог 6 суманд зохион байгуулж сүрьеэгийн үзлэгт 695 хүнийг хамруулсан. Үзлэгийн үр дүнд сэжигтэй 2 тохиолдлыг илрүүлж, идэвхтэй хэлбэрийн сүрьеэгийн 1 тохиолдлыг тус тус илрүүлж, эмчилгээнд хамруулж байна. Үзлэгт хамтрагдсан 695 хүний</p>	100

					<p>цээжний рентген зураг авч, сүрьеэгийн асуумж сорьц шинжилгээнд хамруулан лавлагаа шатлалд 21 хүнийг онош тодруулахаар шилжүүлэн ажилласан.</p> <p>2024 онд бүртгэгдсэн хүчилд тэсвэртэй нянгийн эерэг 5 тохиолдлын 12 хүнийг далд халдварын эмчилгээнд 100 хувь хамруулсан. Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос Дундговь, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймгийн СЭМТ-үүдийн багийн бага эмч, лаборант нарын оролцсон "Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа" сэдэвт Өмнөд бүсийн сургалт семинарыг зохион байгуулж 5 аймгийн 80 гаруй эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан.Сүрьеэгийн мэдээлэл сурталчилгааны төлөвлөгөөний дагуу сүрьеэтэй тэмцэх өдрийг угтуулан иргэдэд мэдээлэл сургалт, сурталчилгааг тасралтгүй зохион байгуулан (500) иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан байна.</p> <p>Сүрьеэгийн өвчлөл 13 бүртгэгдэж түвшин 10000 хүн амд 1,7 промилль байна.</p>	
--	--	--	--	--	---	--

	<p><b>Арга хэмжээ 1.1.5.</b> Зоонозын халдварт өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг судалгаа, нотолгоонд тулгуурлан зохион байгуулж, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах</p>	Улсын төсөв	Хачигт халдвар тохиолдол 10000 хүн амд	0.2	0.1	<p>2024 оны зоонозын халдварт өвчний хариу арга хэмжээний календарчилсан төлөвлөгөөний дагуу Булган, Гурвантэс, Сэврэй сумын нутагт хачгийн тархалт, нягтшил, зүйлийн бүрдэл, хачгаар дамжих халдварт өвчний байгалийн голомтын төлөв байдлыг тогтоох, хачигт халдварын тандалт шинжилгээг зохион байгуулсан. Тус тандалт шинжилгээний хүрээнд дээрх сумдын нутаг дэвсгэрт хачиг тархах боломжтой биотопыг сонгон бэлчээрийн хачиг цуглуулан зүйлийн бүрдлийг тодорхойлон, шинжлүүлэхээр ЗӨСҮТ-ийн вируслогийн лабораторид 226 хачиг хүргүүлэн шинжилгээнд хамруулсан. Зоонозын халдварт өвчний өнөөгийн мэдээлэл, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээ зэрэг халдварт өвчний мэдээллээр төрийн-158, эрүүл мэндийн-70 нийт 228 байгууллагын 3706 хүнд 215 цагийн сургалт хийж 25190 ширхэг санамж тараах материал тараан зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Ард иргэдэд зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5016 хүнд 397 удаагийн яриа таниулга, 6-8 төрлийн 8396 ширхэг санамж, тараах материал тараан, цахимаар 494 мэдээг, байгууллагын пэйж болон пэйс хаягаар дамжуулан 300924 хүний хандалт /давхардсан тоогоор/ авсан. Дуудлага бүрийг тухай бүр нь ZIS программд мэдээллийн сан үүсгэн тогтмол дуудлага мэдээллээ шивж ажиллаж байна. Галзуу өвчний эрсдэлд өртсөн 24 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд бүгдийг ZIS программд тухай бүрд нь шивж ЗӨСҮТ-өөр хянуулан заавар зөвлөгөөг авч ажиллаж байна. Мөн хачигт хазуулан онош тодруулахаар 11 хүнийг ZIS программд шивж оруулсан бөгөөд шинжилгээг ЗӨСҮТ-ийн лавлагаа лабораторийн тасагт хүргүүлэн хийгдсэн ба 1 хүн нь хачигт риккетсиоз IgM батлагдсан, 7 нь хачигт риккетсиоз үгүйсгэгдсэн, 3 нь давтан шинжилгээнд хамрагдаж байна. Хүний өвчлөл болон мэрэгч амьтны дуудлагад үйлчлэх бэлэн байдал хангагдсан. Галзуу өвчний эрсдэлд өртсөн 52 дуудлага хүлээн авч хариу арга хэмжээ тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан ба 22 хүнд эмчилгээний 5 тунгаар, 30 хүнд урьдчилан сэргийлэх 3 тунгаар галзуугийн эсрэг</p>	100
--	---	-------------	--	-----	-----	---	-----



						<p>вакцин хийгдсэн байна. 1 хүн өөрийн хүсэлтээр вакцин хийлгэхээс татгалзсан байна. 7 хүнд ийлдэс эмчилгээг хавсран хийж ажиллаа. Хачигт халдвараар 13 дуудлага мэдээлэл хүлээн авсан ба 1 хүн хачигт риккетсиозоор батлагдсан, 12 хүн лабораторийн шинжилгээгээр сөрөг гарч үгүйсгэгдсэн байна.</p> <p>Хачигт халдвар тохиолдол 10000 хүн амд 0.1 буюу 1 тохиолдол бүртгэгдсэн байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 1.1.6.</b> Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ыг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон ажиллана</p>	Орон нутгийн төсөв	БЗДХ илрүүлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан хүний тоо	800	1000	<p>2024 оны 11 сарын байдлаар нийт 1416 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 27 тохиолдлоор буурсан байна. БЗД-н-424 тохиолдол бүртгэгдэж үүнээс 13.9% жирэмсэн эмэгтэйчүүд, тэмбүү 32.3%, заг хүйтэн 32.5, хламид 7.8%, трихомониаз 16.7%, бусад халдвар 10.6%-ийг тус тус эзэлж байна. өнгөрсөн оны мөн үеэс 141 тохиолдлоор, 10000 хүн амд 18,6-р нэмэгдсэн ба 4,5% нь жирэмсний үзлэгээс, 9.4% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 79% нь өвчний учир амбулаториор, 4,7% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна. Илэрсэн өвчлөлийг 100% бүрэн эмчилгээнд хамруулж, хавьтагчийн 30%-ийг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн молекул биологийн лабораторид бэлгийн замын халдварын 14 төрлийн үүсгэгчийг тодорхойлох шинжилгээг шинээр нэвтрүүлж 471 хүнийг хамруулсан. Шинжилгээний үр дүнг тооцоход 11.6%</p>	100	
		Илрүүлсэн өвчлөлийг эмчилгээнд бүрэн хамруулсан хувь	100	100			

						буюу 55 тохиолдолд шинжилгээний хариу сөрөг, өөрчлөлтгүй гарсан.	
	<p><b>Арга хэмжээ 1.1.7.</b> Товлолын дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, ДДУХ-ын тандалтыг эрчимжүүлэх, дархлаажуулалтын чиглэлээр ажиллаж байгаа хүний нөөцийг чадваржуулах, мэргэшүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах</p>	Байгууллагын төсөв	Товлолын дархлаажуулалтын хамралтын хувь	98	99	<p>Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 10 сарын 31-ны өдрийн А/75 дугаар тушаалаар "Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн шалтгаан хамаарлыг тогтоох" баг байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 18 дархлаажуулалтын нэгжид мэргэшсэн 18 вакцинолог сувилал ажиллаж байна. 14 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ-ийн 18 вакцинолог сувилалчдыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж, 13 сумын ЭМТ-д дэмжлэгт хяналтыг газар дээр нь хийж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Вакцинологын мэргэшүүлэх сургалтад 1 сувилалчийг хамруулан мэргэшүүлж байна.</p> <p>2024 онд тарилгатай халдварт өвчний тохиолдол бүртгэгдээгүй. Товлолын вакцины хамралт 98,5%-тай 31 хүүхэд хоцорсон байна. БЦЖ вакцины хамралт-100%, В гепатит-100%, халдварт саагийн эсрэг вакцины хамралт 98,0 хувьтай, хоцорсон 5, тарьдаг саа 98% хувьтай, хоцорсон-7 хүүхэд байна. Тавт вакцины хамралт-98%, хоцорсон-5, А гепатит 98,5%-тай хоцорсон-3, УГУ вакцины хамралт -98,8% хоцорсон-6, ПЕВ вакцины хамралт 98.6 хувьтай хоцорсон 5 тохиолдол тус тус хамрагдсан байна. ДДУХ-ыг вакцин бүр дээр тогтмол тандаж байна. 2024 онд нийт 1830 хүүхэд тандалтад хамрагдсан бөгөөд хөнгөн урвал 16 хүүхдэд илэрсэн бол хүнд урвалын сэжигтэй тохиолдол 2 хүүхдэд илэрсэн. Үүнийг журмын дагуу тандалт судалгааг хийж ХӨСҮТ-д хүргүүлсэн. Улсын хэмжээнд Улаанбурхан өвчний дэгдэлт гарсантай холбоотой Улаанбурхан Улаануудын нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулж хүүхэд-946, эмнэлгийн ажилчид-727, Жирэмсэн эх -37, хил гаалийн ажилтан-120 хамруулсан.</p>	98,5

<p><b>Арга хэмжээ 1.1.8.</b> Тарилгат халдварт полиомиелит, улаанбурхан, улаанууд сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, тандах, тандалтын сорьц явуулах</p>	<p>Байгууллагын төсөв</p>	<p>Сорьцын тоо</p>	<p>0</p>	<p>15</p>	<p>Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 08 сарын 05-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний" улаан бурхан өвчнөөс сэргийлэх, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, тандах баг байгуулж чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, зөвлөмжөөр хангаж ажилласан. Аймгийн хэмжээнд цочмог халууралттай тууралттай сэжигтэй 2 тохиолдлыг бүртгэн сорьцыг ХӨСҮТ-ийн лабораторид хүргүүлсэн. Шинжилгээний хариу сөрөг гарч сэжигтэй тохиолдол үгүйсгэгдсэн. Полиомиелитын сэжигтэй 1 тохиолдлыг илрүүлэн тандалт хийж сорьц тээвэрлэсэн. Аймгийн хэмжээнд 5 жил тутамд 1 тохиолдлыг илрүүлэх зорилтыг ханган ажилласан. Тандалтын сорьцыг 15 хүүхдээс авч НЭМҮТ-ийн Полиомиелитын лабораторид хүргүүлэн шинжилж, хариуг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Сорьцын тоо-15</p>	<p>100</p>
<p><b>Арга хэмжээ 1.1.9.</b> Вакцины хадгалалт тээвэрлэлт, чанар аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, цахим бүртгэлийг сайжруулах, мэдээллийн баазад тогтмол хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангах</p>	<p>Байгууллагын төсөв</p>	<p>Тоног төхөөрөмжөөр хангагдсан ЭМБ-ын тоо</p>	<p>-</p>	<p>18</p>	<p>БОЭТ- электрон хэрэгсэл, Сум, өрхийн 18 эрүүл мэндийн төвийн вакцинжуулалтын цэгүүдэд шаардлагатай хүүхдийн ор, сувилагчийн тэргэнцэр, яаралтай тусламжийн цүнх, ариутгалын бикс, дижитал термометр, олон үйлдэлт принтер зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Дархлаажуулалтын нэгжийн тоног төхөөрөмжийн хангалт 100 хувьд хүрсэн. Папиллома вирусийн вакцин нэвтрэхтэй холбоотой хүйтэн хэлхээний чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар вакцины хөргөгчийн хэм хянах 10.0 сая төгрөгийн өртөгтэй электрон хэрэгсэл 59 ширхгийг эрүүл мэндийн байгууллагад, 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн газарт вакцины нөөц хадгалах 3 ширхэг хөргөгчөөр тус тус хангагдсан. Вакцины хадгалалт тээвэрлэлт, чанар аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудад 5 удаагийн зөвлөмж хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагын дарга нар болон вакцинатор сувилагчдад цахимаар 1, танхимаар 2 удаагийн сургалт хийсэн. Нийт 18 эрүүл мэндийн байгууллагын 60 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан. Сүүлийн 10 жилийн</p>	<p>100</p>

						<p>хугацаанд дархлаажуулсан хүүхдийн мэдээллийг цахимд нөхөн шивэх ажлыг зохион байгуулж гүйцэтгэл 92 хувьтай байна.</p> <p>2024 онд дархлаажуулалтын чиглэлээр 18 эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналт хийж зөвлөмжөөр хангасан</p> <p>Дэмжлэгт хяналт хийсэн ЭМБ-ын тоо-18</p>	
<p><b>Арга хэмжээ 1.1.10.</b> Шинэ вакциныг нэвтрүүлэх (Умайн хүзүүний папиллома вирусийн эсрэг вакциныг шинээр товлонд нэвтрүүлэх)</p>	Байгууллагын төсөв	Хамрагдалтын хувь	0	80%	<p>Папиллома вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэхтэй холбоотойгоор арга зүйн сургалтад холбогдох 4 мэргэжилтэн ХӨСҮТ-д сургалтад хамрагдан бэлтгэгдсэн. Аймгийн хэмжээнд дархлаажуулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан, нэгдсэн төлөвлөгөө боловсруулан сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд бичил төлөвлөгөө, зураглал гарган дархлаажуулалтын багийг томилгоожуулан ажилласан. Дархлаажуулалтыг улсын хэмжээнд 2024 оны 11 сарын 28-ны өдрөөс эхлүүлэн зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг 100 хувь хангасан.</p> <p>2024 онд шинэ вакцинжуулалт нэвтрүүлэхтэй холбоотой 3 удаагийн чадавхжуулах сургалтыг зохион байгуулж БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар болон вакцинатор сувилагч нар зэрэг нийт 170 гаруй эмч, мэргэжилтнийг хамруулсан. Мөн дархлаажуулалтыг амжилттай зохион байгуулах салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор сургуулийн захирлууд, сургуулийн эмч нарт 2 удаагийн сургалтыг зохион байгуулан нийт 86 багш ажилчдыг хамруулан ажилласан.</p> <p>Бэлтгэл ажлыг хангуулах, арга зүйн зөвлөгөөг 5 суманд зохион байгуулан дэмжлэгт хяналт хийж танхимаар нийт 470 гаруй ард иргэдэд, багш, эцэг эхчүүдэд дархлаажуулалтын ач холбогдол вакцины талаар сургалт хийж иргэдэд тараах гарын авлага, видео, AR технологид суурилсан мэдээлэл зэрэг нийт 3100 ширхэг гарын авлагыг хийж олон нийтэд хүргэсэн. Орон нутгийн харьяалалтай</p>	95	

						<p>нийт 40,000 иргэнд масс мессежийг илгээн мэдээлэл хүргэн ажилласан.</p> <p>Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтын арга хэмжээг 2024 оны 11 сарын 28-ны өдрөөс эхлэн зохион байгуулж аймгийн хэмжээнд 19,8% буюу 391 хүүхэд хамрагдаад байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 1.1.11.</b> Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалтыг сайжруулах, дэмжлэг хяналт, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж халдварын сэргийлэлт хяналтын багийг чадавхжуулах</p>	<p>Байгууллагын төсөв</p>	<p>Тандалтад хамрагдсан байгууллагын тоо</p>	-	18	<p>Аймгийн хэмжээнд нийт 18 эрүүл мэндийн байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын багаас хог хаягдлын менежмент болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой урьдчилсан үнэлгээг хагас бүтэн жилээр 53 асуумж бүхий үнэлгээний хуудсаар үнэлж, үнэлгээг нэгтгэн дүгнэж ажилласан. Үнэлгээний үр дүнд сайжруулах шаардлагатай 3, хангалттай 15 эрүүл мэндийн байгууллага байна. Үр дүнд 35 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн 30 гаруй байгууллагын 45 эмч мэргэжилтэнд эмнэлгээс шалтгаалах халдвар, халдвар хяналтын багийн чиглэлээр сургалт зохион байгуулж чадавхжуулсан. Сургалтын үр дүнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт сайжрах, эрүүл мэндийн ажилчдын халдвар авах эрсдэлт хүчин зүйл өртөлт буурч, эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулсан. Аймгийн 17 эрүүл мэндийн байгууллагын мэс заслын дараах шархны халдварын тандалтыг 198 үйлчлүүлэгчдэд, судасны гуурстай(уян зүү) холбоотой халдвар илрүүлэх тандалтыг 154 үйлчлүүлэгчдэд, төрсний дараа эх, нярайг эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх болон гэрийн эргэлт хийх үед халдвар илрүүлэх тандалтыг 115 үйлчлүүлэгчдэд, шээлгүүртэй холбоотой шээсний замын идэвхтэй тандалтыг 18 иргэнд хийсэн байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой сэжигтэй тохиолдол 2 бүртгэгдсэн ба дараагийн шатлалын эмнэлэгт хүргэгдсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдал үүсэж байгаа цэг бүрд ангилан цуглуулах нөхцөл бүрдсэн ба шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Хог хаягдлын менежмент дотоодын хяналт улирал бүр</p>	<p>100</p>	
		<p>Бэлтгэгдсэн халдвар хяналтын ажилтны тоо</p>	-	18			

						хийгдэж байна. 18 эрүүл мэндийн байгууллагын Хог хаягдлын түр хадгалах цэгт дотоодын хяналт нийт 54 удаа хийгдэж зөвлөмж хүргэж ажилласан байна. Нийт 12 эрүүл мэндийн байгууллага шатаах зуух ашиглаж байгаа бол 5 эрүүл мэндийн байгууллага компанид гэрээлэн хог хаягдлыг устгаж байна. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдал асгарсан, алдагдсан тохиолдол бүртгэгдээгүй байна.  Тандалтад хамрагдсан байгууллагын тоо-18  Бэлтгэгдсэн халдвар хяналтын ажилтны тоо-45	
<b>Арга хэмжээ 1.1.12.</b> Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөх, ЭМБ-ын эмч, мэргэжилтнийг чадавхжуулах	Байгууллагын төсөв	Сургалт үйл ажиллагаанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо	30	50	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөх төлөвлөгөөний хүрээнд томуугийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилтын 73 арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж төлөвлөгөөнд тодотгол хийн бэлтгэл бэлэн байдлыг хангасан. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 95,6 хувьтай хэрэгжсэн.  2024 онд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болзошгүй хоол хүнсний шалтгаант хордлого уул уурхай, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуй нэгжид голомтлон гарч 348 хүн өвчилсөн. Голомтод мэргэжлийн баг бүрдүүлэн ажиллаж, голомтлон гарсан гэдэсний халдварын үүсгэгч эх уурхайг тодорхойлж, голомтыг таслан зогсоон, зөвлөмж арга зүйгээр ханган ажилласан. Голомтлон гарсан хоол хүнсний шалтгаант хордлогын үед эрүүл мэндийн байгууллагаас хариу арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж 9186 гаруй ажилчид, иргэнийг халдвар авах эрсдэлээс таслан сэргийлж, голомтыг цомхотгож ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний чиглэлээр уул уурхай үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, сумдын засаг дарга, сумын эрүүл мэндийн	100	

						төвүүдэд 3 удаагийн зөвлөмж чиглэлийг хүргүүлэн ажилласан.  Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний, дархлаажуулалтын чиглэлээр эмч, мэргэжилтнийг чадавхжуулах цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж 18 эрүүл мэндийн байгууллагын 150 гаруй эмч, мэргэжилтнийг хамруулан, мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн.	
<b>Зорилт 1.2. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэргийлж болох эндэгдлийг иргэд, хамт олны оролцоотой бууруулж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг эрчимжүүлэх</b>							
<b>Арга хэмжээ 1.2.1.</b> Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл тухайлбал, элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдар, чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлэх үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх.	Улсын төсөв	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг /10 000 хүнд амд/	34.6	35.6	Аймгийн хэмжээнд артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт хамрагдвал зохих 28375 иргэдээс 16640 (58,6%) иргэн, Чихрийн шижингийн эрт илрүүлэгт хамрагдвал зохих 28962 иргэдээс 15957 (55%) иргэн, Хөхний үзлэгт 12406 иргэнээс 6735 (54,3) иргэн, Умайн хүзүүний эсийн шинжилгээнд 5161 иргэнээс 1640(31,8%) хамрагдсан байна. Анхан шатны эмнэлгүүдэд суурилсан эрт илрүүлгийн дундаж 65,4 хувьтай байна. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 343752 хүнд үзлэг шинжилгээ хийсний 86281 /25.1%/-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн.  11 сарын байдлаар халдварт бус өвчлөл шинээр 89728 бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9711 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 70,8% нь шинэ өвчлөл байна. Үүнээс Амьсгалын тогтолцооны өвчин-22131, Хоол шингээх эрхтний өвчин-21804, Шээс бэлэгсийн тогтолцооны өвчин-7497, Цусны эргэлтийн тогтолцооны өвчин-7069, Мэдрэлийн тогтолцооны өвчин-4631 байна.	100	
		Чихрийн шижин өвчний эрт илрүүлэг /10 000 хүнд амд/	52	56			
		Хөхний хавдрын эрт илрүүлгийн тоо	6611	6711			
		Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг /10000 хүнд амд/	19.3	36.7			

	<p><b>Арга хэмжээ 1.2.2.</b> Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, 18-30 насны хүн амын дундах эрт илрүүлэг зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>Орон нутгийн төсөв 100.0</p>	<p>Эрт илрүүлэгт 18-аас дээш насны хүн амын хамрагдалтын хувь</p>	<p>31.0</p>	<p>70</p>	<p>Орон нутгийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх 2024 оны ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөт ажлын хүрээнд 18-30 насны багцын үзлэг оношилгоо зохион байгуулж буй эрүүл мэндийн байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж, хүний нөөцийн судалгаанд үндэслэн Цогтцэций, Гурвантэс, Ханбогд, Манлай, Ноён, Сэврэй сумын эрүүл мэндийн төвд чадавхыг үнэлгээг зохион байгуулан ажилласан. Чадавхын үнэлгээг Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран 1-2 удаа зохион байгуулж чадавхыг үнэлгээгээр зөвхөн Ханбогд сумын эрүүл мэндийн төв тэнцсэн. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай Ханбогд сум гэрээлэн эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 18-30 насны үзлэгийг зохион байгуулахаар болсон. Энэ оны 3 дугаар улиралд Даланзадгад сумын хэмжээнд Жасминдра клиниктэй гэрээлэн эрт илрүүлгийн арга хэмжээг зохион байгуулж эхэлсэн. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага дээр эрт илрүүлгийг зохион байгуулсан нь урьдчилан сэргийлэх үзлэгийн хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлсэн. 2024 оны 8 дугаар сараас хойш эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын гүйцэтгэлийн санхүүжилт олгогдохгүй, өр зээлийн асуудал үүссэнтэй холбоотойгоор эрт илрүүлгийн хамралт удааширч байна. Даатгалын санхүүжилт үндэсний хэмжээнд тасарсантай холбоотойгоор бусад аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагууд бэрхшээл үүссэн. Өвчлөлийн мэдээгээр нийт үзлэгт хамрагдсан иргэдийн 88,5%-д өвчлөл илэрсэн бөгөөд үүнээс 18-30 насны иргэдийн 32,9%-д, 31-45 насны иргэдийн 96,7%-д, 46-60 насны иргэдийн 99,4%-д, 61-дээш насны иргэдийн 100%-д өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна. Мөн нийт өвчлөлийн 53,6% хоол боловсруулах тогтолцооны өвчин, 19,4% дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчнүүд, 11,3% Шээс бэлгийн тогтолцооны эмгэг, 7,5% Зүрх –судасны тогтолцооны өвчин, 1,1% Амьсгалын тогтолцооны өвчин бүртгэгдээд байна. Өмнөговь аймгийн</p>	<p>85</p>
--	--	-------------------------------------	---	-------------	-----------	--	-----------



						хэмжээнд 18-30 насны 2133 /16%/, улсын дунджаас 11,4%-аас байна..	
	<p><b>Арга хэмжээ 1.2.3.</b> Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг насны бүлгээр хамруулж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлж хамрагдалтыг нэмэгдүүлэх</p>	Орон нутгийн төсөв	Эрт илрүүлгийн хувь	31.0	70.0	<p>Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, хүн амын дундах эрт илрүүлэг үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахаар 100.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн эрт илрүүлгийн үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар насанд хүрэгчдийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулахаар “Жасминдра” клиниктэй гэрээлэн ажиллаж байна. Мөн эрт илрүүлэг үзлэгийн эрчимжүүлэх зорилгоор Улсын нэг дүгээр төв эмнэлэг болон CLINICO HEALTH CENTRE эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарийн хамтарсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо "Нүүдлийн эмнэлгийн үзлэг" арга хэмжээг амжилттай зохион байгуулж нийт 1165 иргэнийг хамруулсан. Үүнээс 481 малчин хамрагдсан. Үзлэгээр хавдрын урьдал-4, шинэ чихрийн шижин-3, бөөрний хоргүй хавдар-1, элэгний миоплазм-2, уушгины хавдрын сэжигтэй тохиолдол-1, ходоодны шарх-6, зүрх судасны эмгэгтэй 156 хүн илэрч, өрх сумын эрүүл мэндийн төвд мэдээлэх, лавлагаа шатлалд шилжүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт үзлэг хамрагдсан иргэдийн 14.8% нь өвчлөл илэрсэн байна. Үзлэгийн мэдээллийг насны багцаар үзвэл: 0-5 нас 6101/57.8%, 6-17 нас 12873/74%/, 18-30 нас 2133/16%/, 31-45 нас 2874/15,7%/, 46-60 нас 2348/22,2%/, 61+ нас 1044/21.4%/ хамрагдсан байна.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагуудад эрт илрүүлэг үзлэгтэй холбоотой тушаал, шийдвэр, үзлэг идэвхжүүлэх зөвлөмж бичгийг 22 удаа, төрийн болон төрийн бус албан байгууллага, уул уурхайн компаниудад үзлэгт хамрагдах зааврыг 4 удаа хүргүүлсэн. Иргэдийг уриалах, заавар</p>	52

						<p>зөвлөмжөөр хангах 40 мэдээлэл бэлтгэн цахим сүлжээнд байршуулсан, ойролцоогоор 10000 иргэний хандалттай байна. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу эрт илрүүлгийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зөвхөн Бүсийн оношилгоо эмчилгээний төв дээр суурилан зохион байгуулан ажиллаж байгаа нь хамралт хангалтгүй байх, очер дараалал үүсэх шалтгаан болж байна. Цаашид хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг нэмэгдүүлэн эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ оны 8 дугаар сараас хойш байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын санхүүжилт олгогдохгүй, өр зээлний асуудал үүссэнтэй холбоотойгоор эрт илрүүлгийн хамралт удааширч байна.</p> <p>Эрт илрүүлгийн хувь 36,5 байна. Улсын дунджаас 9,5%-аар бага байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 1.2.4.</b> Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын урьдчилан сэргийлэх үзлэг”-г зохион байгуулах</p>	<p>Орон нутгийн төсөв 80.0 сая төг</p>	<p>Хүрч үйлчилсэн хүний тоо</p>	<p>3500</p>	<p>4000</p>	<p>“Эрүүл Өмнөговьчууд” зорилтын хүрээнд “Явуулын үзлэг” арга хэмжээг 6 суманд зохион байгуулж 2,136 иргэнийг орон нутгийн 39,105,834 төгрөгийн санхүүжилтээр хамруулахаар төлөвлөн ажиллаа. Үзлэг арга хэмжээг нарийн мэргэжлийн 13 чиглэлийн 31 эмч, мэргэжилтнийг хамруулан 6 суманд зохион байгуулж 3339 хүн амыг хамруулсан. Үзлэгт малчин, өндөр настан, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдах боломжгүй зэрэг зорилтот хүн амд чиглэсэн. Мөн тухайн сум орон нутагт шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийг сонгон авч явж ажилласан нь илүү үр дүнтэй болсон. Үзлэгт 3339 иргэн хамрагдаж үүнээс 1325/39%/ малчин, 480/14%/ ахмад настанд, 1030/30%/ эрэгтэй, 2309/70%/ эмэгтэй хамрагдаж, 508/15%/ иргэнд анхан шатанд нь эмэн эмчилгээ, эрүүл мэндийн зөвлөгөөг хүргэж, 237/7%/ иргэнийг лавлагаа шатлалд шилүүлсэн байна. "Нүүдлийн эмнэлгийн үзлэг" арга хэмжээг орон нутгийн 9,064,927 төгрөгийн санхүүжилтээр Сэврэй, Цогтцэций, Ханбогд, Даланзадгад суманд 4 бүсэд зохион байгуулан 15 сумын 1165 иргэнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулсан. Үүнээс 481 малчин</p>	<p>100</p>	

						хамрагдсан. Говийн оюу хөгжлийг дэмжих сантай хамтран Иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэн Эрүүл зүрх аяныг 7 суманд зүрхний өвчтэй, өндөр настай, малчин 311 иргэдэд зүрхний нарийн мэргэжлийн эмчийг үзлэгийг зохион байгуулсан.  Хүрч үйлчилсэн хүний тоо - 4815 иргэн		
1.2	<b>Арга хэмжээ</b> Хавдрын эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эмчилгээг орон нутагт нэвтрүүлэх	<b>1.2.5.</b> хими бай нутагт	Орон нутгийн төсөв 190.0 сая төгрөг	Эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	17	50	“Хавдрын хими эмчилгээний хэсэг”-ийг 2023 оны 11 сард байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулан 2024 онд 26 хүнд давхардсан тоогоор нийт 136 удаагийн хавдрын хими, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хүргээд байна. Хавдраар оношлогдсон 608 хүнээс ХСҮТ-д 30 хүн хими эмчилгээнд хамрагдаж байна. Орон нутагтаа хими эмчилгээг эхлүүлснээр 86,6% нь орон нутагтаа хамрагдсан байна. 2024 онд нийт хөнгөвчлөх тасагт 85 хүн хэвтэн эмчилгээнд хамруулан ажилласан. Хавдрын хөнгөвчлөх, хими эмчилгээ хийхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн стандарт хангалтыг 100 хувьд хүргэсэн.  Шимбилэг ӨЭМТ, Гурвантэс СЭМТ, Цогтцэций СЭМТ, БОЭТ-д умайн хүзүүний өвчлөл, хавдрыг эрт илрүүлэх колькоскоппыг 2023 онд нийлүүлэн ашиглалтад оруулан 2024 онд 712 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн. Үзлэгээр умайн хүзүүний хавдрын урьдал байх магадлалтай 408 хүн буюу нийт үзлэгийн 57,3%-эсийн шинжилгээнд хамруулсан Үүнээс умайн хүзүүний хавдрын урьдлаар 2 хүн оношлогдож шаардлагатай эмчилгээг хийж эмчийн хяналтад авсан. Элэгний хавдрын эрт илрүүлэг 12554 хүн буюу нийт хамрагдалтын 42,0%, Умайн хүзүүний эсийн шинжилгээнд 1409 хүн буюу 27,3%, Хөхний үзлэгт 6050 буюу 48,8% нь хамрагдсанаас умайн хүзүүний хорт хавдар 1 тохиолдлыг илрүүлж шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. "Хайр дүүрэн гар" хүрч үйлчлэх арга хэмжээг 14 сумын IV, V дугаар бүлгийн хавдартай 40 хүнд, хавдраар оношлогдоод хяналтад байдаг 0-18 насны /20/ хүүхдүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ, зөвлөгөө зөвлөмжийг хүргэн ажилласан. Хавдраар оношлогдсон иргэдийн хөдөлмөрийн чадвар тодорхой хэмжээгээр	100

						<p>алдагдаж амьдралынхаа турш бие махбод, сэтгэл зүй, нийгмийн асуудалтай тэмцэх шаардлагатай болдог. Иймд хүнд өвчин даван туулж буй хүмүүст стрессийг хэрхэн даван туулах чадварыг эзэмшүүлэх, эерэг мэдрэмж авах, цагийг хэрхэн сонирхолтой дурсамжтай өнгөрүүлэх талаар мэдлэг олгох, хавдрын өвчний үеийн хооллолт зэргээр сургалт зохион байгуулсан. Мөн 0-18 насны Хавдраар оношлогдсон хүүхдүүд болон зорилтод бүлгийн хүүхдүүдэд Art Therapy-Урлагийн сэтгэл заслаар дамжуулан өөрийгөө ойлгох, зорилтод иргэдийн гэр бүл, асран хамгаалагчдад асаргаа сувилгаа, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх талаар сургалтыг Өмнөговь аймгийн ЗДТГ, НБХ, ЭМГ, БОЭТ, хамтран хавдартай иргэд, зорилтод бүлгийн хүүхдүүд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүд асран хамгаалагч 50 хүн, зорилтод бүлгийн хүүхдүүд болон гэр бүлийн 70 хүнд сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>БОЭТ-н 2 сувилагчийг ХСҮТ-д хавдрын хими бай эмчилгээний сувилагчийн богино хугацааны ажлын байрны дагалдан сургалтад хамруулахаар шаардлагатай байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэсэн.</p> <p>Бай эмчилгээг орон нутагтаа нэвтрүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн төсвөөр 36,4 сая төгрөгийн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийхээр төлөвлөж байна.</p> <p>Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо -85</p> <p>Хими эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо-26</p>	
<p><b>Арга хэмжээ 1.2.6. “Эрүүл шүд”</b> хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөндийн үйлчилгээний</p>	<p><b>1.2.6. шүд”</b> амны тусламж чанар</p>	<p>Орон нутгийн төсөв 150.0 сая төг</p>	<p>Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо</p>	<p>3150</p>	<p>32000</p>	<p>“Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 18 арга хэмжээг төлөвлөн 92%-тай хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд 6 сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинет, хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг, Говь дент шүдний төв, БОЭТ зэрэг нийт 16 кабинетаар амны хөндий, шүдний тусламж үйлчилгээг амбулаториор 35,430 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс өвчний учир 24,801, урьдчилан сэргийлэхээр 10,629 иргэн байна. Өнгөрсөн онтой</p>	<p>100</p>

	хүртээмжийг нэмэгдүүлэх.		Эмчлэн эрүүлжүүлсэн хүний тоо		<p>харьцуулахад тусламж үйлчилгээ хүргэсэн хүний тоо 12.4 хувиар нэмэгдсэн байна. Бусад үйл ажиллагааны хүрээнд шүдний эмчгүй сумын эрүүл мэндийн төвүүд шүдний эмч ажиллуулан 1200 иргэнд тусламж үзүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан Говь дент шүдний төв 9445 иргэнд амны хөндийн тусламж үйлчилгээ, 2142 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг үнэ төлбөргүй зохион байгуулж ажиллаа. Аймгийн Засаг даргын А/63 дугаар захирамжийн хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгж бүр байгууллагын ажлын чиг үүрэг, онцлогт тохируулан албан хаагчдад амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, амны хөндий, шүд угаалтын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, ажлын байрандаа шүдээ тогтмол угаах орчин нөхцөлийг 18 байгууллага "Шүд угаах хэсэг" тохижуулсан. Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургуульд шүд угаах хэсгийг орон нутгийн төсвийн 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлан тохижуулах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхээр зураг төсөв боловсруулагдан худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж байна. Орон нутагт 2 дахь удаагаа "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг бэлтгэл ажлын хүрээнд багш, мэргэжилтнүүдэд дадлага сургалтын арга хэмжээг 2 өдөр 80 багш, эмч мэргэжилтэнд зохион байгуулсан ба тэмцээнд үе тэнгийн 144 сургагч багш, 40 бэлтгэгч багш, 54 шүүгчид, 20 тэмцээн зохион байгуулагчдын нийт 258 хүний бүрэлдэхүүнтэй амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд оролцогч хүүхдүүдийн асран хамгаалагчдаас авсан өмнөх болон дараах асуумж судалгаагаар амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг 92,1% нэмэгдсэн бол хүүхдээс авах судалгаагаар хүүхдийн мэдлэг 100% нэмэгдсэн байна. 2023 онд хийгдсэн тэмцээний дундаж үнэлгээ 83 байсан бол энэ онд 85,6 болж 2,6 болж үнэлгээ нэмэгдсэн байна. Энэ нь жил ирэх тусам хүүхдүүдийн шүдээ угаах чадвар нэмэгдэж байгааг харуулж байна. 18 эрүүл мэндийн байгууллагын хүрээнд амны хөндий, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх 6 төрлийн видео контент, 15 төрлийн мэдээллийн брошюр, гарын авлагыг 9500 гаруй хүнд хүргэж, хэвлэл мэдээллийн</p>	
--	--------------------------	--	-------------------------------	--	---	--

						<p>хэрэгсэл, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэж ажиллаа. Хөтөлбөрийн санхүүжилтийн 30% багаж төхөөрөмж худалдан авах, 40% шүдний хэсэг байгуулах, 2,2% сургалтын үйл ажиллагаа, 13,04% үзлэг арга хэмжээ, 8,02% шүдний угаалтын тэмцээн, 5,9% шүдний төвийн тохижилтын зардалд тус тус зарцуулсан.</p> <p>Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо-35430 Эмчлэн эрүүлжүүлсэн хүний тоо- 23029</p>	
	<p><b>Арга хэмжээ 1.2.7.</b> Алслагдсан суманд амны хөндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, Даланзадгад сумын шүдний төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>Орон нутгийн төсөв 50.0 сая төгрөг</p>	<p>Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо</p>	5003	10000	<p>Хөдөө орон нутагт тусламж үйлчилгээг өргөжүүлэхээр Номгон, Цогт-овоо сумдад шүдний кабинет тохижуулахаар шаардлагатай багаж тоног төхөөрөмж, урвалж материалын эрүүл шүд хөтөлбөрөөс 10 сая төгрөгийн багаж, төхөөрөмжийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Иймд Ханбогд, Номгон, Цогт-овоо, Гурвантэс, Цогтцэций, Манлай шүдний кабинет ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. 11 сарын байдлаар сумын эрүүл мэндийн төвүүд 4951 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн Говь дент шүдний төв 9445 иргэнд амны хөндийн тусламж үйлчилгээ, 2142 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг үнэ төлбөргүй зохион байгуулсан. Мөн сар бүр дэмжих аяныг зохион байгуулж хүүхдэд ээлтэй сард тусгай хэрэгцээт хүүхдийн сар болгон зорилтот бүлгийн иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Шүдний төвд 3 эмч, 3 сувилагч, 1 үйлчлэгчтэй хамран ажиллаж байна. “Шүдний явуулын үзлэг” арга хэмжээг 12 сумын 6,12 настай 700 хүүхдэд фтор түрхлэг, 500 орчим иргэнд тусламж үйлчилгээ хүргэхээр төлөвлөн Говь дент шүдний төвөөр гүйцэлдүүлэхээр ажлыг эхлүүлсэн. 12 сарын байдлаар Цогт-овоо, Баяндалай, Гурвантэс суманд ажиллаж амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 501 хүнд үзлэг эмчилгээ, эрдэсжүүлэх түрхлэг хийсэн. Үүнээс шүдний ломбо эмчилгээ -149 хүнд, Шүдний чулуу түүх эмчилгээ -6 хүнд, Шүд авалт-42 хүнд, Фторт түрхлэг-326 хүнд хийгдсэн байна. 6-12 настай-249 хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, эрдэсжүүлэх буюу фторт түрхлэг хийсэн. Үүнээс Эрүүл хүүхэд-70, Цоорлын тархалт-86.3% байна.</p>	100

						Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо-14396	
	<b>Арга хэмжээ 1.2.8</b> Осол гэмтэл өвчлөл ялангуяа хүүхдийн түлэгдэлт, гэмтэл, амиа хорлох, нас баралтаас сэргийлсэн мэдээлэл сургалт сурталчилгаа, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх		10000 хүн амд	173.5	170	<p>Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд 17 албан байгууллагын 1764 иргэд, албан хаагчдад сургалт мэдээлэл зохион байгуулж осол гэмтлийн өвчлөл ялангуяа гэрийн нөхцөлд хүүхдийн түлэгдэлт, гэмтэл, амиа хорлох, нас баралтаас сэргийлсэн мэдээлэл сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна.</p> <p>11 сарын байдлаар 1680 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба өвчлөл урьд оноос 528 тохиолдлоор өссөн байна. Он гарсаар 304 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 66/21.7%/ нь хорт хавдар, /35/13.2% нь осол гэмтлийн нас баралт, 20/6.6%/ нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдлээр нас барсан байна. Нийт нас баралтын 71 (23.4%) нь эмнэлэгт, бусад нь гэртээ хээр гадаа нас барсан байна. Нас баралт өнгөрсөн оны мөн үеэс 21 тохиолдлоор өссөн байна Осол гэмтэл 42,8% гэртээ, 34.2%-гудамж зам, 5,1% сургууль цэцэрлэгийн орчинд тохиолдсон нь өнгөрсөн оноос гэрийн орчин дахь осол гэмтэл буурч, гудамж замын осол нэмэгдэж, сургуулийн орчны гэмтэл өнгөрсөн оны түвшинд байна.</p> <p>11 сарын байдлаар Осол гэмтлийн шалтгаанаар нас баралт нийт 35 бүртгэгдсэн өмнөх оны мөн үеэс 6 тохиолдлоор буурсан байна. Тохиолдлыг газраар авч үзвэл гэртээ 1, гудамж зам 3, бусад газарт 1 байна. Цагдаагийн газартай хамтран ахуйн болон бага насны хүүхдийн унадаг дугуйн осол гэмтлийн мэдээлэл, сэрэмжлүүлгийг цахим орчинд хүргэх ажлыг хүрээнд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2024” тэмцээний хүрээнд аймгийн төвийн 10 цэцэрлэгийн 1832 эцэг эх, багш, ажилчдад “Хуулийн нэмэлт өөрчлөлт”, “Мотоциклын хамгаалах малгай” зэрэг сэдвийн хүрээнд 10 удаагийн сургалтыг 1 цагийн хугацаатай зохион</p>	100

						байгуулсан. Унадаг дугуй болон цахилгаан дугуйгаар хөдөлгөөнд оролцохдоо анхаарах асуудал сэдвээр 6 сургуулийн ахлах, дунд ангийн 955 хүүхдэд 6 удаагийн 40 минутын сургалтыг зохион байгуулсан.  100000 хүн амд осол гэмтлийн шалтгаант өвчлөл 216,8 байна.  10000 хүн амд осол гэмтлийн шалтгаант нас баралт 4,4 байна.	
	<b>Арга хэмжээ 1.2.9</b> Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт CERVICARE AI систем буюу хиймэл оюун ухаанд суурилсан оношилгоог нэвтрүүлэх	Орон нутгийн төсөв  50.0 сая төгрөг	Оношилгоонд хамрагдсан хүний тоо	162	500	2023 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн оношилгооны системийг ашиглалтад оруулан тусламж үйлчилгээг 2024 он гарснаар 167 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнээс умайн хүзүүний улайлт өөрчлөлттэй 15 эмэгтэйг эсийн шинжилгээнд, 5 эмэгтэй эдийн шинжилгээнд хамруулсан. 2024 онд Орон нутгийн хэмжээнд анх удаа Гурвантэс сумын эрүүл мэндийн төвд умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт CERVICARE AI систем буюу хиймэл оюун ухаанд суурилсан оношилгооны аппаратыг Орон нутгийн төсвийн 49,0 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэн хүлээлгэн өгсөн үзлэг хийгдэж эхлээгүй байна.  БОЭТ-хамтран Цогт-овоо-, Мандал-овоо, Баяндалай суманд 216 хүнийг үзлэгт хамруулсан байна. Үүнээс умайн хүзүүний улайлттай 35 эмэгтэйг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна. Мөн CERVICARE AI систем буюу хиймэл оюун ухаанд суурилсан оношилгоог орон нутагт Түмэн мэлмий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нэвтрүүлэн -468 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 318 хэвийн, умайн хүзүүний шарх улайлттай давтан үзлэгт орох-86, умайн хүзүүний хавдрын урьдал болон сэжигтэй-64, эдийн шинжилгээнд хамруулсан-64 байна.  Хиймэл оюун ухаанд суурилсан оношилгоонд хамрагдсан хүний тоо –851	100



	<p><b>Арга хэмжээ 1.2.10</b> Хавдрын хөнгөвчлөх, хими эмчилгээ зэрэг хавдрын чиглэлээр үйл ажиллагааг явуулж буй эмнэлэг, хосписын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Орон нутгийн төсөв 10.0 сая төгрөг</p>	<p>Туршлага судлах үйл ажиллагаанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо</p>	<p>5</p>	<p>10</p>	<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөхний хавдрыг илрүүлэх маммографийн аппаратыг орон нутгийн төсвийн 380 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэн эмчилгээ оношилгоо дээр дэвшилтэд шинэ технологийг нэвтрүүлээд байна. Тоног төхөөрөмж ажиллуулахад шаардлагатай 1 эмч, мэргэжилтнийг лавлагаа шатлалын эмнэлэгт ажлын байрны дагалдан сургалтад хамруулан чадавжуулсан. 2024 оны байдлаар 118 иргэнд хөхний хавдрыг илрүүлэх маммографийн оношилгоог хийгээд байна.</p> <p>Ажлын байрны дагалдан сургалтыг БОЭТөвийн дүрс оношилгооны эмч, хавдрын хими эмчилгээний эмч, эмэгтэйчүүдийн хавдрын эмч нар Хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр Германы Ахмад мэргэжилтний албатай /Senior Experten Service/ хамтран Герман улсын эмэгтэйчүүдийн хавдрын эмчийг орон нутагт ажиллуулан хамтарсан үзлэгийг 45 хүнд хийсэн үүнээс хөхний хорт хавдар-9, Өндгөвчний хавдар-1, эмэгтэйчүүдийн хоргүй хавдар-1, киста-3 зэрэг өвчлөлийн тохиолдлыг илрүүлж өөрчлөлттэй байх магадлалтай 31 иргэнд үзлэг зөвлөгөөг өгсөн.</p> <p>Энэтхэг улсын Шинэ Дели хотын Макс эмнэлэгт 8 хүний бүрэлдэхүүнтэй баг 7 хоногийн хугацаанд туршлага судалсан.</p> <p>Мөн Швейцар улсад болсон Олон улсын хавдрын эмч нарын хуралд 2 хоногийн хугацаатай 3 хүний бүрэлдэхүүнтэй явж хавдрын зөвлөгөөнд оролцон туршлага судалсан.</p> <p>Ажлын байрны дагалдан сургалтад хамрагдсан, туршлага судалсан эмч мэргэжилтний тоо-16</p>	<p>100</p>
	<p><b>Арга хэмжээ 1.2.11.</b> Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Арга хэмжээний дундаж</p>	<p>85.0</p>	<p>90.0</p>	<p>Хүн амын дундаж наслалтыг уртасгах, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг Өмнөговь аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй</p>	<p>92</p>

<p>(“Хавдрын эсрэг арга хэмжээ”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл, идэвхтэй амьдрал”)-г үр дүнтэй хэрэгжүүлэх</p>		<p>хэрэгжилтийн хувь</p>			<p>бодлогын баримт бичгийн хүрээнд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлээр аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 7 төрлийн төсөл арга хэмжээг тусган шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт суулган хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал Хавдрын эсрэг арга хэмжээ, Сүү тараг, Эрүүл элэг, Эрүүлшүд, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих, Харшлын эсрэг хамтдаа зэрэг орон нутгийн бодлого хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжих, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд нийт 27,174 хүн оролцсон байна. Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ “Хавдрын эсрэг арга хэмжээ”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих, Харшлын эсрэг хамтдаа зэрэг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг 90.0%-тай хэрэгжүүлж, тайлагнаж ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад 2%-аар нэмэгдсэн байна. Нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр аймгийн 43 спорт заал, 2 усан бассейн, 5 фитнес клуб, 4 иог, бясалгалын төв, 2 бүжгийн клуб зэрэг нийт 56 байгууллага аж ахуй нэгжтэй хамтран хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжин ажилсан.</p>	
<p><b>Арга хэмжээ 1.2.12. “Сүү тараг”</b> хөтөлбөрийг хэрэгжүүлж хүүхдийн жингийн алдагдал, эрсдэл бодисын дутагдлыг бууруулна</p>	<p>Орон нутгийн төсөв 225.0 сая төгрөг</p>	<p>Зорилтод бүлгийн хүүхдийн хамралтын хувь</p>	<p>80%</p>	<p>85%</p>	<p>2024 онд сүү тараг хөтөлбөрт хамрагдвал зохих 6-12 сартай 5017 хүүхэд, 2 хүртэл насны ихэр 218 хүүхэд, 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1,392 хүүхэд, жингийн алдагдалтай, өсөлтийн хоцрогдолтой 816 хүүхэд буюу нийт давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 7443 хүүхдийг хамруулан ажилласан. “Сүү тараг” хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоогоор санхүүжилтийг харьяа сумын Засаг даргын Тамгын газарт эрхийг шилжүүлэн нийт 193,518,000 сая төгрөг санхүүжилтийг олгож ажилласан. Тавдугаар сараас сүү тараг хөтөлбөрийн үйл ажиллагааг эхлүүлж 14 Сумын ЭМТ-ийн хамрагдах ёстой 3435 хүүхэд 100 хувь амжилттай хамрагдсан. Нэг хүүхдэд сард ноогдох</p>	<p>100</p>

						санхүүжилт 26,000 төгрөгөөр тогтоож, сард 4 удаа олгож, нэг удаагийн авалтаар 600 гр тараг, 500 гр сүү эцэг эх, асран хамгаалагч нарт хуваарийн дагуу олгон ажилласан. Даланзадгад сумын “Сүү тараг” хөтөлбөр худалдан авах ажиллагаатай холбоотойгоор 8 дугаар сарын 1-нд эхэлсэн бөгөөд 12 дугаар сарын 15 хүртэл Шимбилэг, Өнө-орших, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвийн харьяаны хүүхдүүдэд сүү таргыг олгож байна. Даланзадгад сумын хэмжээнд нийт 4008 хүүхэд 100 хувьтай хамрагдаж байна. Сүү тараг хөтөлбөрийн хүрээнд дараах Хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн зуны сувиллын арга хэмжээг 6 суманд зохион байгуулан нийт 329 хүүхдийг сувилалд хамруулан, эрүүлжүүлсэн. Сүү тараг хөтөлбөр болон зуны сувилалд хамрагдсан хүүхдүүд жингийн алдагдалтай, өсөлт хоцрогдолтой хүүхэд дунджаар 1,1-1,3 кг жин, 1,5-3см өндөр нэмэгдсэнээр хөтөлбөрт удаан хугацаанд хамрагдах нь хүүхдийн биеийн өсөлт хөгжилд илүү сайнаар нөлөөлж байгааг баталж байна.	
<b>Арга хэмжээ 1.2.13.</b> Өсвөр үе, залуучуудын эрүүл мэндэд анхаарч, охидын жирэмслэлт, төрөлт, үр хөндөлтийг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, Өсвөр үеийн клиникийг удирдлага арга зүйгээр хангаж, дэмжлэг хяналт хийж ажиллах	Төсөл хөтөлбөр	Тусламж үйлчилгээ үзүүлсэн өсвөр үеийнхний тоо	850.0	1000.0	Хүүхэд хөгжил хамгааллын жилийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор Жаргалтай ирээдүй аяны арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Аяны хүрээнд насны онцлогт тохирсон үзлэг оношилгоо, шинжилгээ багцыг боловсруулан 4,6,8,10,12,14,16 насны 11204 хүүхдийг үзлэгт хамруулахаар төлөвлөн хамрагдалт 51,1%-тай хэрэгжиж байна.  Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээг 18 эрүүл мэндийн байгууллагууд 65 удаа зохион байгуулж нийт 3520 өсвөр үе, сурагчдыг хамруулж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэн ажилласан байна. 2024 онд сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр онош тавигдаж, сэтгэл заслын үйлчилгээ авсан өсвөр үеийн 9 тохиолдол байна. Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн болон НҮЭМ-ийн талаар үе тэнгийн 50 сургагч багш бэлтгэх	92	

					<p>сургалтыг зохион байгуулж, үе тэнгийн боловсрол олгох боломж нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>2024-2025 оны хичээлийн жилд нийт 22 сургууль дээр эрүүл мэндийн клубийг байгуулан, эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.</p> <p>22 сургуулийн 65-70% нь эрүүл мэндийн клуб үйл ажиллагаа явуулж, үе тэнгийн эрүүл мэндийн боловсрол олгох арга хэмжээг гүйцэтгэж байна.</p> <p>Өмнөговь аймгийн ЗДТГ, НБХ, ЭМГ, хамтран аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 20 сурагчийг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн. Бэлтгэгдсэн өсвөр үеийн сургагч багш нар, ЭМГ-тай хамтран зуны амралтаар зуслангийн 3 ээлжид очиж сургалт зохион байгуулан 200 гаруй хүүхдэд мэдлэг, мэдээллээр түгээн ажилласан.</p> <p>Өмнөговь аймгийн хэмжээнд 366 өсвөр насны сурагчдад тамхины хор нөлөөний талаар асуумж авч сургалтын өмнөх мэдлэг 25% байсан бол сургалтын дараах асуумжаар сурагчдын мэдлэг ойлголт 85% болж нэмэгдсэн ба БЗДХ, болон ЖСА хэрэглээ сэдвээр сургалт зохион байгуулснаар сургалтын өмнөх мэдлэг 25% байсан бол сургалтын дараах асуулгаар 90% болж өссөн байна. Аймгийн хэмжээнд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх 4 клиник тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. 2024 онд нийт 2253 өсвөр үеийнхэнд тусламж үйлчилгээг хүргэж, үүнээс зөвлөгөө мэдээллийг 1500, эмчилгээ оношилгоонд 780, лавлагаа шатлалд шилжүүлсэн 53 тохиолдлыг, сэтгэлзүйчид хандсан 621 тохиолдолд тус тус тусламж үйлчилгээг хүргэн ажилласан байна.</p> <p>Аймгийн хэмжээнд Өсвөр үеийн клиникийн тоо- 4</p> <p>Үйлчлүүлсэн өсвөр үеийн тоо – 2253</p> <p>Зөвлөгөө – 1500</p>	
--	--	--	--	--	--	--

						Эмчилгээ – 780 2-р шатлалд шилжүүлсэн – 53 Сэтгэл зүйчид хандсан – 621	
<b>Арга хэмжээ 1.2.14.</b> Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд оюутан залуучуудыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	Төсөл хөтөлбөр	Үзлэгт хамрагдсан оюутан залуусын тоо	267	500	Аймгийн хэмжээнд оюутны эрүүл мэндийн дэмжих, “Эерэг хандлага – эрүүл оюутан” урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, сургалт, нөлөөллийн цогц арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Аяны хүрээнд оюутан залуусаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахыг уриалж, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр төлөвлөгөө боловсруулан өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ-тэй хамтран дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаа. Политехникийн коллежийн 244 оюутан, суралцагч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 12 сэдвээр үе шаттайгаар зохион байгуулсан. ШУТИС-н харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургуулийн 152 оюутан, суралцагчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн арга хэмжээ, 72 оюутан, залууст урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, шинжилгээний арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Аймгийн орон нутагтаа суралцаж буй оюутан, суралцагчдыг эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд 41,3%-ийг хамруулсан байна.	95	
<b>Арга хэмжээ 1.2.15</b> БОЭТ, СЭМТ-ийн эмнэлзүй хоол эмчилгээний тогооч нарыг мэдлэг арга зүйгээр ханган эмчилгээний хоолны стандартыг сайжруулан хэрэгжилтэд хамтарч ажиллах	Орон нутгийн төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	70%	80%	Хоол зүй монголын нийгэмлэг ТББ-тай хамтран аймгийн БОЭТ, СЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын эмнэлзүйн хоолны тогооч нарт ЭМС-ын 2023 оны А/440 тушаалыг мөрдөж ажиллахтай холбоотойгоор 3 өдрийн 28 цагийн эмнэл зүйн хоолны онол, дадлага, хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 14 сумын-13 тогооч, БОЭТ-3 тогооч, хувийн хэвшлийн эмнэлгийн 6 тогооч хамрагдсан.  Эрүүл мэндийн байгууллагын нийт тогооч нарын 85% нь уг сургалтад амжилттай хамрагдсан. Сургалтад хамрагдсан тогооч нарын 36% нь өмнө нь мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байсан. Сургалтаар хоол, шим тэжээлийн тухай	100	

						<p>үндсэн ойлголт, Хоолны илчлэг, шимт бодисын тооцоо хийх аргагүй, эмнэл зүйн хоол, шим тэжээлийн онцлог болон өвчтөний биед шаардлагатай илчлэг, шимт бодисыг хэрхэн хоолноос хангах талаар онол, дадлага хосолсон хичээлүүд, эмнэл зүйн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тогооч нарт тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнийг хэрхэн шийдвэрлэх агуулгын хүрээнд мэдээлэл хүргэсэн.Эмнэл зүйн тогооч нар сургалтад хамрагдсанаар эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч нарт зориулсан 7 өдрийн хоолны цэсэд 1, 2-р хоол, зууш, шингэн зүйлсийн нэр төрлийн олшруулах, илчлэг, шимт бодисын найрлагыг зөв бодож тооцоолох, эмнэл зүйн хоолны цэс нь 14 хоногт давтагдахгүй хоолны цэсээ зөв төлөвлөж сурсан. Мөн ажлын байр нь дээрх арга барил, ур чадвар сайжирсан. Үр дүнд нь эрүүл мэндийн байгууллагууд хэвтэн эмчлүүлэгчдээ долоо хоногт нэг удаа иж бүрдэл эмнэл зүйн хоолыг нэвтрүүлэн үйлчилж байна. Ингэснээр хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайнаар нөлөөлж байна.</p> <p>АНУ-ын Эрүүл зөв хооллолтын холбооны эмч АНУ-ын Иллинойс их сургуулийн доктор, профессор Ханна Миттер хамтран чихрийн шижин өвчний үеийн хооллолт, эмчилгээ оношилгооны чиглэлээр сургалтыг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж 100 гаруй ард иргэд, эрүүл мэндийн салбарын 40 гаруй эмч, мэргэжилтэн хамрагдсан.</p>	
<p><b>Арга хэмжээ 1.2.16.</b> Иргэдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэх</p>	<p>Улсын төсөв Төсөл хөтөлбөр</p>	<p>Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо</p>	2200	3000	<p>Аймгийн хэмжээнд сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг иргэн бүрд 2 дугаар аяны арга хэмжээг зохион байгуулж нийт 1200 гаруй хүнд хүрч сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, цахим орчинд БОЭТ, 3 ӨЭМТ, 14 СЭМТ-үүд “Дэлгэцийн донтолт”, “Стресс менежмент”, “Нойргүйдэл”, “Сэтгэл гутрал”, “Сэтгэл түгшилт”, “Ганцаардал” гэх мэт нийт 12 сэдвийн хүрээнд 36 удаагийн давтамжтай сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах зөвлөгөө, зөвлөмжийг хүргэсэн мэдээллийг цахим орчинд байрлуулан 20.000 гаруй хандалтыг авсан байна. Мөн электрон тамхи, янжуур тамхины хэрэглээний хор хөнөөл, архины хэрэглээ тархинд хэрхэн гэмтэл учруулдаг талаарх</p>	100	

						<p>сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг ЕБС-ын 2762 сурагчдад, 2157 иргэнд хүргэсэн байна. Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвд мэргэжлийн сэтгэл зүйч орон тоогоор ажилсанаар 30 иргэн, өсвөр насны 11 хүүхдэд 100 гаруй удаагийн давтамжтайгаар ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг өгсөн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн дотрын тасаг, хавдрын эмчилгээнд орж байгаа үйлчлүүлэгч иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, долоо хоног бүрийн 3 дахь өдөр хөгжим заслын эмчилгээг хийж байна. Аймгийн хэмжээнд 0-18 насны хавдраар оношлогдсон болон хүнд өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, ар гэрийнхэн нийт 70 хүнд Art Therapy-Урлагийн сэтгэл заслаар дамжуулан нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйч нар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх 2 төвөөр дамжуулан ганцаарчилсан зөвлөгөөнд 2975 иргэн, бүлгийн зөвлөгөөнд 972 иргэн, нийт 3947 иргэн хамруулсан. Өмнөговь аймгийн ИТХ-н шийдвэрээр “Итгэлтэй амьдрал төв” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрыг 10 сард байгуулан, байнгын ашиглалтад оруулсан. Тус төв нь 12 дугаар сарын байдлаар архи, согтууруулах ундааны хамраалтай 20 иргэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргээд байна.</p> <p>тусламж үйлчилгээ авсан хүний тоо-3947</p>	
<p><b>Арга хэмжээ 1.2.17.</b> Ахмадуудын дунд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх</p>	Улсын төсөв	Зорилтот бүлгийн хамрагдсан хувь	40	50	<p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ахмадын кабинетаар 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт үзлэг 6791 үүнээс өвчний учир 5850, зорилтот бүлгийн идэвхтэй хяналтад 941 ахмад настанд үйлчилгээ хүргэсэн. Мөн 176 ахмад настанд уламжлалт, нөхөн сэргээх эмчилгээнд хамруулаад байна. "Дэвшилтэт-Даланзадгад" хөтөлбөрийн хүрээнд Улсын "Нэгдүгээр төв эмнэлэг"-тэй хамтран төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношилгоонд 300 гаруй ахмад настнуудыг хамруулсан. Мөн 14 сумын ЭМТ, 3 өрхийн ЭМТ-үүд байнгын асаргаа сувилгаатай ахмадын тоог гаргаж, гэрээр 143 ахмадад гэрийн асаргаа сувилгаа, эмчилгээ хийж гүйцэтгэж байна. Аймгийн ахмадын сувилалд 2024 онд 6 удаагийн ээлжээр 320 ахмад настан хамрагдан сувилуулсан. “Ар үр”</p>	100	

						сувилалд 15 сумын 1098 ахмад настан үйлчилгээнд төлбөрөө хөнгөлөлттэй үнээр төлөн үйлчлүүлсэн байна. Аймгийн хэмжээнд Даланзадгад сумын 3 өрхийн эрүүл мэндийн төв, 14 сумын эрүүл мэндийн төвүүдийн дархлаажуулалтын кабинетаараа дамжуулан 65-аас дээш насны 596 ахмадыг томуугийн сайн дурын дархлаажуулалтад, Даланзадгад сумын 10 багийн 85 ахмадыг шүдний үзлэгт хамруулж, тусламж үйлчилгээ үзүүлсэн.  Зорилтот бүлгийн ахмадын хамрагдалт-70 хувь	
<b>Арга хэмжээ 1.2.18.</b> Эрүүл мэндийг дэмжигч сум, байгууллага, өрх, иргэний тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг идэвхжүүлэх, шалгуур хангасан иргэн аж ахуй нэгж байгууллага, сумыг шалгаруулж урамшуулах	Орон нутгийн төсөв	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	13	15	Эрүүл мэндийг дэмжигч сум, байгууллага, өрх, иргэний тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр 18 эрүүл мэндийн байгууллагуудыг удирдлага арга зүйгээр ханган ажиллаа. Эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг нэмэгдүүлэх зорилгоор 50 гаруй байгууллагад холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 472 дугаар тушаалын дагуу шалгуур үзүүлэлт хангасан Эрүүл аюулгүй орчин, эрүүл мэндийг дэмжих зан үйлийг сурталчлах, олон нийтэд хэвшүүлэх, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, элдэв өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажилладаг эрүүл мэндийн дэмжигч 13 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл мэндийг дэмжигч сумыг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд сүрьеэгүй сум арга хэмжээг Ноён суманд хэрэгжүүлж байна. Зорилтод хөтөлбөрийн хүрээнд 2091 хүнд сүрьеэгийн илрүүлэг үзлэг, асуумжийг авч ажилласан байна. Үүнээс цэрний шинжилгээнд 54 сорьц ирүүлж 1 хүн буюу 1,8% сүрьеэ илэрч шаардлагатай тусламж үйлчилгээ зөвлөгөө зөвлөмжийг хүргэсэн байна.	100	
<b>Арга хэмжээ 1.2.19.</b> Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт,	Улсын төсөв	МСС-д хамрагдсан байгууллагын тоо,	60 7000 40	70 7500 50	Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, мэдээлэл сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 93%-ийн биелэлттэй, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна. Аймгийн 18 эрүүл мэндийн байгууллага ард иргэдэд эрүүл мэндийн	100	



<p>сурталчилгааг эрчимжүүлж, бусад салбарын хамтын оролцоог уялдуулан чиглүүлэх</p>		<p>иргэдийн тоо, хамтран ажилласан байгууллагын тоо</p>			<p>боловсрол олгох сургалт нөлөөллийн 90 гаруй арга хэмжээг зохион байгуулж 17674 иргэнийг хамруулсан. Бусад салбарын хамтын ажиллагааны хүрээнд нийт 82 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудын фейсбүүк хуудсаар дамжуулан 1030 төрлийн мэдээлэл, нийтлэлийг хүргэж давхардсан тоогоор 150,518 хүний хандалт авсан байна. 2024 онд Цахим сүлжээ, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор мэргэжлийн сэтгүүлчтэй гэрээ байгуулан ажилласан.</p> <p>МСС-д хамрагдсан байгууллагын тоо-40</p> <p>МСС хамрагдсан иргэдийн тоо-17674</p> <p>Хамтран ажилласан байгууллага-82</p>	
<p><b>Арга хэмжээ 1.2.20.</b> Хүн амын дунд өглөөний гүйлт, алхалт оройны алхалт, дугай унах зэрэг нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулан, нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хувийн хөрөнгө оруулалттай спорт, бялдаржуулах клуб, нийтийн бүжиг зэрэг нэгжүүдийн дунд эрүүл зөв амьдралын хэв маягийг ард иргэдэд хэвшүүлэх болзолт уралдааныг зохион байгуулах.</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>Хамтран ажилласан төрийн бус байгууллагын тоо</p> <p>Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо</p>	<p>50</p> <p>3000</p>	<p>65</p> <p>4000</p>	<p>Аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг дээрээ хүүхэд болон багш ажилчид өдөр бүр тогтсон хугацаанд хийх боломжтой брэнд дасгал хөдөлгөөн, хэмнэлийг бий болгох зорилгоор “Завсарлагааны хэмнэл” болзолт уралдааны арга хэмжээг 5 сарын хугацаанд зохион байгуулж ерөнхий боловсролын 22 сургууль, 31 цэцэрлэгийн нийт 3000 орчим албан хаагчид, сурагчид идэвхтэй оролцсон. Хүн амын дунд нийтийн биеийн тамирыг дэмжих, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжсэн аян, арга хэмжээг нийт 6 удаа зохион байгуулж нийт 69 байгууллага, 4743 иргэнийг хамруулан ажилласан. 2024 оны өглөөний дасгал хөдөлгөөний дэмжсэн гүйлт, алхалтын арга хэмжээнд нийт 250 иргэд идэвхтэй тогтмол хамрагдсан байна. Нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр аймгийн 43 спорт заал, 2 усан бассейн, 5 фитнес клуб, 4 иог, бясалгалын төв, 2 бүжгийн клуб зэрэг нийт 56 байгууллага аж ахуй нэгжтэй хамтран хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжин ажилсан.</p>	<p>100</p>

						Хамтран ажилласан төрийн бус байгууллагын тоо-69 Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо-4743	
	<p><b>Арга хэмжээ 1.2.21</b></p> <p>Сум өрхийн эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжиж буй анхан шатны тусламж, үйлчилгээний мобайл технологийн хэрэглээг өргөжүүлнэ.</p>	Төсөл хөтөлбөр	Нийт ашиглагдаж буй 17 эрүүл мэндийн байгууллагын мобайл технологийн ашиглалт, хэрэглээний хувь	90	100	<p>Анхан шатны тусламж үйлчилгээнд өргөн хэрэглэгдэж буй тус тоног төхөөрөмжийг урьдчилан сэргийлэх үзлэг, сэргийлж болох нас баралтыг бууруулах төлөвлөгөөт, болон төлөвлөгөөт бус арга хэмжээтэй уялдуулан ашиглалтыг сайжруулж байна. Өнгөрсөн оны тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгаанд үндэслэн ЭМЯ-аас 4 сумын ЭМТ-д шинээр мобайл технологийн тоног төхөөрөмжийг дахин нийлүүлж ашиглалтын болон эмнэлзүйн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээ болон орон нутгийн дэмжлэгээр зохион байгуулагдаж буй “Явуулын үзлэг”, “Жаргалтай хүүхэд”, “Малчдын үзлэг” зэрэг иргэдэд хүрэх үйлчилгээний үеэр явуулаар ажиллах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Мөн ДЭМБ-ын санхүүжилтээр ЭМЯ-аас 59 багт 5 төрлийн багаж, 5 төрлийн түргэвчилсэн шинжилгээний тестээс бүрдсэн “Багийн эмчийн багц”-ийг нийлүүлсэн. Явуулаар гэрийн эргэлтийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай мобайл болон багийн эмчийн багцыг 17 ЭМТ-ийн 81 эмч мэргэжилтэн 100 хувь ашиглаж байна.</p>	100
	<p><b>Арга хэмжээ 1.2.22</b></p> <p>Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, хяналтын үзлэгийг өргөжүүлэн тусламж, үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.</p>	Төсөл хөтөлбөр	Гэрийн эргэлт, идэвхтэй хяналтын хувь	80	90	<p>Аймгийн хэмжээнд нийт 362.752 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 96284, идэвхтэй хяналтын үзлэг 39560 тохиолдол бүртгэгдсэн байна. Анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд хийгдсэн гэрийн эргэлт, идэвхтэй хяналтын үзлэг 8342 буюу сум, өрхийн ЭМТ-ийн урьдчилан сэргийлэх үзлэгийн 30 хувийг эзэлж байна.</p> <p>Анхан шатны тусламж үйлчилгээ авсан иргэдийн хэрэгцээнд тулгуурласан судалгаагаар:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төрсөн эх нярайн гэрийн эргэлтийн тусламж үйлчилгээ,</li> <li>- Зорилтод бүлгийн өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй тусгай хэрэгцээт иргэд гэрээр үзүүлэх</li> </ul>	100

						<p>тусламж үйлчилгээг илүү сонгон үйлчлүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээнд хэвтэн эмчлүүлэх эмчилгээг сонгон үйлчлүүлэх,</li> <li>- Сэргээн засах тусламж үйлчилгээнд өдрөөр хамрагдах нь илүү байна.</li> </ul> <p>Нийт идэвхтэй хяналт, гэрийн эргэлтийн 66%-ийг анхан шатны сум өрхийн ЭМТ-д хамруулсан ба энэ нь өнгөрсөн оноос 4%-аар нэмэгдсэн байна. Иргэд лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нь харьцангуй багасаж анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэнийг илэрхийлж байна.</p>	
<b>Зорилт 1.3. Уур амьсгалын өөрчлөлт, орчин болон хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.</b>							
1.3	<p><b>Арга хэмжээ 1.3.1.</b> Орчны эрүүл мэндийг хангах, агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол, хөл ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор <b>“Харшлын эсрэг хөтөлбөр”</b>-ийг хэрэгжүүлж, хүн амын эрүүл мэндийг хамгаална.</p>	Орон нутгийн төсөв 50.0 сая төгрөг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	92.0	95.0	<p>Харшлын эсрэг” хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхэд шаардагдах 50,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж ажиллаж байна. 3 зорилтын хүрээнд 17 үйл ажиллагаа хийгдэхээр төлөвлөгдсөнөөс 16 үйл ажиллагааг зохион байгуулж Хөтөлбөрийн Хэрэгжилт 94,1 хувьтай. Аймгийн хэмжээнд 22 эрүүл мэндийн байгууллагыг унд ахуйн усны эрүүл зүйн шинжилгээнд хамруулан шинжилгээгээр ундны усны MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. Арьс харшлын кабинетэд арьснаас мөөгөнцөр илрүүлэх, Иммунаглобулин Е үзэх шинжилгээг БОЭТ-д нэвтрүүлэхээр сорьц авах материал болон харшлын сорил тодорхойлох материалуудыг татан авч 11,055,000 төгрөгийн зарцуулалт хийгдсэн. Энэ онд нийт 146 иргэнд харшлын сорил тавигдсан. Даланзадгад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 86 аж ахуй нэгж байгууллагын ажилтан албан хаагч, 10 багийн нийт өрхийг хамруулан “Шарилжгүй Өмнөговь, харшлын эсрэг хамтдаа” аяныг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж хадаж тайрах арга аргачлалыг албан тоотоор байгууллагуудад хүргэн 12000 мкв 10 тн шарилж хөл газрын ургамал хадаж тайрч түүсэн. Цэвэрлэгээний улсын аяны хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-30-ны өдрүүдэд 14 сумын ЭМТ, 3</p>	94,1

					<p>ерхийн эмнэлэг, БОЭТ-г хамруулан нийт эрүүл мэндийн байгууллагууд хог хаягдлыг цэвэрлэх, эзэмшлийн хашаа, талбайд хуримтлагдсан хог хаягдлыг ачиж, тээвэрлэн хоггүй орчныг бүрдүүлэх, ажлыг зохион байгуулж 19 эрүүл мэндийн байгууллага 15000м 9500 кг хог ургамлыг түүж цэвэрлэсэн. Иргэдэд ургамлын гаралтай харшил, харшлын сорил гэж юу вэ? Антибиотикийн зохистой хэрэглээ гэж юу вэ? Сэдвийн хүрээнд урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж, 1500 гарын авлага бэлтгэж иргэдэд хүргэсэн. 14 СЭМТ, 3 ӨЭМТ 1555 иргэдэд харшлын чиглэлээр гарын авлагыг бэлтгэн хүргэж 2665 иргэнд танхимын сургалт зохион байгуулсан. Иргэдийн дунд амьтан болон ургамлын гаралтай харшил төрүүлэгч, химийн буюу хавьтал харшлын дерматит сэдвээр Арьс харшлын эмч Б.Үүрийнтуяатай хамтран 3 удаагийн Подкаст бэлтгэн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж 12000 гаруй иргэнээс хандалт авсан. 14 СЭМТ, 3 ӨЭМТ 88 төрлийн шторк хэвлэлийг цахимд байршуулан 18000 иргэнээс хандалт авсан. "Арьс харшлын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх нь" сэдэвт сургалтыг АШУҮИС, Арьсны өвчин судлалын үндэсний төвтэй хамтран БОЭТ, СЭМТ, ӨЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд дунд зохион байгуулсан. Сургалтаар нийт 23 эмч мэргэжилтэн танхимын сургалтад хамрагдаж, Эмийн шалтгаанд хордлого харшил, арьсны эмгэгүүд, Зайн оношилгоо буюу Derma аппилкейшны ашиглалт, сайжруулалтын мэдлэг олгож шинээр орсон эмч нарт ашиглалтын талаар заавар, дадлага ажлыг хийлгүүлж зайн оношилгоо хийх ур чадвар сайжирсан. 17 эрүүл мэндийн байгууллагын 204 эмч мэргэжилтэнд хамрагдсан сургалтын хүрээнд мэдлэг олгох сургалт зохион байгуулсан. Арьс харшлын өвчнийг оношлох багаж тоног төхөөрөмж- дермаскопи, дижитал риноскопи зэрэг багажаар арьс харшлын кабинетыг хангасан. Харшлын сорил тодорхойлох нөхцөл боломжоор хангагдан оношилгоо сайжирснаар урьдчилан сэргийлэлт мөн сайжирсан. Анхан шатны эмнэлгийн эмч мэргэжилтнүүд арьс харшлын өвчнийг зайнаас ялган оношлох чадвартай болж энэ онд нийт 46 тохиолдлыг</p>	
--	--	--	--	--	--	--

						бүртгэн зайнаас оношилж иргэдэд чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлсэн. 2023 онд Арьс харшлын нийт 6456 үзлэг хийгдсэн. 2024 онд 8244 үзлэг хийгдэн өмнөх оноос 1788 үзлэгээр өссөн байна.	
<b>Арга хэмжээ 1.3.2.</b> Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилтыг сайжруулах	Байгуулл агын төсөв	Эрүүл мэндийн байгууллагын тоо	12	19	Аймгийн хэмжээнд 2024 онд нийт 20 эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэхийг хяналтын хуудсаар үнэлсэн. СЭМТ-14, БОЭТ-1, ЗӨСТ-1, Говь дент шүдний төв-1, ӨЭМТ-3 үнэллээ. Үнэлгээгээр шаардлага хангасан байгууллага 3, сайжруулах шаардлагатай байгууллага 10, шаардлага хангаагүй байгууллага 7 байна. Үнэлгээ хийлгэсэн байгууллагуудад хугацаатай зөвлөмж хүргүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдүүлэн ажиллаж байна.  2024 онд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Манлай, Номгон, Хүрмэн сумын эрүүл мэндийн төвийг шинээр барьж Цогт-Овоо өргөтгөлийн засвар, ашиглалтад оруулснаар иргэдэд ээлтэй орчинд тусламж үйлчилгээ үзүүлэх, эмч эмнэлгийн ажилтнууд ая тухтай орчинд ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан. Сонсголын бэрхшээлтэй иргэдэд тусламж үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай, ээлтэй хүргэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад дохионы хэлтэй эмч, сувилагч бэлтгэх ажлыг аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран зохион байгуулж БОЭТ-болон ӨЭМТөвийн 8 эмч, сувилагчийг мэргэжлийн сургалтад хамруулан бэлтгэсэн. Нийт ЭМБ-д нэн түрүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан хонх, тэмдэглэгээ, барель үсэг байршуулах, ХБИ-тэй харилцах ажилтанг томилж ажиллах шаардлагатай байна.	100	
<b>Зорилт 1.4. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж буй эмч, мэргэжилтнийг чадавхжуулах, мэргэшүүлэх</b>							
<b>Арга хэмжээ 1.4.1.</b> Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр судалгааны ажил	Байгуулл агын төсөв	Хийгдсэн судалгаа,	3	3	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хүн амын өвчлөл, тархалтыг тогтоох оновчтой хариу арга хэмжээг авч ажиллах хүрээнд 4 төрлийн судалгаа шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс Өмнөговь аймгийн Даланзадгад	100	

	<p>зохион байгуулж, ажлын үр дүн, дүгнэлтийг улсын хэмжээний сэтгүүл, гарын авлагад хэвлүүлж олон нийтэд хүргэх.</p>		<p>шинжилгээний ажлын тоо</p>			<p>сумын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч папилома вирусийн тархалтыг 100 эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулсан. Судалгаанд 30-аас дээш насны 100 эмэгтэй оролцсон ба эмэгтэйчүүдийн 41%-д нь папилома вирусийн хэв шинж илэрсэн ба үүнээс өндөр эрсдэлтэй 16 төрөл, бага эрсдэлтэй 4 төрлийн хэв шинжүүд илэрсэн байна. Мөн умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч хүний папилома вирусийн өндөр эрсдэлтэй 16 дугаар хэв шинж 9%-д илэрсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн 6-16 настай хүүхдүүдийг 12 төрлийн үзүүлэлт, 2 төрлийн асуумж судалгаагаар 22 сургуулийн 10000 гаруй хүүхдийг судалгаа шинжилгээнд хамруулахаас нийт судалгаанд оролцогчдын 50%-ийг хамруулж дата мэдээллийг нэгтгэж байна. Судалгааны үр дүнд 6-16 настай хүүхдүүдийн өвчлөлийн тархалт, эрдсийн түвшин, бөөс, цагаан хорхой, илүүдэл жин, зэрэг чиглэлээр судалгаа шинжилгээний мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийгдэнэ. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын үсчин гоо сайхны үйл ажиллагаа эрхэлдэг 20 аж ахуй нэгжээс 2 төрлийн эмгэг төрүүлэгч илрүүлэх судалгаа шинжилгээг 10 төрлийн багаж хэрэгсэл, бусад цэгүүдээс 200 арчдас шинжилгээ судалгааг авсан. Үүнээс стафилококк (<i>Staphylococcus aureus</i>) эмгэг төрөгч 4,5%(9), <i>E.coli</i> эмгэг төрөгч 1%(2) илэрсэн байна. Стафилококк (<i>Staphylococcus aureus</i>) эмгэг төрөгч илэрсний 33,3%(3) нь хумсны маникюрын хэрэгслээс, 44,4%(4) үсчин гоо сайханчдын ажлын хувцас, хормогч, нөмрөгт илэрсэн байна. Өмнөговь аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 6-16 насны 16197 хүүхдээс стрептококкийн халдварын тархалтыг тогтоох судалгааны ажлын хүрээнд судалгаанд 14513 хүүхдийг хамруулж 51,2%(7430)-ийг эрэгтэй хүүхэд эзэлж байна. Судалгаанд оролцогчдын 2.9%(418) нь стрептококкийн халдвар эерэг үзүүлэлтэй байна.</p> <p>Судалгааны нэг агшингийн загвар ашиглан дээрх 4 төрлийн судалгааг шинжилгээний ажлыг аймаг орон нутгийн түвшинд зохион байгуулан ажилласан. Судалгаа</p>	
--	--	--	-------------------------------	--	--	---	--

						шинжилгээний үйл ажиллагаанд 19613 иргэн, 42 объект хамрагдсан байна. Хийгдсэн судалгааны тоо-4	
	<b>Арга хэмжээ 1.4.2.</b> Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж буй эмч, мэргэжилтнийг чадавхжуулах	Орон нутгийн төсөв	Сургалтад хамрагдсан хүний тоо	17	25	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж буй эмч, мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг 1 дүгээр улиралд зохион байгуулж 17 эрүүл мэндийн байгууллагын НЭМ-ийн 17 эмч, мэргэжилтнийг хамруулсан.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн төвийн 8 мэргэжилтнийг 15 удаагийн сургалт, зөвлөгөөнд, 2 мэргэжилтэнг урт хугацааны төрөлжсөн мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулж чадавхжуулсан.</p> <p>Анхан шатны 13 эрүүл мэндийн байгууллагад нийгмийн эрүүл мэндийн ажилтан орон тоогоор ажиллаж байна. Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 6 эмч, эмнэлгийн ажилтныг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр Сингапур, Малайз улсын нийгмийн эрүүл мэндийн төв, эрүүл мэндийн байгууллагатай танилцах, туршлага судлах, мэргэжлийн гэрчилгээ олгох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж, хамтран ажиллах байгууллагатай гэрээ байгуулсан.</p> <p>Сургалтад хамрагдсан хүний тоо-31</p>	100
<b>Стратегийн зорилго 2. Хүн амд зонхилон тохиолдож буй өвчлөл, эндэгдлийг бууруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, хүртээмжийг сайжруулах</b>							
<b>Зорилт 2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах</b>							
	<b>Арга хэмжээ 2.1.1</b> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS	Улсын төсөв	Стандарт хангалтын дундаж хувь	60	80	MNS 7014:2023 “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” стандартыг аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх байгууллагын хэмжээнд сурталчлах, байгууллагын түвшинд хэрэгжилтийг зохион байгуулах зорилгоор сургалтын удирдамж гарган, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн ЭМТ-үүд нийт 10 эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн 3 эрүүл	100

	7014:2023 стандартыг эрүүл мэндийн байгууллага бүрт хэвшүүлэх, сурталчлах арга хэмжээ хэрэгжүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах					<p>мэндийн байгууллага нийт 13 байгууллагын давхардсан тоогоор 120 эмч, эмнэлгийн ажилчдад сургалтыг орсон.</p> <p>Мөн эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартын хэрэгжилтийг үнэлэх 3 бүлэг, 55 шалгуур үзүүлэлтээр, 13 эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Стандарт хэрэгжилтийн 95 хувьтай байна. Стандартыг сурталчлах, үйл ажиллагаанд хэвшүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт 100%.</p>	
2.1	<p><b>Арга хэмжээ 2.1.2</b> Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд тогтмол хяналт тавин ажиллах</p>	Улсын төсөв	Гэрээний хэрэгжилтийн хувь	91	96	<p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 2024 оны гүйцэтгэлийн гэрээг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 дугаар тушаалыг үндэслэн, аймгийн Засаг даргын А/551 дүгээр захирамжаар батлуулсан “Үнэлгээний баг” хагас жил, бүтэн жилээр үнэлдэг. Бүтэн жилийн гэрээний хэрэгжилтийг 2025 оны 01 сарын 05-ны өдрийн дотор үнэлэх бөгөөд явцын үнэлгээгээр 94 хувьтай байна.. Хагас жилийн гэрээний хэрэгжилтийн үнэлгээгээр 3 Өрхийн эрүүл мэндийн төв дунджаар 88.4 хувь “ХАНГАЛТТАЙ” үнэлэгдсэн. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь стандартын шаардлагад нийцсэн барилга байгууламжтай, багаж тоног төхөөрөмжийн стандарт хангалт 76 хувь, хүний нөөцийн хангалт 94.6 хувь бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийг сургаж чадавхжуулах ажлын хүрээнд хүүхдийн 2 эмч Япон улсад зохион байгуулагдсан Олон улсын 6-р хуралд оролцсон. Сэргээн засах, хүүхдийн эмч, сувилагч БНСУ-д эмнэлзүйн богино хугацааны сургалтад хамрагдсан.</p> <p>Өрхийн ЭМТ-ийн удирдлагууд “Өрхийн холбоо”-ны хуралд хамрагдаж, анхан шат, ялангуяа ӨЭМТ-д тулгамдсан асуудлуудаа танилцуулан, цаашдын хөгжилд анхааран ажиллаж байна.</p>	94
	<b>Арга хэмжээ 2.1.3</b> Орон нутагт түр оршин суугч, явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж,	Улсын төсөв	Хөдөлгөөнт хүн амд үзүүлсэн тусламж	7490	8000	Эрүүл мэндийн байгууллагууд харьяалал харгалзахгүй эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг тогтмол үзүүлж байна. Сум өрхийн эрүүл мэндийн төвд хөдөлгөөнт хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг 11.337 иргэнд хүргэсэн нь өмнөх оноос 3847 нэмэгдсэн байна.	100



<p>үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэх</p>		<p>үйлчилгээний тоо</p>			<p>11 сарын байдлаар халдварт бус өвчлөл шинээр 89728 бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9711 тохиолдлоор буурсан байна. Нийт өвчлөлийн 70,8% нь шинэ өвчлөл байна.</p> <p>2024 онд орон нутгийн дэмжлэгээр тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн онцлог арга хэмжээний хүрээнд УНТЭ-тэй хамтран БОЭТ-д шинээр нэвтрүүлж буй ангиографийн оношилгоо, эмчилгээнд сум, өрхөөс зүрх судасны эмгэгтэй 91 иргэнийг шат дараатай хамруулж, тусламж үйлчилгээг үзүүлсэн.</p> <p>Аймгаас жил бүр зохион байгуулагддаг “Явуулын үзлэг” арга хэмжээг энэ жил тухайн сум орон нутагт шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн эмчийг сонгон авч ажиллуулсан нь илүү үр дүнтэй арга хэмжээ болж үзлэгээр 3,339 иргэн хамрагдаж, үүнээс 1,030 /30%/ эрэгтэй, 2,309 /70%/ эмэгтэй байсан ба 1,325 /39%/ малчин, 480 /14%/ ахмад настан байсан. 508 /15%/ иргэнд эмчийн зөвлөгөө өгч, сумын эмчийн хяналтад эмийн эмчилгээ хийлгэж, 237 /7%/ иргэнийг лавлагаа шатлалд шилжүүлж, шаардлагатай нарийн шинжилгээ, оношилгоонд хамруулан эмчийн хяналтад авсан.</p>	
<p><b>Арга хэмжээ 2.1.4</b> Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Нийт авлагагүй донорын тоо</p>	<p>778</p>	<p>800</p>	<p>2024 онд ДЭМБ-аас “Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа” уриан дор тэмдэглэхээр шийдвэрлэсний дагуу ЦСҮТ-өөс ирүүлсэн удирдамжийн хүрээнд ЭМБ-уудад эрүүл хүн бүрийг цусны донорт элсүүлэх, донорын эгнээг өргөжүүлэх, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг тогтмол хугацаанд цусаа бэлэглэх орчин нөхцлийг бүрдүүлэх, олон нийтэд алдаршуулах, сурталчлах, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах чиглэл өгч ажилласан. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 17/13 тогтоолоор Цусны донорыг урамшуулах, донорын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, журам гаргасан. Журмын хүрээнд Улаанзагалмайн нийгэмлэг, БОЭТ-тэй хамтран 90 доноруудын дунд спорт арга хэмжээ зохион байгуулж, мөн Хүндэт донор-4, Ачтан</p>	<p>100</p>

						<p>донор-10, Энэрэнгүй донор-10 тус тус шалгаруулан, алдаршуулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд “Цусаа бэлэглэх өдөр аян”-г сар бүрийн 03-ны өдөр зохион байгуулж, донорын эгнээг нэмэгдүүлж Нийт бүртгэлтэй байнгын идэвхтэй донор 558 байна. БОЭТ-ийн цусны станцад 444 цувралын 856 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж нөөцөнд 1033 нэгж цус, аймгийн эмнэлэгт 765 нэгж, сумдад 75 нэгж бүтээгдэхүүнийг захиалгын дагуу бүрэн нийлүүлсэн. Цуглуулсан 326 нэгж бүхэл цусанд халдвар илрүүлэх 4 шинжилгээг 100% хийсэн ба 3 цусанд элэгний С,В вирус илэрч актлагдсан байна.</p>	
	<p><b>Арга хэмжээ 2.1.5</b> Эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний чанар хүртээмж, техникийн хангалтыг сайжруулах</p>	Орон нутгийн төсөв	Техник, хэрэгслийн тоо	7	8	<p>ДЭМБ-ын дэмжлэгээр Эрүүл мэндийн яамнаас 14 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн 61 багт багийн эмчийн яаралтай тусламжийн Дижитал даралтын аппарат, пульсоксометр, зайн өндөр хэмжигч, халууны шил, амьсгал тоологч болон жирэмсний тест, гемоглобины тест, шээсний шинжилгээ, тэмбүүгийн шинжилгээг хийх түргэвчилсэн тестүүд багцыг нийлүүлж, тараагдсанаар яаралтай тусламжийн бэлэн байдлын хангалт 90 хувь байна.</p> <p>“Эмнэлэг хүртэлх гэмтэгсдийг аврах”-тусламж үзүүлэгч мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх сургалтыг Эрүүл мэндийн газар, БОЭТ, 11 сумын ЭМТ, 3 уул уурхайн эмч нарт 12 төрлийн онолын хичээл, 12 төрлийн тохиолдлын өртөөт гардан сургалт, 5 төрлийн ур чадварын өртөөт гардан ажилбарын сургалтыг сүүлийн үеийн олон улсын сургалтын шинэ хэрэглэгдэхүүнүүдийг ашиглан зохион байгуулсан.</p> <p>Зүрх судасны өвчний хүндрэлээс сэргийлэх зорилгоор орон нутгийн дэмжлэгээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ангиографийн оношилгоо, эмчилгээний тусламжийг нэвтрүүлж, 87 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн ЭМЯ-наас томилогдсон Үндэсний баг 2 удаа ирж, зүрх судас, хэвлийн, мэдрэлийн, хавдрын ангиографийн тусламж үйлчилгээг нэвтрүүлж, ажлын байрны сургалт зохион байгуулж, эмч, мэргэжилтнүүдийг багаар нь дагалдуулсан.</p>	100

	<p><b>Арга хэмжээ 2.1.6</b> Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлэх</p>	<p>Улсын төсөв, Орон нутгийн төсөв</p>	<p>Төлөвлөгөөний хэрэгжилт</p>	<p>90,5</p>	<p>95</p>	<p>Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн болон шинэ мэргэжилтнүүдийг чиглүүлэх сургалтаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” чиглэлээр мэдээлэл, сургалт зохион байгуулж, 104 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. БОЭТ болон 13 анхан шатны ЭМБ-д дэмжлэгт хяналтаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд үнэлгээ хийж, мэргэжил аргазүйн зөвлөмж хүргүүлсэн. БОЭТ-ийн удирдлагын баг шинэчлэгдсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны үйл ажиллагаанд дэмжлэгт хяналтыг хийж, 13 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснээр Чанарын алба 4 орон тоогоор ажиллаж, ЭМХТ-д хүсэлт тавьж, ЭМТҮЧАБ-ын чиглэлээр ажлын байрны сургалт зохион байгуулах зөвлөх баг ирж, 6 өдөр ажилласан. Энэ хугацаанд сум, өрхийн ЭМТ-ийн Чанарын багийнханд сургалт зохион байгуулж, 25 хүн хамрагдсан. Тохиолдол, эрсдэл бүртгэх, хариу арга хэмжээ авах ажлуудын үнэлгээ 10%-р өссөн. ЭМЯ-аас удирдлагын багийн үйл ажиллагаа, чанарын албаны үйл ажиллагаанд хяналт хийж, зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 90% байна.</p> <p>2024 онд орон нутагт нэвтрүүлсэн шинэ технологи:</p> <p>1. Молекул биологийн лабораторид BIO RAD ПСР аппарат, BIO NEER ялгах аппаратыг нэвтрүүлсэн. Тус аппаратаар доорх нэр төрлийн шинжилгээ хийгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Бэлгийн замын далд халдвар илрүүлэх STI-14 ийн шинжилгээ - 473 хүнд</li> <li>-Хүний хөхөнцөр вирусийн 29 генотипийг илрүүлэх HPV, 200 хүнд</li> <li>-Элэгний ачаалал үзэх HBV, HDV, HCV, 1,029 хүнд</li> <li>-Улаан бурхан улаануудын шинжилгээ, 3 хүнд</li> </ul> <p>2.Хавдрын маркерийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн. Одоогоор 6 төрлийн хавдрын маркерийн шинжилгээг хавдар илрүүлэх, оношлох, тавиланг таамаглах, эмчилгээний үр дүнг хянах болон хавдрын дахисан эсэхийг илрүүлэх зорилгоор эмнэлзүйн практикт ашиглаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>-AFP- Элэгний эсийн хорт хавдар, үр хөврөлийн эсийн хавдрын маркери.</li> <li>-CA-125- Өндгөвчний хавдрын эмчилгээ, оношилгооны гол маркери.</li> </ul>	<p>100</p>
--	--	--	--------------------------------	-------------	-----------	--	------------

						<p>-СЕА-Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын маркери.  -СА19-9 Нойр булчирхайн хавдрын гол маркери.  -СА15-3-Хөхний хавдрын маркери.  -СА-72-4-Ходоодны хавдрын маркери.</p> <p>3.Дотор болон хөнгөвчлөхийн тасгийн үйлчлүүлэгчдэд эмчилгээний зорилгоор төвийн венийн гуурсыг цээжний болон хэвлийн хөндийд байршуулж байна. 2024 онд нийт 8 хүнд цээжний гуурс байрлуулсан. 20 хүнд хэвлийн гуурс байрлуулж эмчилгээ хийсэн.</p> <p>4.Ангиографийн тусламж үйлчилгээг зүрх судасны, мэдрэлийн, хэвлийн, хавдрын чиглэлээр үзүүлж эхэлсэн. ЭМЯ-аас томилогдсон Үндэсний багыг БОЭТ-ийн эмч, мэргэжилтнүүд дагалдан суралцаж, орон нутагт нутагшуулахаар ажиллаж байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 2.1.7</b>  Эмнэлгийн тусламж үйлчилгээнд хэрэгжүүлж буй стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжид хяналт тавих  Эмнэлгийн магадлан итгэмжлэлийн явцын үнэлгээ хийж, магадлан итгэмжлэл олгуулахад мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэх</p>	Улсын төсөв	Тухайн жилд магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо	-	11	<p>2024 онд аймгийн хэмжээнд эмнэлгийн магадлан итгэмжлэлд орох 11 эрүүл мэндийн байгууллагад тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар мэргэжил аргагүйн зөвлөмж өгч ажилласан.</p> <p>2024 оны II улиралд 6 сумын эрүүл мэндийн төв, 2 хувийн хэвшлийн эмнэлэг, 1 өрхийн эрүүл мэндийн төв, III улиралд 1 сумын эрүүл мэндийн төв 1 хувийн хэвшлийн эмнэлэг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу магадлан итгэмжлэлийн шинжээч нар ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/426 дугаар тушаалаар Ноён сумын эрүүл мэндийн төв 1 жил, Хүрмэн сумын эрүүл мэндийн төв 2 жилээр, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 сарын 13-ны А/346 дугаар тушаалаар, Шимбилэг өрхийн эрүүл мэндийн төв 2 жил, Баяндалай сумын эрүүл мэндийн төв 2 жил, Баян-Овоо сумын эрүүл мэндийн төв 4 жил, Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв 2 жил, Маналговь эмнэлэг 1 жилээр, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/296 дугаар тушаалаар Гурвантэс сумын эрүүл мэндийн төв 2 жил, Булган сумын эрүүл мэндийн төв 2 жил тус тус магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт хангаж, магадлан итгэмжлэгдсэн.</p> <p>.2024 оны 04 сард магадлан итгэмжлэлийн албанаас магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын</p>	90,9	

						<p>тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор явын хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдэж, “Тэгш дүүрэн төгөлдөр” эмнэлэгт ажиллаж, 28 шалгуур үзүүлэлт бүхий зөвлөмж өгч ажилласан ба 2024 оны 06 сард магадлан итгэмжлэлийн шинжээч нар томилогдон ажиллахад зөвлөмжийн хэрэгжилт дутагдалтай тул магадлан итгэмжлэгдээгүй зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо-10</p>	
	<p><b>Арга хэмжээ 2.1.8</b> Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө гарган арга зүйгээр хангах</p>	Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	94,1	98	<p>Сувилахуй, тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх-2024” оны төлөвлөгөөг гаргаж, батлуулан 4 зорилтын хүрээнд, 31 ажлыг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувь байна.</p> <p>АШУҮИС-ийн сувилахуйн сургуулиас сувилагч тусгай мэргэжилтнүүдэд “Харилцааны урлагт суралцахуй”, “Хувь хүний хөгжлийн хандлага”, “Сувилагчийн ёс зүйн зарим асуудал” сэдвүүдээр сургалт зохион байгуулж, нийт 205 сувилагч, тусгай мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <p>Эрүүл мэндийн газар, Улаанбаатар Их Сургуультай хамтран БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 7 сувилагчийг БНСУ-д туршлага судлах 7 хоногийн богино хугацааны дадлага сургалтад хамруулсан.</p> <p>Олон улсын сувилагчийн өдөрт зориулсан “Үйлчлүүлэгчийн стандартад сувилагчийн манлайлал-2024” онол практикийн бага хурлыг зохион байгуулан 9 илтгэгч оролцсон.</p> <p>Сувилагч мэргэжлийг сурталчилсан видео, контент арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 645 мэргэжилтнийг хамруулсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээний ажлын шилдэг арга туршлагыг нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд “КОНТЕНТ, ВИДЕО” бичлэгийн уралдааныг зохион</p>	90,2

						<p>байгуулж уг уралдаанд Эрүүл мэндийн 9 байгууллагаас бичлэг ирүүлснийг цахим сүлжээнд байршуулсан. Үзлэгийн хандалт 30,300 байна. Цахим сүлжээнд байршуулсан иргэдэд зориулсан мэдээ мэдээллийн үзлэгийн хандалт-38,565.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж үйлчилгээ,сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, хүний нөөц, ажлын ачаалал тэнцвэржүүлэх, сувилахуйн тусламж үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бэхжүүлэх 4 үйл ажиллагааны чиглэл бүхий 29 ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилт 90,2 хувь</p> <p>131 эрүүл мэндийн байгууллага, бусад салбарын 26 байгууллагад 1130 ажиллагсад ажиллаж байгаагийн 20% буюу 226 сувилагч, 32% буюу 362 эмнэлгийн тусгай мэргэжилтэн байна.Үүнээс 65% нь үндсэн болон төрөлжсөн мэргэжил эзэмшсэн, 22,1% нь мэргэжлийн зэрэг хамгаалсан байна. 2024 онд тэргүүлэх зэрэг-2, ахлах зэрэг-2 хамгаалсан..</p>	
--	--	--	--	--	--	---	--

**Зорилт 2.2 Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, эх, хүүхдийн эндэгдэл, үр хөндөлтийг бууруулах**

<p><b>Арга хэмжээ 2.2.1</b> “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх / ЭМС-ын 2021 оны А/760 тоот тушаал/ <b>“Эх, хүүхдийн эрүүл мэнд”</b> орон нутгийн дэд хөтөлбөрийг тусгай</p>	<p>Орон нутгийн төсөв 100.0 сая төгрөг</p>	<p>Хөтөлбөр,арга хэмжээний биелэлтийн хувь</p>	94,1	98	<p>Эрүүл мэндийн сайдын А/760 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөө, аймгийн “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 3 зорилт, 29 заалт бүхий төлөвлөгөө гарган, 100 сая төгрөгийг төсөвлөн, хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,2%-тай хэрэгжүүлж, дараах үр дүн гарсан. Үүнд эхийн эндэгдэлгүй, эхийн ноцтой хүндрэлийн 4 тохиолдол бүртгэгдсэн ч шуурхай хариу арга хэмжээ авч, эхийн амь насыг аварсан. Амьгүй төрөлтийг 6 тохиолдлоор, охидын төрөлтийг 7 тохиолдлоор бууруулсан. Нярайн эндэгдлийн тоо 6 тохиолдлоор өссөн ба 1-5 насны эндэгдэл 1, Жирэмсний эрт хяналтын хувийг өмнөх оны мөн үеэс 0,6%-р нэмэгдүүлж, 90,5% болсон.</p>	91,2
--	--	--	------	----	--	------

<p>төлөвлөгөөний хүрээнд үр дүнтэй хэрэгжүүлэх</p>						
<p><b>Арга хэмжээ 2.2.2</b> Эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эх, ургийн анагаах ухааныг хөгжүүлж, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил аргагүйгээр хангах</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Эхийн эндэгдэл</p>	<p>0</p>	<p>0</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч ажиллаж, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээнд мөрдөгдөж байгаа удирдамжийн хэрэгжилт, тусламж үйлчилгээний чанарт үнэлгээ хийх дэмжлэгт хяналтыг БОЭТ, 6 сумын ЭМТ-д хийж, зөвлөмж хүргүүлэн ажилласан. Жирэмсний эрт хяналтын хувийг өмнөх оны мөн үеэс 0,6%-р нэмэгдүүлж, 90,5% болсон.</p> <p>7 хоног бүрийн Пүрэв гаригт 17:00 цагт эх барихын болон яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах чиглэлээр 17 эрүүл мэндийн байгууллагуудад тогтмол цахим хурал зохион байгуулж байна.</p> <p>-БОЭТ-н эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг илрүүлэх сүүлийн үеийн суурин ЭХО аппарат (“Мед импекс” ХХК шалгарч 6-р сарын 11-нд Төрөх эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг тодорхойлох боломжтой шинэ технологийн samsung V8 загварын ЭХО аппаратыг нийлүүлсэн. Ингэснээр орон нутагт ургийн гажгийг тодорхойлох бусад нарийн шинжилгээг хийх боломжтой болсон. Ашиглалтад орсноос хойш 1930 эмэгтэй тус аппаратаар ЭХО оношилгоонд орсон байна)</p> <p>Эхийн эндэгдэл-0</p>	<p>100</p>
<p><b>Арга хэмжээ 2.2.3</b> Нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж,</p>	<p>Улсын төсөв</p>	<p>5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/</p>	<p>10.7</p>	<p>9.7</p>	<p>ЭМС-ын 2024 оны А/147 дугаар тушаалын дагуу гарсан төлөвлөгөөний хэрэгжилт 84%-тай байна</p> <p>2023 оны А/240 дугаар тушаалын дагуу ЭМГ, БОЭТ, анхан шатны ЭМБ-ын 93 эмч мэргэжилтнүүдэд “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам”-ыг танилцуулж, мэдээлэл хүргэсэн. Аймгийн хэмжээнд 11 сарын байдлаар 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 18 тохиолдол</p>	<p>70</p>

2.2	<p>үйлчилгээг анхан шат, лавлагаа шатлалын түвшинд зохион байгуулж, хүүхдийн эндэгдэлд судалгаа хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллах</p>					<p>бүртгэгдсэн нь /1000 амьд төрөлтөд 16.5/ өнгөрсөн оны мөн үеэс 12 тохиолдлоор өссөн,</p> <p>1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн 1000 амьд төрөлтөд 9,1 байна. ЭМХТ, ЭХЭМҮТ-ийн ТСА-д орон нутагт эмнэлзүйн хурлыг зохион байгуулах “Зөвлөн туслах баг”-ийг ажиллуулах хүсэлтийг хүргүүлсэн. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүүхэд, нярай, эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч нарын багтай хамтран “Бүсийн сургалт” арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Бага насны хүүхдийн сэргийлж болох өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор БОЭТ, сум, өрхийн ЭМТ болон хувийн эмнэлгийн нийт 24 эрүүл мэндийн байгууллагын 250 гаруй хүүхдийн болон ерөнхий мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдэд ЭХЭМҮТ-ийн бусад арга хэмжээтэй хамтран 6 удаагийн арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үеэр ЭХЭМҮТ-ын “Зөвлөн туслах баг” ажиллаж, 2023 оны эндэгдлийн судалгаанд дүн шинжилгээ хийж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгч, хамтран ажилласан.</p> <p>Сар бүр ЭХЭМҮТ-өөс орон нутгийн эмч нарт чиглэсэн цаг үеийн мэдээлэл, шаардлагатай арга зүйн сургалтыг цахимаар зохион байгуулдаг ба 8 удаагийн цахим сургалтад аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 162 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан.</p>	
	<p><b>Арга хэмжээ 2.2.4</b> Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлэх</p>	Орон нутгийн төсөв	Дэмжлэг авсан хүний тоо	0	1	<p>2024 оны 11 сарын байдлаар 1091 эх амаржсан. Эхийн ноцтой хүндрэлийн 4 тохиолдол бүртгэгдсэн. БОЭТ-д бүртгэгдсэн 1 тохиолдол дээр БОЭТ, ЭМГ-ын хамтарсан Аудитын баг эмнэлзүйн хэлэлцүүлэг хурлыг зохион байгуулж, ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд мэдээлэл, материалыг хугацаанд нь хүргүүлсэн ба ноцтой хүндрэлээс сэргийлэх зөвлөмж гарган, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлтэй 2 эхийг аймгийн Засаг даргын нөөц сангаас Улаанбаатар тээвэрлэсэн ба 38 сая төгрөгийг зарцуулсан.</p>	100



<p><b>Арга хэмжээ 2.2.5</b> Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана.</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Жирэмсний эрт үеийн хяналтын хувь нэмэгдэнэ</p>	<p>89,7 %</p>	<p>90,2%</p>	<p>Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн тэмбүүгийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж ажиллаж байна. Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ, жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор долоо хоног бүрийн Пүрэв гаригт 17:00 цагаас цахим хурлыг эмч, эх баригч нартай зохион байгуулж, мэргэжил аргагүйн зөвлөгөө чиглэл өгч ажиллаж байна.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын жирэмсний эрт үеийн хяналтыг 0,6%-иар нэмэгдүүлж, 90,5% байна. Эхээс урагт дамжих гурвалсан халдвараас сэргийлэх шинжилгээнүүдийг түргэвчилсэн оношлуураар 100% оношилж байна.</p> <p>Элэгний С вирусийн эмчилгээнд хамрагдах шаардлагатай 159 иргэнээс 81 иргэнийг эмчилгээнд бүрэн хамруулж, 44 хүн эдгэрсэн байна. Үүнээс жирэмсэн 7 хүн эмчийн хяналтад орсон байна. Элэгний В вирусийн эмчилгээнд 75 хүн шинээр хяналтад орж нийт 30 хүн эмийн эмчилгээнд тасралтгүй хамрагдаж байна. Үүнээс жирэмсэн 10 эх эмчийн хяналтад байна.</p> <p>11 сарын байдлаар БЗДХ-н 424 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 141 тохиолдлоор, 10000 хүн амд 18,6-р нэмэгдсэн ба 4,5% нь жирэмсний үзлэгээс, 9.4% нь урьдчилан сэргийлэх үзлэгээр, 79% нь өвчний учир амбулаториор, 4,7% нь тандалтын үзлэгээс илэрсэн байна.</p> <p>Төрөлхийн тэмбүүгийн тохиолдол бүртгэгдээгүй байна.</p>	<p>100</p>
<p><b>Арга хэмжээ 2.2.6</b> Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан хүүхдийн хувь</p>	<p>90</p>	<p>95</p>	<p>“Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэгт хамруулах чиглэлээр 9, 18, 36 сартай хүүхдэд эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн цогц үзлэг хийх арга барилыг сум, өрхийн ЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдэд зааж сургах үйл ажиллагааг тогтмолжуулахаар “Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг хийх” мэргэжил аргагүйн сургалтад орон нутгийн 4 эмч сургагч багшаар</p>	<p>100</p>

байгуулахад мэргэжил аргагүйгээр хангаж ажиллах.					<p>бэлтгэгдсэн. Бусад сургалт арга хэмжээтэй уялдуулан нийт 4 удаагийн сургалт арга хэмжээг 160 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан зохион байгуулсан. НҮБХС-ын дэмжлэгээр АШУҮИС-ийн техникийн аргачлалаар “Нярайн скрининг шинжилгээ, оношилгооны салбар төв”-ийг 2024 оны 3-р сард байгуулан, төрсөн нярайд 24 цагийн дотор төрөлхийн эмгэгээс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх шинжилгээнд хамруулж байна. Ашиглалтад орсноос хойш БОЭТ-д төрсөн нийт 700 нярайд шинжилгээг хийж, сорьцыг тээвэрлэсэн бөгөөд 40 нярайд давтан шинжилгээ хийгдэж, 19 хүүхдэд ферментийн өөрчлөлт илэрснийг төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн зөвлөх эмчийн удирдамжаар ар гэрт зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>100 настны судалгаагаар 2024 онд хөгжлийн цогц үзлэгт хамрагдвал зохих 9,18,36 сартай 4899 гаруй хүүхдээс БОЭТ-ийн төрсөн нярайн скринингт хамрагдсан хүүхдүүд болон анхан шатанд /9,18,36 сартай хүүхдүүд/ хамрагдсан хүүхдүүд давхардсан тоогоор 4856 буюу 99% нь хөгжлийн цогц үзлэгт хамрагдсан байна.</p>	
<p><b>Арга хэмжээ 2.2.7</b> Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах</p>	Улсын төсөв	Шийдвэрлүүлж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	1	1	<p>Орон нутгийн “Эрүүл Өмнөговь”, “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэг, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, оношилгоог зорилтот 4 суманд зохион байгуулах, мөн Герман улсын эмэгтэйчүүдийн хавдрын эмчийн үзлэг, оношилгоог БОЭТ-д ажиллуулах, ажлын байрны сургалт зохион байгуулах, нярайн тасгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тохижуулах, нярайн скринингийн төвийг орон нутагт байгуулах зэрэг 3 ажлуудын санал, төсвийг гаргаж, АЗДТГ-т танилцуулан шийдвэрлүүлсэн.</p> <p>хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо-3</p>	100
<p><b>Зорилт 2.3 Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх, иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх</b></p>						

2.3	<p><b>Арга хэмжээ 2.3.1</b> Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах /ЭМС-ын 2022 оны А/749 дугаар тушаал /</p>	Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	87	90	<p>Орон нутгийн хэмжээнд уламжлалт, сэргээн засахын тусламж үйлчилгээг гүйцэтгэлийн санхүүжилтээр үзүүлж буй БОЭТ, 14 СЭМТ, 3 ӨЭМТ, хувийн ортой 3 эмнэлэг, “Ар үр” сувиллууд өдөр тутамдаа тогтмол үзүүлж нийт уламжлалтын 16, сэргээн засахын 2 эмч, 15 бага эмч, сувилагч салбар бүрд ажиллаж байна. ЭМБ-ууд сум орон нутгийн онцлогт уялдуулан төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 88 хувьтай, уламжлалт, сэргээн засах чиглэлээр 7-9 төрөлд тусламж үйлчилгээг нарийвчлан үзүүлж өдрийн болон гэрийн эргэлтийн тусламж үйлчилгээг түлхүү хүргэн ажиллаж байна.</p> <p>Бүс нутгийн хэмжээнд энэхүү тусламж үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд шинээр баригдаж буй “Уламжлалт, сэргээн засахын 40 ортой эмнэлэг”-ийг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах “Ажлын хэсэг”-ийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг эрчимжүүлж шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн тооцоо судалгааг гарган худалдан авах ажлыг эхлүүлсэн. Мөн хүний нөөцийн тооцоо судалгаа, урсгал зардлын төсвийн тооцоог гарган хүргүүлсэн. Хүний нөөцийн хангалтыг бүрдүүлэхээр ажиллах хүсэлтэй эмч мэргэжилтний жагсаалтыг гарган ажилд орох анкетыг авч байна.</p> <p>Тус эмнэлгийн ажиллах эрхзүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч орон нутгийн хэмжээний тусламж үйлчилгээний судалгааг гарган албан бичгийн төслийг хянуулж хүргүүлсэн. Эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэл 95%-тай үргэлжилж улсын комисст хүлээлгэн өгөх шатандаа ажиллаж байна. Мөн хүний нөөцийн чадавхыг сайжруулах зорилгоор БОЭТ, өрхийн ЭМТ-ийн эмч сувилагч нар болон тухайн эмнэлэгт ажиллах сэргээн засах уламжлалтын 11 эмч мэргэжилтнүүдийг Солонгос улсын Дизайн эмнэлэгт туршлага судлуулах эмнэлзүйн богино хугацааны сургалтад хамруулан орон нутгийн хэмжээнд ЭМБ</p>	95
-----	--	-------------	---------------------------------	----	----	--	----

						<p>хоорондын хамтын ажиллагааны боломжийг бүрдүүлж байна.</p> <p>Эмнэлгийн үйл ажиллагаа эхэлснээр уламжлалт, сэргээн засахын 4-5 төрлийн тусламж үйлчилгээний нэмэгдэж иргэдэд хүрч үйлчлэх боломж илүү өргөн хүрээнд чанартай тусламж үйлчилгээг авах боломж бүрдэнэ.</p>	
	<p><b>Арга хэмжээ 2.3.2</b> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засал тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг удирдлага арга зүйгээр хангах</p>	Төсөл хөтөлбөр	Хүрч үйлчлэх зорилтод бүлгийн хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн хувь	60	80	<p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад 0-15 насны хөгжлийн бэрхшээлтэй 327 хүүхэд бүртгэгдсэн ба дээрх хүүхдүүдээс саажилт, уналт таталт, тархины усжилт гэсэн оноштой 30 хүүхэд, тэдний эцэг эх асран хамгаалагчид нийт 60 хүнийг аймгийн ЗДТ, "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд "Эрхэм нандин сувд" ТББ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран 17 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг оношилгоонд үнэ төлбөргүй хамруулан ар гэрт дэлгэрэнгүй зөвлөгөө зөвлөмжийг төрөлжсөн мэргэжлийн эмч нар өгсөн. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь сэргээн засахын чиглэлээр 2 хөдөлгөөн засалчийг ажиллуулж байгаа бөгөөд нийт 36 хүүхдийг 7-14 хоногийн хөдөлгөөн заслын эмчилгээнд хамрагдсан.</p> <p>"Говь дент" шүдний төвд тусгай хэрэгцээт хүүхдийн амны хөндийг эрүүлжүүлэх "ХҮҮХЭД БҮХЭН ЖАРГАЛТАЙ БАЙГ" аян зохион байгуулан одоогоор 81 хүүхдүүдийг шүдний үзлэгт хамруулж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлээд байна. Өндөр даралтад хүчилтөрөгчийн эмчилгээнд Даланзадгад сумын хөгжлийн бэрхшээлтэй 41 хүүхэд хамруулан эмчилгээг 14 хоногийн давтамжтай тасралтгүй оруулан ар гэр асран хамгаалагчдад зөвлөгөө мэдээлэл өгч, асаргаа дэмжих хуралд ХБ-тэй 20 хүүхдийг шинээр хамруулан хяналт хийн ажилласан.</p> <p>11 сарын байдлаар 37246 хүүхдийг идэвхтэй хяналтын үзлэгт хамруулсан ба хүрч үйлчлэх зорилтод бүлгийн 302 хүүхдэд буюу 92,3% шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлсэн.</p>	100

	<p><b>Арга хэмжээ 2.3.3</b> Эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх үүсвэрээс авахгүй байх чиглэлийг хэрэгжүүлж ажиллах</p>	Улсын төсөв	Эмийн хангалтын хувь	85	88	<p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем Tender.gov.mn цахим дэлгүүрээс 9 удаагийн худалдан авалтаар 23 Эм ханган нийлүүлэх байгууллагатай ерөнхий гэрээний дагуу 118 удаа гэрээ байгуулж давхардсан тоогоор 611 нэр төрлийн 468,168,675₮-н эм, эмнэлгийн хэрэгслийг татан авч Эрүүл мэндийн байгууллагуудын захиалгын дагуу түгээлт хийж зайлшгүй шаардлагатай эмийн хангамж хүртээмжийг тогтвортой хангасан.</p> <p>Ерөнхий гэрээгээр 6,535, 675₮-н хэмнэлттэй худалдан авалтыг зохион байгуулсан. Гэрээний гүйцэтгэл 477,723 138₮ буюу 98 хувьтай хэрэгжсэн. Эрүүл мэндийн байгууллагуудад хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Цахим дэлгүүрт байршсан эм хэрэгслийг бусад эх үүсвэрээс худалдан авахгүй байх зөвлөмжийг хүргүүлж, Цахим дэлгүүрт ороогүй бусад 458 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэлд 22 багцтай 569,0 сая ₮-н төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтаар 19 багцад 10 ЭХНБ-тай 486,7 сая ₮-н гэрээ байгуулж 49,8 сая ₮-н хэмнэлттэй тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд амжилттай зохион байгуулсан. Гэрээний гүйцэтгэл 429,1 сая ₮ буюу 89%-тай хэрэгжсэн байна. 2024 оны 11 сарын байдлаар Нийт эмийн сангууд 17854 жор хүлээн авч, 16 тэрбум 147 сая гаруй төгрөгийн эм бараа борлуулалт хийсэн байна.</p> <p>Эргэлтийн эмийн сангуудад нийт 13637 жор ирсний 41,5% /5663/ нь ЭМДаатгалын, 0,9%/136/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 57,5% /7838/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дунджаар 99,1% байна</p>	100
	<p><b>Арга хэмжээ 2.3.4</b> Эм, эмнэлгийн хэрэгслийн зохистой хэрэглээ, эмийн чанар аюулгүй байдлыг хангах арга</p>	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	7	8	<p>Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр: Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас ирүүлсэн Эмийн гаж нөлөөний сэрэмжлүүлэг мэдээллийн дагуу бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдэд зориулсан эмийн эмчилгээний алдаанаас сэргийлэх, гаж нөлөө илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний талаар цахим сургалтыг 1 удаа зохион</p>	100

	<p>хэмжээ зохион байгуулж ажиллах</p>					<p>байгуулж, 44 байгууллагын 50 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан.</p> <p>ДЭМБ -аас жил бүр зарладаг Эмийн зохистой хэрэглээний 10 хоногийн аяныг 9 дүгээр сард, Бичил биетний тэсвэржилтийн дэлхийн 7 хоногийн аяныг 11 дүгээр сард тус тус нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан. Аяны хугацаанд ЭМГ-аас эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан 2 багц цагийн сургалтыг АШУҮИС-тай хамтран 45 эмнэлгийн мэргэжилтэнд, Харшлын хөтөлбөрийн хүрээнд зориулсан сургалтаар 35 төрийн албан хаагч нарт, Политехникийн коллежийн 45 оюутанд 1 удаа тус тус зохион байгуулав. Эрүүл мэндийн байгууллагууд хүргүүлсэн удирдамж төлөвлөгөөний дагуу дотоодын сургалтаар 129 эмнэлгийн мэргэжилтэнд, 448 иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулж, 77 удаагийн постер, богино бичлэг, видео бичлэгийг цахим орчинд байршуулж, хуваалцах зэргээр цахим орчинд мэдээллийг хүргэсэн, мөн Иргэдэд зориулсан өдөрлөгийн үйл ажиллагааг Даланзадгад сумын 17 эмийн сангаас 436 иргэнд Антибиотикийн зохистой хэрэглээ, Эмийн гаж нөлөө, эм хэрэглэх 5 зөвийн зарчим зэрэг мэдээ мэдээллийг хүргэж, витаминжуулалт амны хаалтыг иргэдэд түгээж ажиллалаа.</p> <p>Эмийн чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эм зүйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, эм зүйн тусламж үйлчилгээтэй холбоотой батлагдсан заавар журам тушаалын хэрэгжилтийг сайжруулах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад эм эмнэлгийн хэрэгсэл хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор цахим сургалтыг 1 удаа 12 эрүүл мэндийн байгууллагын 12 эмнэлгийн мэргэжилтэн хамруулан зохион байгуулсан.</p> <p>Эм зүйн тусламж үйлчилгээ, бодлогын хэрэгжилт чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр аймгийн БОЭТ-д 25 асуумжтай хяналтын хуудасны дагуу 1 удаагийн хяналт үнэлгээ, 5 сумын эрүүл мэндийн төвд 3 чиглэлийн 7 асуумжийн хүрээнд хяналт үнэлгээ хийж, 6 эмнэлэгт давхардсан тоогоор 50 заалт бүхий зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг үнэлэн ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт дунджаар 78% үнэлэгдсэн.</p>	
--	---------------------------------------	--	--	--	--	--	--

						<p>Сумын иргэдийн Зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Гурвантэс, Цогтцэций суманд ажиллаж байгаа эмийн сангуудад мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгож, эмийн сангийн мэргэжилтнүүдэд өндөр эрсдэлт эмэнд холбогдох тушаал журмын хэрэгжүүлэн ажиллах чиглүүлэх арга зүйн сургалтыг 1 удаа зохион байгуулав.</p> <p>“Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн тандалтын тогтолцооны мэдээлэл цуглуулах” цахим сургалтыг 1 удаа зохион байгуулж БОЭТ, Сум, Өрхийн ЭМТ-дийн ЖСАХ-хариуцдаг 17 эмч мэргэжилтнүүдийг хамруулж, жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслийн бүртгэл, тайлагналтыг цахим системээр хийх үйл ажиллагааг хэвшүүлж байна. ЭМГ-аас зохион байгуулсан. сургалт мэдээлэл үйл ажиллагааны тоо : сургалт мэдээлэл 7 удаа, хяналт үнэлгээ 6 удаа хийгдсэн, бусад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран өдөрлөг мэдээллийн үйл ажиллагаа 1 удаа, зохистой хэрэглээний аян 2 удаа зохион байгуулсан.</p>	
<p><b>Арга хэмжээ 2.3.5</b></p> <p>Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хяналт тавих, тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх асуудлуудыг хуулийн хүрээнд, хугацаанд нь шийдвэрлэж ажиллах</p>	Улсын төсөв	Хяналт үнэлгээнд хамрагдсан ЭМБ-ын тоо	40	45	<p>Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 11 удаа хуралдаж, нийт дараах чиглэлийн 89 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 21 төсөлд эхний шатны хэрэгцээний үнэлгээ хийгдэж, 4 төслийг буцаасан.</li> <li>2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 36 ЭМБ-н хүсэлтийг хэлэлцэж, үүнээс 9 эмнэлэг, 1 сувилал, 2 АШМУХ, 18 эмийн сангийн хугацааг сунгасан.</li> <li>3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангаагүй 2 эмнэлэг, 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалсан.</li> <li>4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл нэмэх болон хасах 6 эмнэлгийн хүсэлтийг шийдвэрлэв.</li> <li>5. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлын хүрээнд 5 удаа хэлэлцсэн.</li> </ol> <p>Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаас гарсан шийдвэрийг ЭМГД-н 9 удаагийн тушаалаар баталгаажуулж, 9 удаагийн</p>	100	

						<p>удирдамжаар 22 ЭМБ-д шинжээчийн баг ажиллуулж үнэлгээ дүгнэлт гаргуулсан ба 84 ЭМБ-д комиссын зөвлөмжийг хүргүүлсэн. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд license.mn цахим системийг нэвтрүүлж, тусгай зөвшөөрөл бүхий 124 ЭМБ-ын мэдээллийг шивж мэдээллийг санг үүсгэсэн. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын тоо-36. Шинээр олгосон тоо -16. Тусгай зөвшөөрлийг цуцалсан-3. Хяналт үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо-22.</p>	
--	--	--	--	--	--	--	--

**Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, мэргэжилтэн, ажилтнуудын хүрэлцээ, чадамжийг нэмэгдүүлж, дэмжин хөгжүүлэх, тэдний амьдрах орчин, нийгмийн хамгааллыг сайжруулна.**

**Зорилт 3.1 Эмч, сувилагч эрүүл мэндийн салбарын мэргэжилтнийг сургах, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжих**

3.1	<p><b>Арга хэмжээ 3.1.1.</b> Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлж, эмч мэргэжилтнүүдийн дунд ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах</p>	Орон нутгийн төсөв	Хүний нөөцийг чадавхжуулах сургалтын тоо	59	гүйцэтгэл ээр	<p>Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хяналтын хорооноос “Эрүүл мэндийн байгууллагын соёлд хувь хүний хөгжил, үйлчилгээний стандартыг хэвшүүлэх нь” сэдэвт сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр танхим болон цахим хослуулан зохион байгуулж нийт 126 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон. АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн багш нар 2024.04.22-23-ны өдрүүдэд сувилагч тусгай мэргэжилтнүүдэд “Харилцааны урлагт суралцахуй”, “Хувь хүний хөгжлийн хандлага”, “Сувилагчийн ёс зүйн зарим асуудал” сэдвүүдээр сургалт зохион байгуулж нийт 205 сувилагч, тусгай мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <p>2024.05.2-3 өдрүүдэд Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн хяналтын хорооны дарга О.Оюунбилэг эрүүл мэндийн байгууллагын дарга, удирдлагуудад удирдлагын манлайлал, ёс зүй сэдвээр сургалтыг орсон.</p> <p>2024.11.04-ний өдөр эрүүл мэндийн салбарт шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд баримжаа олгох сургалтыг зохион байгуулж тус сургалтад Эрүүл мэндийн яамны ёс зүйн хяналтын хорооны дарга Ц.Оюунбилэг “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж сургалтад</p>	100
-----	--	--------------------	--	----	---------------	---	-----



						<p>БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон 40 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <p>Эрүүл мэндийн салбарын жолооч, үйлчлэгч, туслах ажилчдыг хөгжүүлэх, ёс зүй харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалтыг 2024.11.04-ний өдөр зохион байгуулж тус сургалтад ЭМГ-ын НЭМТ-ийн Сэтгэцийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Б.Ганцэцэг ёс зүй, харилцаа хандлага, super jump-н сургагч багш Г.Өлзийбүрэн амьдралаас та юу хүсдэг вэ? зэрэг ёс зүй, харилцааны сургалтыг зохион байгуулж сургалтад 55 туслах ажилчид хамрагдсан юм.</p> <p>эмч мэргэжилтнүүдийн дунд ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан тоо-496</p>	
<p><b>Арга хэмжээ 3.1.2</b> Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх</p>	Улсын төсөв	<p>Ажлын байран дахь сургалтын тоо</p> <p>Мэргэшүүлэх сургалтын тоо</p>	6 13	гүйцэтгэл ээр	<p>-БОЭТ, 14 СЭМТ, хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын эмнэлзүйн хоолны 20 тогооч нарт эмнэлзүйн хоолны нэр төрлийг олшруулах, амт чанарыг сайжруулах, тогооч нарын ажлын байрны чадамжийг нэмэгдүүлэх онол, дадлага хосолсон 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>-“Эрүүл Өмнөговь зорилтын хүрээнд” эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор АНУ-ын Монгол дахь элчин сайдын яамны "Иргэн цэргийн харилцааны дэмжлэгийн бүлэг", Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран "Эмнэлэг хүртэлх гэмтэгсдийг аврах тусламж" сэдэвт онол, дадлага хосолсон 3 хоногийн сургалтыг Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллагууд, уул уурхайн бүсэд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлдэг 24 эмч, мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан.</p> <p>-УНТЭ-ийн Зүрхний төвийн Зөвлөх эмч, зүрх судас, судсан дотуурх мэс заслын эмч, тоног төхөөрөмжийн инженерийн баг 2024 оны 5-8 сарын хооронд 6 удаа Өмнөговь аймагт ирж БОЭТ-ийн эмч, сувилагч, тоног төхөөрөмжийн инженер, техникч, туслах сувилагч нарын багтай хамтран үзлэг, оношилгоо, эмчилгээ хийж, мөн эмч мэргэжилтнүүдийг ажлын байран дээр сургасан.</p>	100	

					<p>-“Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд Франц улсын “ACTIONS MONGOLIE” ТББ-тай хамтран Франц улсын нүдний эмч, тоног төхөөрөмжийн инженер нар БОЭТ-д ажиллаж шаардлагатай иргэдэд дурангийн мэс засал, нүдний эмчийн үзлэг, эмч нарыг ажлын байран дээрх дагалдан сургалтыг зохион байгуулсан.</p> <p>- "Нутгийн Хишиг" хөтөлбөрийн хүрээнд эмч, эмнэлгийн ажилчдыг өөрсдийн ажлын байр, тоног төхөөрөмжид нь лавлагаа шатлалын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар дагалдуулан чадваржуулах, улмаар орон нутагт хийгддэггүй шинэ оношилгоо, эмчилгээний аргыг нутагшуулах зорилтыг тавин ажиллаж энэхүү ажлын хүрээнд ХБНГУ-ын Анагаах ухааны доктор, эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын их эмч Хенниг Риттер нь 15 хоногийн хугацаанд БОЭТ-ийн хавдрын их эмч, дүрс оношилгооны их эмч, эмэгтэйчүүдийн их эмчтэй хамтран 100 гаруй иргэдэд үзлэг, оношилгоо хийж, эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээр дагалдан сургаж ажилласан.</p> <p>-ЭМС-ын тушаалаар томилогдсон Үндэсний баг болох УНТЭ, УГТЭ, ХСҮТ, УХТЭ-ийн Зүрх судасны ангиографи, мэдрэлийн ангиографи, хэвлийн хөндийн ангиографийн эмч нар БОЭТ-д 2 удаа томилогдон ажилласан. Ингэснээр Өмнөговь аймагт эмнэлгийн тусламж үйлчилгээний шинэ технологийг нэвтрүүлж, мэдрэлийн ангиографи, хэвлийн ангиографи эмчилгээнүүдийг анх удаа хийж, цаашид нутагшуулахаар эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээр дагалдуулан сургасан.</p> <p>-Канад Улсын Бритиш Колумбиагийн их сургуулийн профессор, Лаурел мэс заслын сангийн УЗ-ийн гишүүн, төслийн удирдагч Хью Парсонс, Лаурел мэс заслын сангийн УЗ-ийн нарийн бичгийн дарга Кристин Туано нар ШУГТЭ, УНТЭ-ийн нүдний эмч, резидент эмч нар Өмнөговь аймгийн БОЭТ-ийн нүдний эмч, сувилагч нартай хамтарсан үзлэг оношилгоог хийж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж ажиллаа.</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>-"Эрүүл Өмнөговь" хөтөлбөрийн хүрээнд АШУУИС-ийн хүүхдийн тэнхимийн эмч нар орон нутгийн эмч, сувилагч нарыг чадваржуулах зорилгоор "Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн үеийн менежмент" сургалтыг ЭМГ болон БОЭТ дээр зохион байгууллаа. Сургалтад БОЭТ, 14 сум, 3 ӨЭМТ, ХХЭМБ-ын нийт 50 эмч, 26 сувилагч хамрагдлаа. Мөн АШУУИС-ийн харьяа Монгол-Япон эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар БОЭТ-ийн эмч нартай хамтарсан үзлэг хийж эмч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулсан.</p> <p>- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хүний нөөцийн бодлого, сургалт, магадлан итгэмжлэл, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, халдвараас сэргийлэх хяналт, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн программ хангамж, статистик мэдээллийн талаар Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 34 алба хаагчдад ажлын байрны чиглүүлэх дадлага сургалтыг зохион байгуулан арга зүйгээр ханган ажилласан.</p> <p>Ажлын байран дахь сургалт-15</p> <p>Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо-181</p>	
<b>Арга хэмжээ 3.1.3</b> Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн стандарт хангалтыг нэмэгдүүлэх	Улсын төсөв	Хүний нөөцийн стандарт хангалтын хувь	89	92	Аймгийн хэмжээнд нийт 18 эрүүл мэндийн байгууллага иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаагаас сумын эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөцийн стандарт хангалт 85 хувь, өрхийн эрүүл мэндийн төвүүд- 96,7 хувь, БОЭТ-66 хувийн стандарт хангалттай ажиллаж байна. Хүний нөөцийн стандарт хангалтын хувь-82,5	89,6	
<b>Арга хэмжээ 3.1.4</b> Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор	Улсын төсөв	Дэмжлэгт хамрагдсан ажиллагсдын тоо	39	50	Эмч нарын баярыг тохиолдуулан Баян-Овоо сумын залуу эмчид амьдрах орчин нөхцөлөө сайжруулахад АЗДТГ-аас дэмжлэг болгож 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 1 сувилагчид таван ханатай гэр чип дулаалгын хамт 2 сувилагчид гэрийн чип дуулаалга олгож амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан байна. Төрийн албан хаагчийн	100	

<p>суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах үйл ажиллагааг шийдвэрлүүлж дэмжүүлэх</p>					<p>тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд 42 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 288 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгт хамруулж амьдрах орчныг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ба 1 эмчид сургалтын зардалд 2 сая, 2 хүнд эмчилгээний зардалд 7 сая төгрөгийн дэмжлэг нийт 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 297 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Мөн нэн шаардлагатай хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын хүрээнд БОЭТ-ийн 3 эмчид амьдрах орчноо сайжруулахад нь 18 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Даланзадгад сумаас хэрэгжүүлж буй “Оюуны үр” хөтөлбөрөөс ӨЭМТ-ийн 2 ажилтанд 6 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор “Нутгийн дэм” хөтөлбөрийн хүрээнд нийт эрүүл мэндийн байгууллагын албан хаагчдад 400,000 төгрөгийн дэмжлэг үзүүлж байна.</p> <p>2024 онд нийт 54 эмч, эмнэлгийн ажилчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, сургалт болон эмчилгээний зардалд нийт 324 сая төгрөгийн дэмжлэгт хамруулсан.</p>	
<p><b>Арга хэмжээ 3.1.5</b> Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоодын сургалтад хамруулах,</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>Дэмжлэгт хамрагдсан ажиллагсдын тоо</p>	<p>-</p>	<p>гүйцэтгэл ээр</p>	<p>-2024-2025 оны төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад-7, төрөлжсөн мэргэшлийн сургалтад-12, мэргэшил дээшлүүлэх сургалтад 13 их эмч, 7 сувилагч, тусгай мэргэжилтэн суралцахаар эрүүл мэндийн сайдын А/125 дугаар тушаалаар хяналтын тоо батлагдсан. Төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх хаврын элсэлтэд 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр суралцаж байна. Үндсэн мэргэжлийн сургалтад-4 их эмч, төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх намрын элсэлтэд 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна.</p> <p>-Монголын экспорт импортыг дэмжих үндэсний төвийн харьяа Потеншил сургалтын төвтэй хамтран төр, хувийн хэвшилд ажиллаж байгаа 25 эмнэлгийн мэргэжилтнүүдийг</p>	<p>100</p>

	<p>эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжиж ажиллах</p>					<p>“Туслах сувилагч”-ийн 3 сарын сургалтад хамруулж амжилттай төгсгөсөн.</p> <p>- Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой хамтран 12 сумын эрүүл мэндийн төвийн дарга нарыг Удирдлагын академийн “Сумын эрүүл мэндийн төвийн удирдлагын хөгжил” сэдэвт богино хугацааны сургалтад хамруулахаар хүсэлтийг хүргүүлж 2-р ээлжид сурахаар төлөвлөгдсөн.</p> <p>-Эрүүл мэндийн сайдын “Гадаад сургалтад суралцуулах тухай” 199 дүгээр тушаалын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод зохион байгуулагдах богино хугацааны гадаад сургалтад сумдын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, сувилагч, багийн эмчийн мэдээллийг авч сургалтад хамруулж байна. 1,2-р ээлжид 3 сувилагч богино хугацааны гадаад сургалтад хамрагдсан. 3 сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч 3-р ээлжид явуулахаар хүсэлт хүргүүлсэн.</p> <p>-Эрүүл мэндийн газар, Улаанбаатар Их Сургуультай хамтран БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 7 сувилагчийг БНСУ-д туршлага судлах 7 хоногийн богино хугацааны дадлага сургалтад хамруулсан.</p> <p>-Нутгийн хишиг хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-Төв Ази болон Шанхай хотын хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудыг оролцуулан Urumqi хот дахь Шянжаны Анагаах Ухааны Их Сургуультай хамтран зохион байгуулсан “Умайн хүзүү болон хөхний хорт хавдрын урьдчилан сэргийлэлт ба хяналт” сэдэвт олон улсын конференцэд 2024 оны 07 сарын 05-ны өдрөөс 07 сарын 19-ны хооронд Х.ШБОЭТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн 2 эмчийг хамруулсан.</p> <p>-Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад орноос туршлага судлах, ажлын байрны дагалдан сургалтыг Даланзадгад сумын ЗДТГ-ын “Оюуны үр” хөтөлбөрийн санхүүжилтээр Япон улсын эрт илрүүлгийн төвийн үйл ажиллагаатай танилцах, орчин</p>
--	--	--	--	--	--	--

					<p>үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж судлах ажлаар 27 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.</p> <p>- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020-2024 оны “Нутгийн хишиг” мөрийн хөтөлбөр, Эрүүл Өмнөговь зорилтын хүрээнд Япон улсад “Хүүхдийн өвчний менежмент, тусламж үйлчилгээг сайжруулах” зорилгоор БОЭТ болон Сум, Өрхийн ЭМТ-ийн хүүхэд, нярайн 6 эмч нарыг туршлага судлах гадаад сургалтад хамруулсан.</p> <p>-Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын 22 албан хаагч Бүгд найрамдах Хятад ард улсын Хөх хотын Олон улсын эмнэлгийн хороонд туршлага судалсан.</p> <p>-“ГОВИЙН ОЮУ” хөгжлийг дэмжих сан, Аймгийн Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааны “Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр” болон БНСУ-ын Чонжү хотын “ДИЗАЙН” эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд “Уламжлалт, Сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах” зорилгоор богино хугацааны эмнэлзүйн сургалтад хамруулах, туршлага судлан ажлын байранд суралцуулахаар 11 эмч, сувилагчийг хамруулсан.</p> <p>Гадаад, дотоод сургалтын дэмжлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо-115</p>	
<p><b>Арга хэмжээ 3.1.6</b>  Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтныг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах</p>	-	<p>гүйцэтгэл ээр</p>	<p>Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга, Хяналт шалгалтын хэлтсийн даргын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу Төрийн жинхэнэ албаны бүтцийн нэгжийн удирдах албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтад орж</p>	100

	хангах					<p>хамгийн өндөр оноо авч тэнцсэн Б.Оюунсүрэнг ЭМГ-ын Хяналт шалгалтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагчийн,</p> <p>Б.Цагаанцэндийг ЭМГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн даргын сул орон тоонд тус тус томилуулахаар нэр дэвшүүлсэн Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 59, 60 дугаар тогтоолын дагуу томилон ажиллуулсан.</p>	
--	--------	--	--	--	--	--	--

**Стратегийн зорилго 4. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, санхүүжилтийг гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулж, дэд бүтцийг шинэчлэн засварлан өргөтгөж, иргэдэд ээлтэй ая тухтай орчныг бүрдүүлж, техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, технологийн дэвшлийг нутагшуулна.**

**Зорилт 4.1 Эрүүл мэндийн байгууллагуудын дэд бүтэц, автомашин, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх**

4.1	<p><b>Арга хэмжээ 4.1.1.</b> Гурвантэс, Ханхонгор сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилгын ажлыг эхлүүлэх. Хүрмэн, Баяндалай сумын Эрүүл мэндийн төвийн барилгыг дуусгаж ашиглалтад оруулах</p>	<p>Орон нутгийн төсөв 1,415.94 тб төгрөг</p> <p>Төсөл хөтөлбөр 2,224.80 тб төгрөг</p>	<p>Ажлын гүйцэтгэлийн хувь</p>	<p>-</p> <p>90</p>	<p>100</p> <p>100</p>	<p>- Гурвантэс сумын эрүүл мэндийн төвийн барилгын нийт төсөв 3,949,998,000 тэрбум ба 2024 онд 1 тэрбум, 2025 онд 2,9 тэрбумыг улсын төсөвт санал оруулсан. Грийтконтакт ХХК гүйцэтгэгчээр шалгарч гүйцэтгэл 30%-тай явагдаж байна.</p> <p>- Ханхонгор сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 2024 онд эхлээгүй. Ханхонгор сумын эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв Говийн Оюу Хөгжлийг дэмжих сангийн харилцааны хорооны гишүүдийн саналаар хасагдсан тул 2024 онд барилгын ажил эхлээгүй. Аюута ХХК Ханхонгор сумын эрүүл мэндийн төвийн эскиз зургийг гаргасан ба зураг төсөл хийгдэх гэрээ байгуулаагүй учир зураг төсөл хийгдэхгүй зогссон байна.</p> <p>- "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн 3,3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Хүрмэн сумын эрүүл мэндийн төвийн 15 ортой барилгыг "Тэлмүүн Доной" ХХК барьж гүйцэтгэж 2024 оны 03 сарын 20-нд байнгын ашиглалтад оруулсан.</p> <p>- "Нутгийн хишиг" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Баяндалай суманд 15 ортой,</p>	100
-----	---	---	--------------------------------	--------------------	-----------------------	--	-----

						лифттэй, 2 давхар шинэ эмнэлгийг барилгыг барьж 2024 оны 02 сарын 17-нд байнгын ашиглалтад оруулсан.	
<b>Арга хэмжээ 4.1.2.</b> Сэргээн засах 40 ортой эмнэлгийн барилгын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах	Улсын төсөв 2,915.60 тб төгрөг Орон нутгийн төсөв 2,000.00 тб төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувь	30	100		<p>- Даланзадгад суманд баригдаж буй "Уламжлах сэргээн засах 40 ортой эмнэлэг"-ийн нийт төсөв 9,3 тэрбум. Үүнээс, улсын төсвийн 7,3 тэрбум, орон нутгийн төсвийн 2 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр ХӨХ БҮРДНИЙ ЭХ ХХК барилгын ажлыг барьж гүйцэтгэж байгаа ба барилгын явц 90%-тай явагдаж байна.</p> <p>- Гэрээний хугацаа 2024 оны 12 сарын 20-нд дуусна.</p> <p>- Шинэ эмнэлгийн үйл ажиллагааг жигд тасралтгүй хангах зорилгоор тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сангийн 1,492,386,000 тэрбум төгрөгийн санхүүжилтээр худалдан авахаар төлөвлөж тендер шалгаруулалт хийгдэж байна. Тендер шалгаруулалт нь 3 багцаас бүрдэнэ. Багц 1 тавилгын хэрэгсэл нийт 300,000,000 сая төгрөг, багц 2 гал тогоо, хоол үйлдвэрлэлийн хэсэг, бусад багаж, туслах хэрэгсэл нийт 112,386,000 төгрөг, багц 3 хүлээн авах, яаралтай тусламж, үзлэгийн хэсэг 1,080,000,000 төгрөг байхаар төсөвлөөд байна.</p>	100
<b>Арга хэмжээ 4.1.3.</b> Хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, нярайн эндэгдлийг бууруулах зорилгоор Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд хүүхдийн 50 ортой	Орон нутгийн төсөв 2,000.00 тб төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	30		<p>- 2024 оны 11 сарын байдлаар, Хүүхдийн 50 ортой эмнэлгийн ажлын зураг төслийн зургийн даалгавар болон барилгын зураг төслийг Аюута ХХК нь нийт 9,1 тэрбум төгрөгийн төсөв шаардлагатай байхаар боловсруулав.</p> <p>- Зураг төсөв удааширсантай холбоотой барилгын ажил эхлээгүй байна. Зураг төсөв нь батлагдсан бөгөөд 2025 оны Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хүүхдийн 50 ортой эмнэлгийн нийт санхүүжилт 5 тэрбум төгрөг байна.</p>	100



эмнэлгийн барилгыг барьж эхлүүлэх							
<b>Арга хэмжээ 4.1.4.</b> Эрүүл мэндийн байгууллагын барилга, дэд бүтцийг сайжруулах /Цогтцэций, Хүрмэн, Манлай/	Орон нутгийн төсөв 1,179.89 тб төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	- Цогтцэций сумын эрүүл мэндийн төвийн шугамын ажил 430 сая төгрөгөөр хийгдэж байгаа бөгөөд дотор шугамын ажил дуусан улсын комисс ажиллах шатанд явагдаж байна.  - Тохь Гол ХХК Хүрмэн сумын эргэлтийн эмийн сангийн барилга болон эмч нарын амьдрах орон сууцны засварын ажлыг нийт 220 сая төгрөгөөр гүйцэтгэж 100% дуусган байнгын ашиглалтад оруулсан.  - Манлай СЭМТ-ийн барилгын ажлыг Манлай сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил бүрэн дуусч байнгын ашиглалтад орсон.	100	
<b>Арга хэмжээ 4.1.5.</b> Зоонозын өвчин судлалын төвийн хуучин барилгыг буулгах, шинэ барилгын ажлыг эхлүүлэх	Улсын төсөв 1,076.58 сая төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100	-Хуучин барилгын эзэмшлийн талбай хангалтгүй байна гэж үзсэн учир 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/28 дугаар тогтоолоор хасагдсан. Хуучин барилгыг буулгах шаардлагагүй болсон.  -шинэ ЗӨСТ-ийн Био аюулгүй байдлын II зэрэглэлийн барилгын газрыг шийдвэрлэн АЗДТГ-ын худалдан авах ажиллагааны газарт барилга угсралтын тендэр 4 удаа зарлагдаж Этүгэн жим ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна.	100	
<b>Арга хэмжээ 4.1.6.</b> Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд БОЭТөв болон бусад эмнэлгүүдийг нэн шаардлагатай тоног төхөөрөмж, багаж зориулалтын тавилга хэрэгслээр хангах, засварлах	Орон нутгийн төсөв 2,121.60 тб төгрөг	Ажлын гүйцэтгэлийн хувь	75	85	2024 онд Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар нийт 7 худалдан авалт төлөвлөгдсөнөөс 4-р улирлын байдлаар бүх тендер зарлагдаж, үүнээс 6 ажил амжилттай гэрээ хийгдэн нийлүүлэгдсэн байна. Үүнд: -БОЭТ-н эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг илрүүлэх сүүлийн үеийн суурин ЭХО аппарат ("Мед импекс" ХХК шалгарч 6-р сарын 11-нд Төрөх эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг тодорхойлох боломжтой шинэ технологийн samsung V8 загварын ЭХО аппаратыг хүлээн авч комисс ажилласан. Ингэснээр орон нутагт ургийн гажгийг тодорхойлох бусад нарийн шинжилгээг хийх боломжтой	100	

					<p>болж байгаа юм. Ашиглалтад орсноос хойш 1930 эмэгтэй тус аппаратаар ЭХО оношилгоонд орсон байна)</p> <p>-БОЭТ-ийн ходоодны дуран, принтер, дагалдах нэг удаагийн хэрэгслийн хамт (6-р сарын 11-нд “Мед импекс”ХХК гэрээний дагуу 89.463.000 төгрөгийн төсвөөр БОЭТ-ийн дурангийн кабинетад olumpus HQ-190 маркын ходоодны дуранг, дагалдах нэг удаагийн хэрэгслийн хамт хүлээн авч комисс ажилласан. Тус дуран нийлүүлэгдсэнээр БОЭТ 3 ээлжийн ходоодны уян дурантай болж иргэдийн оношилгоонд хамрагдах хүлээгдэл багассан. 2024 оны 8-р сараас хойш нийт 310 хүн дурангийн оношилгоонд орсон байна)</p> <p>-Умайн хүзүүний хавдрыг эрт оношлох хиймэл оюун ухааны аппарат Гурвантэс СЭМТ-д (“Сүвэн-уул” ХХК шалгарч 2024 оны 11-р сард 49.026.000 төгрөгийн төсвөөр умайн хүзүүний хавдрыг эрт үед нь илрүүлэх хиймэл оюун ухааны аппаратыг Гурвантэс СЭМТ-д нийлүүлж ашиглалтад өгсөн)</p> <p>-Сумдын ЭМТ-үүдэд шаардлагатай эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжүүд (“Мехатроник” ХХК шалгарч 400.000.001 төгрөгийн гэрээ хийсэн ба 2024 оны 10-р сарын 9-ний өдөр ЭМБ-уудад хүлээлгэн өгсөн. 14 ЭМБ-д нийт 33 нэр төрлийн 64ш эмнэлгийн тоног төхөөрөмжийг ЭМГ-ын даргын тушаалын дагуу хуваарилан өгсөн. Гэрээний дагуу ариутгалын гэрлийг техник үзүүлэлтэд нийцүүлж өгөхөөр албан тоот ирүүлсэн байгаа)</p> <p>-Сэврэй, Баяндалай, Хүрмэн сумдын ЭМТ-д шаардлагатай эмнэлгийн болон сургалт, гал тогооны тоног төхөөрөмж, тохижилтод шаардлагатай тавилгууд (“Космос тек”ХХК шалгарч гэрээ хийгдсэн. Нийт төсөв 618 сая. Хүрмэн СЭМТ-д 247.017.911 төгрөгийн төсвөөр нийт 59 нэр төрлийн 214 ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Баяндалай СЭМТ-д 140.363.830 төгрөгийн төсвөөр нийт 35 нэр төрлийн 79 ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Сэврэй СЭМТ-д 230.618.259 төгрөгийн төсвөөр нийт 87 нэр төрлийн 296ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлэгдсэн байна)</p> <p>-Сэврэй сумын ЭМТ-д зөөврийн рентген аппарат нийлүүлэгдэн ашиглалтад орсон байна (“Био реагент” ХХК</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>94 сая төгрөгийн төсвөөр зөөврийн рентген аппаратыг Сэврэй СЭМТ-д 2024 оны 5-р сард нийлүүлсэн)</p> <p>-Шүдний төвд шаардлагатай тоног төхөөрөмж 50 сая төгрөгийн төсөвтэй ажил нь оролцогч орж ирэхгүй байгаа учир дахин тендер зарлагдаад явж байна.</p> <p>-Нэмэлтээр аймгийн онцгой комиссоос -189,745,000 БОЭТ-ийн гемодиализийн тасагт нэн шаардлагатай байгаа диализийн аппарат болон усны систем, мөн ангиографын аппаратыг байнгын хэвийн ажиллагаанд оруулахтай холбоотой худалдан авалтыг хийхээр төсвийг аймгийн онцгой комиссоор шийдвэрлүүлж худалдан авалт амжилттай зохион байгуулагдаж ашиглалтад орсон.</p> <p>-БОЭТ-ийн лабораторийн тасагт Элэгний В,С вирусийн идэвхжил тоолох болон бэлгийн замын далд халдвар илрүүлэх шинжилгээг хийх боломжтой ПСР аппаратыг хүлээж аван, ашиглалтад оруулсан. “Антиген” ХХК нийт 110 сая төгрөгөөр нийлүүлсэн.</p> <p>“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар 172,700,000, БОЭТ-ийн угаалгын хэсэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд зориулалтын угаалгын машин-2ш, Хатаагч-2ш, бул индүү болон уурын индүү тус тус 1-ш мөн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн. 928,884,000-БОЭТ, ЗӨСТ, ЭМГ-т шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд сургалтын тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн.</p>	
<p><b>Арга хэмжээ 4.1.7.</b> Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж</p>	Орон нутгийн төсөв	Цахилгааны нөөц эх үүсвэрээр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	18	20	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумдын эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 2024 онд Номгон, Сэврэй сумдын ЭМТ-ийг 220/380В-ийн 5,5-6 КВт хүчин чадал бүхий дизель хөдөлгүүрээр тус тус хангаж, ашиглалтад оруулсан. Ингэснээр БОЭТ, 14 сумын Эрүүл мэндийн төвүүд, 3 Өрхийн эрүүл мэндийн төв цахилгаан тасарсан үед найдвартай нөөц цахилгааны эх үүсвэрээр бүрэн хангагдсан.</p> <p>Мөн бүх эрүүл мэндийн байгууллагуудтай цахимаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотой зөвлөмж, мэдээлэл өгсөн. БОЭТ, Цогтцэций, Ханбогд,</p>	100	

<p>дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг хангуулах</p>					<p>Номгон сумдын эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналтаар ажиллан холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн.</p>	
<p><b>Арга хэмжээ 4.1.8</b> Алслагдсан бүс нутаг дахь хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зорилгоор Багийн эмч нарыг автомашинаар ханган, шатахууны зардлыг шийдвэрлүүлэх</p>	<p>Орон нутгийн төсөв</p>	<p>Автомашин, шатахуунаар хангагдсан багийн эмч нарын тоо</p>	<p>-</p>	<p>гүйцэтгэл ээр</p>	<p>- Улсын онцгой комиссоос Булган сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах хүрээнд 2,0 сая төгрөгийн шатахууны дэмжлэг үзүүлсэн.</p>	<p>100</p>
<p><b>Арга хэмжээ 4.1.9.</b> Сумдыг холын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашинаар хангах /Эрүүл мэндийн газар, ЗӨСТ, 6 СЭМТ /</p>	<p>Улсын төсөв 950.00 сая төгрөг, Орон нутгийн төсөв 1,280.00 тб төгрөг</p>	<p>Автомашинаар хангагдсан ЭМБ-ын тоо</p>	<p>7</p>	<p>8</p>	<p>- Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар сумдыг ойрын болон холын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашинаар хангах нийт төсөвт өртөг 1,280,000,000/нэг тэрбум хоёр зуун наян сая/, Багц-1: Эмнэлгийн түргэн тусламжийн автомашин- 1ш /Landcruiser-76/, Эмнэлгийн түргэн тусламжийн тоноглогдсон автомашин-4ш /Landcruiser 78/ төсөвт өртөг: 1,040,000,000 /Нэг тэрбум дөчин сая/ төгрөг, Багц-2: Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай туулах чадвар сайтай автомашин /Landcruiser 300 GX-R Leather/ төсөвт өртөг: 240,000,000 /Хоёр зуун дөчин сая/ төгрөг байхаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна. - 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 680 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн Landcruiser 78 автомашиныг Булган, Ханхонгор, Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвд, -Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 71,800,000 сая төгрөгийн үнэ бүхий УАЗ-Фургон автомашиныг Эрүүл</p>	<p>95</p>

						мэндийн газарт, ЭМЯ-с Герман үйлдвэрийн Men маркын түргэн тусламжийн алсын дуудлагын бүрэн тоноглогдсон автомашиныг БОЭТ-д тус тус хүлээлгэн өгсөн. Автомашинаар хангагдсан ЭМБ-ын тоо-5 Худалдах авах ажиллагааны төндөр зарлагдсан-8	
<b>Зорилт 4.2. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах, удирдах ажилтнуудыг чадавхжуулах</b>							
он 4.2	<b>Арга хэмжээ 4.2.1.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөө боловсруулж батлуулах	Орон нутгийн төсөв	Төлөвлөгөө боловсруулсан байх	-	1	Төрөөс баримтлах урт хугацааны бодлого, Засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны төлөвлөгөө, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан 2025 онд хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.	80
	<b>Арга хэмжээ 4.2.2</b> Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх	Орон нутгийн төсөв	Хүчин чадал нэмэгдүүлсэн ЭМБ-ын тоо	-	1	-Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Сэргээн засах, уламжлалтын 40 ортой эмнэлгийн барилга 95 хувийн гүйцэтгэлтэй 2024 оны 12 сарын 20-нд улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Эмнэлгийн бүтэц зохион байгуулалтыг нэн яаралтай шийдвэрлэж төрийн болон орон нутгийн өмчит байгууллага үүсгэх тухай хүсэлтийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. -Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд архи, согтууруулах ундааны хамаарал бүхий иргэдэд биеийн болон сэтгэлзүйн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Итгэлтэй амьдрал” төв 10 ортой наркологийн эмнэлэг шинээр байгуулж үйл ажиллагааг эхлүүлсэн. -2023 онд байгуулагдсан “Говь дент” УТҮГ-ыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 19/02 дугаар тогтоолоор “Говь дент анхны цахиур” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчилсөн.	100

	<p><b>Арга хэмжээ 4.2.3</b> Эрүүл мэндийн байгууллагуудыг эцэг эхийн зөвлөлтэй болгох, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүүхдийн өрөөтэй болгох</p>	Орон нутгийн төсөв	Хүүхдийн өрөөтэй болсон ЭМБ-ын тоо	1	10	<p>Өмнөговь аймаг 2024 оныг “Хамгаалагдсан ирээдүй” хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын 02 албан даалгаврын хүрээнд аж ахуй нэгж, албан байгууллагуудыг хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллах чиглэлийг үүрэг болгосон. 20 эрүүл мэндийн байгууллага бус бүр эцэг эхийн зөвлөлтэй чиглэлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна, Эрүүл мэндийн газар, 5 сумын эрүүл мэндийн төв хүүхдийн өрөөг шинээр байгуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	100
	<p><b>Арга хэмжээ 4.2.4</b> Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоог дэмжих, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг үе шаттай зохион байгуулах</p>	Орон нутгийн төсөв	Сургалт, арга хэмжээ зохион байгуулсан тоо	-	гүйцэтгэл ээр	<p>-Өмнөговь аймаг 2024 оныг “Хамгаалагдсан ирээдүй” хүүхдийн хөгжил, хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газартай хамтран байгууллагын дотоод сургалтаар хүүхдийн хөгжилд эцэг, эхийн үүрэг оролцоо хэрхэн нөлөөлдөг, хүүхдүүдийн нас болон сэтгэл зүйн онцлогийн талаар 28 албан хаагчдад “Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан.</p> <p>-Мөн “Говь дент” шүдний төв хүүхэд хамгааллын жилтэй холбогдуулан 533 хүүхдэд амны хөндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж ажилласан.</p> <p>-Хүүхдийн эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/185 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, хүүхдэд ээлтэй орон нутаг санаачилгыг дэмжих зорилгоор “Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээг байгууллагын эцэг, эхийн зөвлөлтэй хамтран 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдөр Эрүүл мэндийн газрын сургалтын өрөөнд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд байгууллагын нийт албан хаагч, ажилчдын 0-18 насны 32 хүүхэд оролцсон.</p> <p>-Сум, өрхийн эрүүл мэндийн 17 байгууллагын 51 эмч, мэргэжилтэн нарт цахимаар мэдээлэл хүргэж, “Хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгуулах, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, байгууллагын эцэг эхийн зөвлөлийг идэвхжүүлэх чиглэлийг өгч ажилласан.</p> <p>-“Хамгаалагдсан ирээдүй” хүүхдийн хөгжил хамгааллын жилийн хүрээнд сум бүрд эрсдэлт бүлгийн хүүхдүүдтэй ажиллах Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн</p>	100

					<p>ажилтанг гэрээгээр ажиллуулж, ажилтнуудаа чадавхжуулах сургалтыг танхимаар болон цахимаар 5 удаа зохион байгуулсан. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт нөлөөллийн арга хэмжээг 18 эрүүл мэндийн байгууллагууд 65 удаа зохион байгуулж нийт 3520 өсвөр үе, сурагчдыг хамруулж мэдлэг хандлагыг нэмэгдүүлэн ажилласан байна. Өсвөр үе, үе тэнгийнхнээр дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгох тогтолцоог бэхжүүлж, зөв дадалтай эрүүл иргэнийг бага наснаас эхлэн төлөвшүүлэх зорилгоор өсвөр үеийн сургагч багш бэлтгэх сургалтыг аймгийн ЗДТГ, НБХ, ЭМГ, МГБССН-тэй хамтран Даланзадгад сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн 20 сурагч нарыг бэлтгэн аймгийн хэмжээнд нийт 22 сургуулийн 208 өсвөр үеийн хүүхдүүдэд сургалтыг зохион байгуулсан байна. сургалт зохион байгуулснаар үе тэнгийн сурагчдад чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагаанд сурагчдын оролцоо, хамтын ажиллагааг сайжирсан ба Өсвөр үеийн сургагч багшаар дамжуулан үе тэнгийнхэнд эрүүл мэндийн боловсрол хүргэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй, оновчтой зохион байгуулж, тэдний ур чадвар, ёс зүйн хэм хэмжээ, хийх үйл ажиллагаа зэргийг танилцуулж сайн туршлагаас суралцсан гэх мэт үр дүнтэй байсан.</p> <p>-Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд, бэлгийн болон НҮЭМ-ийн талаар үе тэнгийн 150 сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Мөн хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг 10 сумын 14902 хүүхдэд хүрч хүргэж, 297 хүүхдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>-Ерөнхий боловсролын 10 сургууль, 1 политехник коллежийн 6-12 дугаар ангийн нийт 1350 сурагчид “Тамхи хэрэглээний өнөөгийн байдал, Янжуур ба электрон тамхины хор хөнөөл” сэдвээр танхимын сургалт зохион байгуулж ажилласан.</p> <p>Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам хамтран 2022-2023 онд “Боловсролын орчин дахь хүүхдийн эрх, хамгаалал, эрүүл мэндийн зан үйл”-ийн тандалтын судалгааны үр дүнд үндэслэн мэдээллийг бэлтгэж Ханбогд сумын 400 сурагчид хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан.</p>	
--	--	--	--	--	---	--

	<p><b>Арга хэмжээ 4.2.5</b> Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох, албан ёсны яриа хэлэлцээ явуулахдаа “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг чанд мөрдөх, удирдамжийн төсөл, зардлын төсөв боловсруулж, Гадаад харилцааны яаманд хүргүүлж санал авах</p>	Улс, Орон нутгийн төсөв	Хуулийн хэрэгжилтийг хангах	-	гүйцэтгэл ээр	2024 онд гадаадад албан хэргээр зочлоогүй.	100
	<p><b>Арга хэмжээ 4.2.6</b> Иргэдэд эрүүл мэндийн зуучлах үйлчилгээг үзүүлэх Өмнөговийн иргэдэд зөвлөн зуучлах төвийг Улаанбаатар хотод байгуулна</p>	Орон нутгийн төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	гүйцэтгэл ээр	Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Өмнөговийн иргэдэд зөвлөн зуучлах төвийг Улаанбаатар хотод байгуулахад 500 сая төгрөгийг төсөв суугдсан ч төсвийн тодотголоор төсвийг хассан тус арга хэмжээ 2025 он хийхээр хойшлогдсон	95
	<p><b>Арга хэмжээ 4.2.7</b> Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам, Монгол улсын Засаг</p>		Хуулийн хэрэгжилтийг хангах	-	гүйцэтгэл ээр	2024 онд гадаадад албан хэргээр зочлоогүй	100



захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.						
--	--	--	--	--	--	--

**Зорилт 4.3 Эрүүл мэндийн байгууллагуудын төсөв санхүүгийн шинэчлэл, Эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлийн санхүүжилтийн системийг үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавих**

4.3	<b>Арга хэмжээ 4.3.1.</b> Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг үр дүнтэй хэрэгжүүлэх	Улсын төсөв	ЭМДаатгалаас санхүүжилт бүрэн авсан байгууллагын хувь	86,6	гүйцэтгэл ээр	14 сумын эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлд суурилсан санхүүжилт хагас жилийн байдлаар 458.4 сая орчим төгрөг авахаас 422,6 орчим сая төгрөг буюу тухайн сардаа нэхэмжилсэн дүнгийн дунджаар 92 хувьтай санхүүжигдэж байна.	92
	<b>Арга хэмжээ 4.3.2.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн төсөөлөл, төлөвлөлтийг байгууллагуудын эдийн засаг төсвийн судалгаа, нотолгоонд түшиглэн хийж, хэрэгжүүлэх, хуваарилах	Улсын төсөв	Төлөвлөлт судалгаа, хуваарилалт	1 1 1	2 2 2	Эрүүл мэндийн салбарын 2025 оны төсвийн төсөөллийг БОЭТөв, ЗӨСТөв, ЭМТөв, ӨЭМТөвүүд зэрэг 20 байгууллагуудыг байгууллага тус бүрээр пискал программд шивж, нэгтгэн 2024 оны төсвөөс 23.1% нэмэгдүүлсэн төсвийг Эрүүл мэндийн яаманд тайлагнасан. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг байгууллагын шилэн дансны хуулийн хугацаанд цахим системд мэдээллийг байршуулж, ил тодын мэдээллийн самбарт байршуулж мэдээллэж ажилласан.	100
	<b>Арга хэмжээ 4.3.3.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, мэдээлэл, тайлагналтыг хугацаанд хийж,	Улсын төсөв	Тайлагналт	14	20	2023 оны аудитын байгууллагын дүгнэлтээр ЭМГ, ЗӨСТөв, СЭМТөвийн 12, нийт 14 байгууллага зөрчилгүй буюу өөрчлөлтгүй дүгнэлтийг авсан. хязгаарлалттай дүгнэлтийг 3 байгууллага буюу БОЭТөв, Цогт-Овоо, Манлай зэрэг эдгээр байгууллагууд авч, Сөрөг дүгнэлтгүй ЭМСалбарын тайланг нэгтгэж Эрүүл мэндийн яаманд тайлагнагдсан байна. 2022 оны Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтээс 82.36% нь өөрчлөлтгүй дүгнэлт авч мөн үеийнхтэй	100

аудитын хяналт, дүгнэлтийг гаргуулан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах					харьцуулахад 11.77% өссөн үзүүлэлттэй байна. Аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг Эрүүл мэндийн яаманд албан тоот, нотлох баримтын хамт нэгтгэн тайлагнасан мөн төрийн аудитын газрын <a href="http://www.fas.audit.mn">www.fas.audit.mn</a> цахим хаягаар хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.	
<b>Арга хэмжээ 4.3.4.</b> Эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай зардал, дэмжлэгийг Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлэх	Орон нутгийн төсөв	Дэмжлэгт хамрагдсан ЭМБ-ын тоо	20	20	- “Говь оюу хөгжлийг дэмжих сан”-аас Сэргээн засах 40 ортой эмнэлгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авахад шаардлагатай 1,4 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлсэн.  - 2024 онд эрүүл мэндийн байгууллагуудад түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний зардалд нийт 4 тэрбум төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Мөн Аймгийн засаг даргын нөөц сангаас яаралтай өвчтөнг Улаанбаатар хот руу хүргэх захирамжаар энэ онд 2 өвчтөнг хүргэсэн ба 38 сая төгрөгийг зарцуулсан.	100
<b>Арга хэмжээ 4.3.5.</b> Эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн хүрээнд чанартай зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тоо	12	Гүйцэтгэл ээр	2024 онд Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар нийт 7 худалдан авалт төлөвлөгдсөнөөс 4-р улирлын байдлаар бүх тендер зарлагдаж, үүнээс 6 ажил амжилттай гэрээ хийгдэн нийлүүлэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн урологи-андрологийн кабинетэд орон нутгийн төсвөөс 19,8 сая төгрөгт нэн шаардлагатай байгаа “Ивэрхий судас андрологийн оношилгооны 8-н нэр төрлийн багаж, хэрэгсэл” худалдан авах ажиллагааг зохион байгуулан, үнийн санал авч “Өлзий дэн” ХХК шалгарсан. Хүлээж авах комисс ажиллахад ТТ-ийн жагсаалтад байгаа иж бүрдлээс 1 хувиргагч дутуу учир бүрдүүлж авахаар хугацаа сунган шийдвэрлэсэн.	100
<b>Арга хэмжээ 4.3.6.</b> Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл тусламж, олон улсын	Төсөл, хөтөлбөр	Зохион байгуулсан арга хэмжээ, санхүүжилт төгрөг	-	Гүйцэтгэл ээр	Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан. ХБГүйцэтгэл 2022-2025 онд Нэгдсэн хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган санхүүжилтийн 60 хувь болох 600,0 сая төгрөгийн санхүүжилтийг авч Төрийн болон орон нутгийн	100

	байгууллагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн хамтран ажиллах					өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу тоног төхөөрөмж болон удирдамж, хөтөлбөрийн дагуу 23 төрийн сургалт, худалдан авалтыг зохион байгуулан нийт 554,1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийн мэдээллийг шилэн дансанд байрлуулан ажиллаж байна.	
	<b>Арга хэмжээ 4.3.7.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын өр авлагын байдалд хяналт тавих, Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцох	Орон нутгийн төсөв	Тайлагналт	-	Гүйцэтгэл ээр	Эрүүл мэндийн салбарын 17 байгууллагын санхүүгийн тайланг 19 төрлийн тайлангийн батлагдсан маягтын дагуу Эрүүл мэндийн яаманд нэгтгэн тайлагнасан. Санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтийг мөн үеийнхтэй харьцуулахад Санхүү байдлын тайлан 1.4 % буурсан, Орлого үр дүнгийн тайлан 2.4 % буурсан, Мөнгөн гүйлгээний тайлан 1.1% буурсан, Өмчийн өөрчлөлтийн тайлан 9.6% өссөн, эргэлтийн хөрөнгө 6.6 тэр бум буюу 2.5 хувиар буурсан, эргэлтийн бус хөрөнгө 61.8 тэр бум буюу 1.2% өссөн, өр 3.1 тэр бум буюу 28% өссөн, авлага 267.5 сая буюу 64% өссөн үзүүлэлтэй байна. Хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэ зөв гаргаж гүйцэтгэлийг е-тайлангийн онлайн программд тайлагнаж, баримтын иж бүрэн байдалд хяналт тавих, хагас жилийн санхүүгийн тайланг гарган тайлагнасан	100
<b>Стратегийн зорилго 5. Эрүүл мэндийн цахим системийг хөгжүүлж, үйлчилгээний шуурхай байдал, эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх</b>							
<b>Зорилт 5.1</b> Эрүүл мэндийн салбарт телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг ашиглан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, цахим үйлчилгээг өргөжүүлэн, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ							

	<p><b>Арга хэмээ 5.1.1.</b> Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно.</p>	Улсын төсөв	Интернэт сүлжээнд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо	20	гүйцэтгэл ээр	<p>Сум өрхийн 20 ЭМБ өндөр хурдны шилэн кабелд холбогдсон байна.</p> <p>Интернэт сүлжээнд холбогдсон эрүүл мэндийн байгууллагын тоо-20</p>	100
	<p><b>Арга хэмээ 5.1.2.</b> Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлэн техник тоног төхөөрөмжөөр хангана.</p>	Орон нутгийн төсөв	Телемедицин ашиглаж байгаа ЭМБ-н тоо	1	гүйцэтгэл ээр	<p>Бүх сумдын эмнэлэг шилэн кабелд бүрэн холбогдсон бөгөөд Нийт 20 байгууллага телемедицин ашиглаж байна. Үүнээс 5 байгууллагад орон нутгийн зардлаар телемедицины тоног төхөөрөмжийг олгосон. Сард дунджаар 2-3 удаагийн цахим хурал, 10-15 удаагийн цахим сургалт зөвлөгөөнийг зохион байгуулаад байна.</p> <p>ЭМБ телемедицинийг эмчилгээ, зөвлөгөө авах теле сургалт болон БОЭТ-д мнКардио программ, дүрс оношилгооны PACS цахим системийг ашиглаж байна.</p> <p>Найдвартай интернэтийн сүлжээ нэвтрүүлсэн авсан ЭМБ-н тоо -20 төсвийн байгууллага + хувийн хэвшил 111</p>	100
5.1	<p><b>Арга хэмээ 5.1.3.</b> Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл</p>	Улсын төсөв	<p>Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо</p> <p>Хяналтын тоо</p>	-	гүйцэтгэл ээр	<p>БЭОТ-д эмчилгээ, үйлчилгээг явуулахад шаардлагатай сервер, галт хана/firewall/, нууцлалтай сүлжээгээр/vpn/ хангагдсан, албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжид вирусийн эсрэг программ, нууц үг суулгаж, интернэт сүлжээнд хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>БОЭТ-д дэмжлэгт хяналтыг 1 удаа хийж зөвлөмжөөр хангасан.</p>	100

<p>мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж ажиллана</p>						
<p><b>Арга хэмжээ 5.1.4.</b> Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Эрсдэлийн үнэлгээ Зөвлөмжийн тоо</p>	<p>-</p>	<p>1 1</p>	<p>Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолоор Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төв орсон. 2024 онд тус байгууллагад дэмжлэгт хяналт үнэлгээг зохион байгуулан Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх зөвлөмжийг хүргүүлсэн. БОЭТ-нь 10 сард Тагнуулын ерөнхий газарт Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хүсэлтийг хүргүүлсэн.</p>	<p>100</p>
<p><b>Арга хэмжээ 5.1.5.</b> Эрүүл мэндийн яамны Цахим эрүүл мэндийн удирдах хорооны шийдвэрийг үндэслэн, албан ёсны программ хангамж, цахим системийг эрүүл мэндийн байгууллагад ашиглуулах, ашиглалтад хяналт тавьж ажиллана.</p>	<p>Улсын төсөв</p>	<p>Улс хувийн хэвшлийн байгууллагад ашиглагдаж байгаа программ хангамжийн судалгаа, дүгнэлт, зөвлөмж</p>	<p>0</p>	<p>1</p>	<p>Эрт илрүүлэг хийж байгаа БОЭТ-“E-Health, 17-сум өрхийн эрүүл мэндийн байгууллага. vhs.hinfo.mn программыг 100 хувь ашиглаж үзлэгийн мэдээгээ оруулж байна.</p> <p>Статистик мэдээ мэдээллийн хүрээнд эрүүл мэндийн салбарын СЭМТ-14, ӨЭМТ-3, БОЭТ-1 хувийн хэвшлийн 22 эмнэлэг, цэргийн ангийн 3 эмнэлэг, “h info” программыг 100 хувь ашиглаж байна.</p> <p>Эрүүл мэндийн газарт аймгийн хэмжээний халдварт өвчний мэдээлэл бүртгэх “e-war” программыг ашиглаж ЭМБ-ууд сарын мэдээний хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим программыг тус тус ашиглаж байна.</p> <p>Томуугийн үндэсний төвийн flu.mn программыг анхан шатны 17 ЭМБ-ууд бүрэн ашиглаж байна.</p>	<p>100</p>

						<p>Нийт эрүүл мэндийн салбарын статистик мэдээ мэдээлэлд-5 программ ашиглаж байна.</p> <p>E-Health Программын хөгжүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд санал дүгнэлтийг 1 удаа хүргүүлсэн.</p>		
	<p><b>Арга хэмжээ 5.1.6.</b> Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлзүйн “E-Health”, “E-Hospital” программ хангамжийн ашиглалтыг сайжруулж тасралтгүй байдлыг хангана.</p>	Улсын төсөв, хандив дэмжлэг	<p>Танхимын сургалт</p> <p>Онлайн сургалт</p> <p>Ажлын байран дээрх сургалт</p> <p>Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо</p>	1	2	<p>10</p> <p>4</p> <p>3</p> <p>30</p> <p>60</p>	<p>“E-Hospital” программ хангамжийн ашиглалтыг сайжруулах танхимын сургалтыг нийт статистикч эмч нарт 1 удаа зохион байгуулж нийт эмнэлгүүдийн 21 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан боловч тухайн программ ашиглагдахгүй болсон.</p> <p>Сумын эрүүл мэндийн төвүүд болон өрхийн эрүүл мэндийн төв нь H-info программ болон Health.gov.mn программыг өдөр тутамдаа ашиглаж байна.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төв 2015 оноос хойш E-health программ ашиглан амбулаторийн бүх хэсгүүд холбогдон мэдээллийг цахимаар дамжуулан сан үүсгэн үйл ажиллагаа жигдрэн ажиллаж байна. цаашид тус программыг хөгжүүлж сайжруулах саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн.</p> <p>Программын сургалтыг Номгон, Булган сумдад ажлын байран дээр 2 удаа тус тус зохион байгуулж 2 сумын 12 хүн хамрагдсанаар Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумуудад эрт илрүүгийн ажлын программ хангамж болох E-Health системийн сургалтыг нийт 24 эмч, мэргэжилтнүүдэд орсон. Танхимын сургалтын тоо 1, Онлайн сургалт 4, ажлын байран дээрх сургалт 5, Хамрагдсан хүн 104.</p>	100

	<p><b>Арга хэмжээ 5.1.7</b>  Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл, технологийн техник хангамж, тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай засвар үйлчилгээг хийх, сүлжээ, хэрэглээний программын ашиглалтад хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангах</p>	-	<p>Завсар үйлчилгээ хийсэн тоног төхөөрөмж тоо</p> <p>Арга зүйгээр хангасан ЭМБ байгууллагын тоо</p>	-  18	Гүйцэтгэл ээр  25	<p>Эрүүл мэндийн байгууллагууд вирусийн программ 100 хувь ашиглаж байна.</p> <p>ЭМГ-ын 30 албан хаагч, 20 ЭМБайгууллагын дарга, эрхлэгчид төрийн албаны цахим шууданг албан хэрэгцээнд ашиглаж байна.</p> <p>20 эрүүл мэндийн байгууллага тоон гарын үсгийн эрх нээлгэсэн.</p> <p>Бүх эрүүл мэндийн байгууллагууд найдвартай өндөр хурдны сүлжээнд холбогдсон бөгөөд нууцлал бүхий VPN сүлжээний бэлэн байдлыг хангасан байна.</p> <p>БОЭТөв e-health, өрх, сумдын эрүүл мэндийн төв health.gov.mn системийг үзлэг оношилгоо, тусламж үйлчилгээний бүртгэл, хэрэглээнд ашиглаж байна.</p> <p>Нийт 12 эмб-ын 28 компьютер, 12 хэвлэлийн тоног төхөөрөмж, 4 байгууллагын интернэт дотоод сүлжээний засвар, үйлчилгээг хийсэн.</p> <p>Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хүүхдийн эрт илрүүлгийн мэдээг оруулах vhs.hinfo.mn системийг оруулж байгаа бөгөөд 17 өрх, сумдын эрүүл мэндийн байгууллагууд ашиглаж байна.</p>	100
<p><b>Зорилт 5.2</b> Орон нутгийн түвшинд эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог тогтвортой хөгжүүлж, мэдээний сан бүрдүүлж, эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн үзүүлэлтийн цаашдын чиг хандлагыг тодорхойлно.</p>							

5.2	<p><b>Арга хэмжээ 5.2.1.</b> Эрүүл мэндийн статистик мэдээллийг урсгалын дагуу, хугацаанд нь чанартай нэгтгэн дамжуулах, нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн хамрагдалт, үнэн зөв, шуурхай байдлыг хангана.</p>	Улсын төсөв	<p>12 сарын мэдээлэл</p> <p>Хувийн хэвшлийн байгууллагын хамралт</p>	<p>12</p> <p>93,</p> <p>4</p>	<p>12</p> <p>100</p>	<p>Эрүүл мэндийн статистик мэдээг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тушаалын дагуу Сарын мэдээ-12 удаа, эх хүүхдийн тандалтын мэдээ-7 хоног бүр 52 удаа, халдварт өвчний мэдээ тохиолдол гарах бүрд-48 удаа, осол гэмтлийн мэдээ сар бүр 12 удаа, ТТӨ мэдээ- 7 хоног бүр 52 удаа, хоног тутмын мэдээг 2024 оны 09 сарын 01-ээс эхлэн өдөр бүр, холбогдох дээд байгууллагад хүргүүлж байна.</p> <p>Мэдээг Бүсийн оношилгоо эмчилгээний төв-1 Сум, өрхийн эрүүл мэндийн төв-17, 34-хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Эмийн сан-50, нийт 102 эрүүл мэндийн байгууллагаас авч нэгтгэн хянаж хүргүүлсэн.</p> <p>Статистикч эмч нарын мэдлэг чадварыг сайжруулах танхимын сургалтыг 1 сард 20 хүнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>Уг сургалтаар статистикийн алдааг залруулах, хууль эрх зүй, нууцын тухай хууль, мэдээ мэдээллийн чанарын талаарх мэдээллүүд өгөгдсөн.</p> <p>ЭМХТ-с VHS программ хангамжийн ашиглалтын талаарх цахим сургалтыг зохион байгуулж, өрх сумдын эмнэлгүүдийн эмч мэргэжилтэн 25 хүнийг хамруулсан ба хүүхдийн эрт илрүүлгийг идэвхжүүлж программ ашиглалтыг эхлүүлсэн.</p>	100
	<p><b>Арга хэмжээ 5.2.2.</b> Мэдээллийн тогтолцоонд ажиллагсад, статистикч эмч нарыг танхимын болон ажлын байрны дагалдан сургалт, сэлгэн ажиллуулах зэргээр мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлэх</p>	Улсын төсөв, хандив дэмжлэг	<p>тасралтгүй сургалтын тоо, статистикчийн тоо</p> <p>Ажлын байрны дагалдан сургалтад хамруулсан шинэ мэргэжилтний тоо</p>	<p>2023 онд 19 статистикчийг тасралтгүй сургалтад</p> <p>4 хүнийг ажлын</p>	<p>Танхимын сургалт 3 удаа -60 хүн</p> <p>Ажлын байрны дагалдан сургалт 2 хүнийг</p>	<p>Хүрмэн сумын статистикч, Тэгш дүүрэн хувийн эмнэлгийн эмчийг ажлын байрны дагалдан сургалтыг 3 өдөр зохион байгуулж.Говьдент, Энх, Итгэл зэрэг хувийн эмнэлгүүдэд ажлын байранд болон цахимаар hinfo программыг зааж сарын мэдээ болон баазын алдааг засах талаар заавар зөвлөгөөг өгсөн.</p> <p>Эрүүл мэндийн газарт статистикч эмч болон мэдээний сан хариуцсан ажилтны ажлын байрны дагалданг 14 хоног хийж цаашид мэдээг хариуцан ажиллаж байна.</p> <p>ГССҮТ-ын осол гэмтлийн тандалтын албанаас осол гэмтлийн шалтгааны код сургалтыг цахимаар зохион байгуулсан. Тус сургалтад 18 эрүүл мэндийн байгууллагын 20 статистикч эмч нар хамрагдаж мэдээний баазыг оношлын зөрүүгүй мэдээлэх мэдлэг чадварыг дээшлүүлсэн.</p>	100



			хамрагдсан статистикч эмчийн тоо	байрны дагалдан сургалтад		Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны дэмжлэгт удирдлагаар хангах, сургалт зохион байгуулсан. сургалтаар программ хангамж, жилийн эцсийн тайлан үзүүлэлт чиглэлээр Бүсийн оношилгоо эмчилгээний төв-2, эрүүл мэндийн газрын-2 ажилтан ажлын байрны дагалдан сургалтад, цахимаар 17 эрүүл мэндийн байгууллагын статистик эмч нар тус тус хамрагдсан.	
	<b>Арга хэмжээ 5.2.3.</b> Мэдээллийн тогтолцоонд шинээр ажиллагсад болон шинэ мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Улсын төсөв	Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо	шинэ мэргэжилтэн 30	шинэ ажилтны сургалт 1 удаа	Эрүүл мэндийн байгууллагуудад шинээр ажилд орсон шинэ эмч, мэргэжилтнүүдийг чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан тус сургалтаар багаар ажиллах чадварт суралцах, эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээ гаргах, эмнэлгийн ажилтны ёс зүй харилцаа хандлага чиглэлээр Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв, Зоонозын өвчин судлалын төвийн 40 гаруй эмч, мэргэжилтнүүд хамрагдсан.  Эрүүл мэндийн газрын бүртгэл мэдээллийн ажилтан шинээр томилогдсонтой холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэргэшил олгох 3 сарын сургалтад хамрагдаж амжилттай төгссөн.	100
	<b>Арга хэмжээ 5.2.4.</b> Эрүүл мэндийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээний санг баяжуулах, эргэн мэдээлэл, мэдээллийн товхимол ном гаргах	Улсын төсөв  Орон нутгийн төсөв	Эрүүл мэндийн мэдээлэлд хийсэн дүгнэлт	12	12	Сар бүр Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүгнэлт хийж сарын мэдээг 11 удаа дараа сарын 05-ны дотор гаргаж эрүүл мэндийн байгууллагууд болон орон нутгийн удирдлага төрийн байгууллагуудад дотоод сүлжээгээр хүргүүлсэн.  Сарын мэдээ-12 удаа, эх хүүхдийн тандалтын мэдээ-7 хоног бүр 52 удаа, халдварт өвчний мэдээ тохиолдол гарах бүрд-48 удаа, осол гэмтлийн мэдээ сар бүр 12 удаа, ТТӨ мэдээ- 7 хоног бүр 52 удаа, хоног тутмын мэдээг 2024 оны 09 сарын 01-ээс эхлэн өдөр бүр, холбогдох дээд байгууллагад хүргүүлж байна.  Эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтээр хүн амын өвчлөл, сэргийлж болох өвчлөл зэрэг зарим үзүүлэлтийн мэдээг	100

					<p>видео хэлбэрээр 4 удаа байгууллагын цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэсэн.</p> <p>Орон нутгийн хүн амын өвчлөл статистик мэдээг өдөр тутамдаа -18 үзүүлэлтээр, 7 хоногийн өвчлөлийн мэдээг-20 үзүүлэлтээр эрүүл мэндийн 18 байгууллагаас авч эргэн мэдээллэж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна.</p>		
		Эргэн мэдээлэл ном	4	4	<p>2024 оны улирлын эргэн мэдээллийн номыг улирал бүр өмнөх оны мөн үетэй харьцуулан 3 удаа гаргасан.</p> <p>3 улирлын эргэн мэдээллийн ном гаргаж дүгнэлт хийж хүргүүлсэн ба 4 дүгээр улирлын ном 2025 оны 01 сарын 05 нд буюу эрүүл мэндийн чанарын үзүүлэлт гарсны дараа гарна.</p>		
		Үзүүлэлтийн ном	0	1	<p>2003-2023 он хүртэлх эрүүл мэндийн 100 гаруй үзүүлэлтээр ном эмхэтгэл хийж тус бүр 100 ширхгээр хэвлүүлэн олны хүртээл болгохоос гадна эмнэлгүүдийн номын санд хуваарилан олгосон. Номын танилцуулга хийх өдөрлөгийг зохион байгуулж аймгийн удирдлагууд болон эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд 50 хүнийг хамруулав. Энэхүү статистик үзүүлэлтийн номонд олон тоон болон чанарын үзүүлэлтүүдийг өргөн хүрээтэй, тайлбартай, улс аймгийн үзүүлэлттэй харьцуулан, эрүүл мэндийн үзүүлэлтийг 2003-2023 оныг хамруулан 20 жилээр нэгтгэхээс гадна эрүүл мэндийн зарим үзүүлэлтийн хэрэглээ, ач холбогдлын түвшингээс хамаарч 30 жилийн хөдлөл зүй, өөрчлөлтийг харуулсан бол мэдээлэл авч эхэлсэн хугацаа, мэдээллийн сангийн олдцоос шалтгаалан 5-10 жилийн мэдээллээр хийсэн үзүүлэлтүүд орсон.</p>		
	<b>Арга хэмжээ 5.2.5</b> Эмч мэргэжилтний судалгааны ажлыг дэмжин, эрдэм судалгааны бага хурал зохион байгуулж,	Улсын төсөв	Эмч мэргэжилтний онол практикийн бага хурлын тоо	2	2	<p>Эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрч буй ололт амжилтыг мэдээлэх, эмч мэргэжилтнүүдийн судалгааны ач холбогдлыг сурталчлах, эрдэм шинжилгээний байгууллага, эмч судлаачдын хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилготой “Дэлхийн эмч нарын эрхийг хамгаалах өдрийн баяр”-ын тохиолдуулан эмч, эмнэлгийн дээд мэргэжилтнүүдийн дунд “ЭРДМИЙН ЧУУЛГАН-2024” онол практикийн бага хуралд зохион байгуулж 12 судалгааны</p>	100

судалгааны үр дүнг тархаана.					<p>бүтээл, 4 ховор тохиолдлын танилцуулга, 2 шинэ технологи, 1 сайн туршлага танилцуулагдан хэлэлцэгдсэн.</p> <p>2.Олон улсын сувилагчийн өдөрт зориулсан “үйлчлүүлэгчийн стандартад сувилагчийн манлайлал-2024” онол практикийн бага хурлыг зохион байгуулан 9 илтгэгч оролцсон.</p> <p>3. АШУҮИС-ийн Дорноговь салбар сургуулийн үе үеийн төгсөгчдийн дунд “хүн амын эрүүл мэндийн тулгамдсан асуудал ба шийдэл” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж 11 судалгааны бүтээл, 4 тохиолдлын танилцуулга хэлэлцэгдсэн байна.</p> <p>сүүлийн 10 жилийн эмч мэргэжилтний судалгаа шинжилгээний ажлыг эмхэтгэн “Эрдмийн товчоон” номыг эмхэтгэн 100 хувь хэвлэлтэд оруулж хэрэглэгчдийн хүртээл болгохоос гадна эмнэлгүүдийн номын санд хуваарилан олгосон. Тус бүтээлд эмч мэргэжилтнүүдийн 148 судалгааны ажлын хураангуй багтаж байгаа бөгөөд доктор, магистрын зэрэг хамгаалсан томоохон бүтээлүүд ч багтаж байгаа юм.</p> <p>Онол практикийн баг хурлын тоо-3</p> <p>Оролцсон илтгэгч судлаач эмч эмнэлгийн тусгай мэргэжилтэн-43</p> <p>Судалгаа шинжилгээний ажлын эмхэтгэл-1</p>	
<p><b>Арга хэмжээ 5.2.6</b> Мэдээллийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг дүгнэж зөвлөмжөөр хангах, ажил дүгнэх үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах</p>	Улсын төсөв	Дүгнэлт зөвлөмж	1	1	Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлэх журмыг шинэчлэн гаргаж эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Тус журмаар статистикч эмч нарын мэдээний үнэн бодит байдал, шуурхай байдал, эргэн мэдээлэл зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан.	100
		Боловсруулсан журам	0	1	Мэдээллийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг журмын дагуу дүгнэж, зөвлөмжөөр ханган ажилласан. Хангалттай сайн үнэлгээг 8 байгууллага, сайн үнэлгээг 9 байгууллага үнэлэгдсэн. Статистикийн мэдээг заагдсан хугацаанд дээд	

						шатны байгууллагад хүргэгдэж эргэн мэдээллэж ажиллаж байна. Статистикч эмчийн үйл ажиллагааг дүгнэх ЭМС-н тушаал шинэчлэгдэх гэж байгаатай холбогдуулан саналыг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн.	
<b>Зорилт 5.3</b> Эрүүл мэндийн байгууллагад хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг тогтмол хийж, тусламж үйлчилгээний тасралтгүй, чанартай байдлыг хангаж ажиллана							
5.3	<b>Арга хэмжээ 5.3.1.</b> Эрүүл мэндийн байгууллагад хийх хяналт үнэлгээний хуудас боловсруулах, үнэлгээний багыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Улсын төсөв	Хяналт үнэлгээний шинэчлэн боловсруулсан хуудасны тоо Сургалтын тоо		Үйл ажиллагааны чиглэл бүрээр 15 үнэлгээний хуудас боловсрогдсон байна.	Эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт үнэлгээг хийх хяналтын хуудсыг холбогдох чиглэлийн мэргэжилтэнгүүд хууль тогтоомжийн хүрээнд Удирдлага төлөвлөлт-бодлогын баримт бичиг, хүний нөөц, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт, статистик, халдвар хамгаалал, орчны эрүүл мэнд, техник тоног төхөөрөмж, сувилахуй тусламж үйлчилгээ, уламжлалт сэргээн засах, Эх, хүүхдийн тусламж үйлчилгээ, жирэмсний хяналтын чанар, товллолт үзлэгийн шинжилгээний чанар, Эмийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал чиглэлээр хяналтын хуудас боловсруулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.  Хяналтын хуудасны тоо-15	100
	<b>Арга хэмжээ 5.3.2.</b> Эрүүл мэндийн байгууллагад хяналт үнэлгээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтэд хяналт тавьж, зөвлөмжөөр хангах	Улсын төсөв	Хяналт үнэлгээ хийж зөвлөмжөөр хангасан байгууллагын тоо Өгсөн зөвлөмжийн тоо	17 байгууллага	Хяналт үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоогоор	Эрүүл мэндийн газрын 22 албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, ажлын байрны эмх цэгц, эмийн нөөц хадгалалт, вакцины нөөц хадгалалтад зэрэгт дотоод хяналт үнэлгээг 1 удаа хийж аргазүйн зөвлөгөөг өгсөн.  ЗӨСТ-10 ажилтан, 17 Эрүүл мэндийн байгууллагын 21 ажилтан, Эрүүл мэндийн салбарт шинээр ажилд орсон 45 ажилтанд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх журмын талаарх сургалт 1 удаа хийсэн.  Эрүүл мэндийн газрын даргын удирдамжийн дагуу дэмжлэгт хяналт үнэлгээний баг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Мандал-овоо, Номгон, Ноён, Ханхонгор, Хүрмэн, Ханбогд, Цогтцэций сумын эрүүл мэндийн төвүүд, Зоонозын өвчин судлалын төв, Тэгшдүүрэн, Аминбулаг	100

						<p>хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт үнэлгээг хийж 2023 оны зөвлөмжийн хэрэгжилтийг нотолгоонд тулгуурлан үнэлж аргазүйн зөвлөгөө өгч сайжруулах арга хэмжээг зөвлөмжөөр хүргүүлсэн.</p> <p>Цогтцэций сумын эрүүл мэндийн төвд иргэнээс ирсэн өргөдөл гомдлын дагуу хяналт хийж өргөдлийг шийдвэрлэсэн.</p> <p>Зөвлөмж тоо-11</p> <p>Хяналт үнэлгээ-12</p>	
	<p><b>Арга хэмжээ 5.3.3.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээг журмын дагуу үнэлж, зөвлөмжөөр хангах</p>	Улсын төсөв	ЭМБ-н гүйцэтгэлийн үнэлгээ Үнэлгээ зөвлөмж	2022 оны үнэлгээ, зөвлөмж	2023 оны үнэлгээ, зөвлөмж	<p>Эрүүл мэндийн газрын 2022 оны А/59 дүгээр тушаалын дагуу 17 эрүүл мэндийн байгууллагын 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үнэлгээг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хяналт үнэлгээгээр Манлай , Цогтцэций, Сэврэй СЭМТ, Шимбилэг, энхийн хүслэн ӨЭМТ, Ноён СЭМТ-үүд 88, 9-91,9 хооронд үнэлэгдсэн байна.</p> <p>Үнэлгээний мөрөөр СЭМТ, ӨЭМТ-д зөвлөмж 1 удаа хүргүүлсэн</p> <p>2024 оны үнэлгээ 2025 оны 1 дүгээр сард эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт гарсны дараа гарна.</p>	100
	<p><b>Арга хэмжээ 5.3.4.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх журам шинэчлэх</p>	Улсын төсөв	Шинэчилсэн журам	-	1	<p>Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудын үнэлэх журмыг шинэчлэн гаргаж эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.</p> <p>Шинэчилсэн журам-1</p>	100

	<b>Арга хэмжээ 5.3.5.</b> Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, шалгуурт үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах	Улсын төсөв	Үнэлгээ хийсэн байгууллагын тоо	1	3	Сум өрхийн 17 эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн үнэлгээг журмын дагуу 2024 оны 1 сард Удирдлага төлөвлөлт, хүний нөөц, эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдал, нийгмийн эрүүл мэнд, статистик гэсэн тусгай шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж эхний 4-н эрүүл мэндийн байгууллагын удирдлагыг цалингийн хувиар урамшуулах албан бичгийг сум орон нутгийн удирдлагуудад хүргүүлсэн.	100
			Сургалтын тоо	2	4	Бусад 13 эрүүл мэндийн байгууллагад ажил сайжруулах анхаарах талаарх зөвлөгөө зөвлөмж хүргүүлж ажилласан байна.  12 Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээг хийж 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт үнэлгээний багын үйл ажиллагаанд явцын хяналтыг хийж зөвлөмжөөр хангасан.  Цахимаар Засгийн газрын 301, 98 тушаалыг хэрэгжүүлэх талаарх сургалтад СЭМТ, ӨЭМТ, ЭМГ-ын албан хаагч нар 90 хувьтай хамрагдаж аргазүйн зөвлөгөөг 2 удаа өгсөн. Зоонозын өвчин судлалын төвийн гүйцэтгэлийн тайланг улирал бүр үнэлж үнэлгээ, зөвлөмж 3 удаа хүргүүлсэн.  17 Эрүүл мэндийн байгууллагын 21 ажилтан, Эрүүл мэндийн салбарт шинээр ажилд орсон 45 ажилтанд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх журмын талаарх сургалтыг тус бүр 2 удаа хийсэн.  Үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллага тоо-12  Сургалтын тоо -4	

**Зорилт 5.4.** Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилго бүхий дотоод аудитыг хийх

	<b>Арга хэмжээ 5.4.1.</b> Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийг хяналтад авах, и-оффис программ	Улсын төсөв	Хяналтад авсан бичиг баримтын тоо, И-оффис сургалтын тоо	Гүйцэт гэлээр	Хяналтад авсан тогтоол шийдвэр	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын хяналт үнэлгээг хийж 89,7 хувьтай үнэлэгдсэн. Хяналт үнэлгээний дүнд зөвлөмж	88,3
--	--	-------------	--	---------------	--------------------------------	--	------

5.4	ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авна/ ажлын байрны сургалт, дотоод хяналт/			Сургалтын тоо-1	гүйцэтгэлээр Ажлын байрны сургалт	ирүүлсний дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн. УИХ-ын тогтоол- 2, Монгол улсын хууль-3 Ерөнхийлөгчийн зарлиг-2 Засгийн газрын тогтоол-12 Засгийн газрын албан даалгавар-1 Сайдын тушаал-47 АИТХ-ын тогтоол-9 ЗДҮАХ-ийн заалт-26 Засаг даргын захирамж-1 Засаг даргын албан даалгавар-3 Дэд хөтөлбөр-5 Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний заалт-17 Бусад-2 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг оруулсан.	
	<b>Арга хэмжээ 5.4.2.</b> Хэлтэс нэгжийн төлөвлөлт тайлагналт, хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ зөвлөмж өгөх	Улсын төсөв	Үнэлгээ зөвлөмж	Хагас бүтэн жилийн хэрэгжилтэд үнэлгээ зөвлөмж өгсөн	Гүйцэтгэлээр	2023 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж удирдлагын багын хурлын тэмдэглэл хамт Эрүүл мэндийн яаманд 2024 оны 01 сард хүргүүлсэн.  2024 онд улирал бүр албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт үнэлгээг хийж байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг эрчимжүүлэх, үйл ажиллагааны дутагдалтай болон цаашид сайжруулж ажиллах чиглэлээр зөвлөмжийг 2 удаа хүргүүлсэн.  Зөвлөмж тоо-3	90
	<b>Арга хэмжээ 5.4.3.</b> Төсвийн ерөнхийлөн захирагч Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж салбар дундын хамтын ажиллагааг	Улсын төсөв	Төлөвлөгөө	1	1	Төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх заалтаар нь хэлтэс бүр хариуцан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	
			Тайлан	2	2	Хагас жилийн хэрэгжилтийг 06 сарын 15-ны дотор буюу гэрээнд заасан хугацаанд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын 23 үзүүлэлтээр хэрэгжилтийг тооцон хүргүүлсэн. 2024 оны жилийн эцсийн гэрээний	100

сайжруулах, хэрэгжилтийг тайлагнаж ажиллах					хэрэгжилтийг эмнэлгийн тусламж үйлчилгээ чанарын үзүүлэлт гарсны дараа буюу гэрээнд заасны дагуу 2025 оны 01 сарын 15-нд хүргүүлэхээр хяналт хийгдэж байна.	
<b>Арга хэмжээ 5.4.4</b> Байгууллагын ил тод байдлыг ханган веб хуудсыг цаг үеийн мэдээ мэдээллийг байршуулж ажиллах	-	Мэдээний тоо	-	гүйцэтгэл ээр	Om.mohs.gov.mn вэб хуудсанд 18 мэдээ, мэдээллийн санд 34 удаагийн шинэчлэлт хийсэн. Фэйсбүүк хуудсанд байгууллагын цаг үеийн мэдээг тухай бүр нь бэлтгэж 154 видео, 108 пост оруулсан.  Нийт давхардсан тоогоор 614.000 хандалт авсан байна.  Эрүүл мэндийн газрын даргын тушаал, шийдвэрийг PDF файл болгон сар бүр шилэн дансанд тогтмол байршуулснаас А тушаал 80 ширхэг, Б тушаал 92 ширхэг, нийт 172 ширхэг мэдээлэл болон 1835,9 сая төгрөгийн тушаал, шийдвэрийг Шилэн дансны тухай хуулийн хугацаанд цахим мэдээллийн системд оруулж мэдээллэсэн байна.	100
<b>Арга хэмжээ 5.4.5</b> Иргэн аж ахуй нэгж хуулийн этгээдээс ирсэн өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэнэ	-	Тайлан	31	гүйцэтгэл ээр	2024 онд нийт 31 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнд: Засгийн газрын 11-11 утсанд 24 70530001- утсанд -2  Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд утсаар хүсэлт-1  Бичгээр эмчилгээний төлбөрийн дэмжлэг хүссэн хүсэлт -1  Бичгээр гомдол-3  Мөн өргөдөл гомдлын тайланг 4 удаа улирал бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-т хүргүүлсэн.	100

**Стратеги зорилго 6. Салбарын хяналтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан хүний эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах, суралцах орчин нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна.**

**Зорилт 6.1 Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.**



6.1	<b>Арга хэмжээ 6.1.1</b> Шинэчлэн боловсруулагдах хяналт шалгалтыг зохицуулах журам, заавар, хяналтын хуудас болон эрсдэлийн шалгуурт санал оруулах	Батлагдсан төсвийн хүрээнд	Шинэчлэгдэх журам, заавар, хяналтын хуудас болон эрсдэлийн үнэлгээний шалгуурт өгсөн саналын тоо	2 удаагийн санал өгсөн	Тухай бүр санал өгсөн байна.	Хяналт шалгалтын нийтлэг журам, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, ашиглалтад хүлээж авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх журам, албан тушаалын тодорхойлолт, хяналт шалгалтын удирдамж зэрэгт 4 удаа 9 саналыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.	100
-----	--	----------------------------	--	------------------------	------------------------------	--	-----

**Зорилт 6.2. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

	<b>Арга хэмжээ 6.2.1</b> Хяналт шалгалтын объектод шалгуур үзүүлэлтээр эрсдэлийн үнэлгээ хийнэ.	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо	-	Шинэчлэгдсэн хяналт шалгалтын мэдээллийн санд буй объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.	Шилэн хяналтын системд батлагдсан 10 төрлийн шалгуур үзүүлэлтээр нийт 722 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. Эрсдэлийн ангиллаар авч үзвэл 125 (17.3%) объект их эрсдэлтэй, 509 (70.5%) объект дунд эрсдэлтэй, 88 (12.2%) объект бага эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн. Хяналтын чиглэлээр авч үзвэл: Хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 444 объект <ul style="list-style-type: none"> <li>• их эрсдэлтэй 47 (10.6%)</li> <li>• дунд эрсдэлтэй 336 (75.7%)</li> <li>• бага эрсдэлтэй 61 (13.7%)</li> </ul> Орчны эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 118 объект <ul style="list-style-type: none"> <li>• их эрсдэлтэй 13 (11%)</li> <li>• дунд эрсдэлтэй 91 (77%)</li> <li>• бага эрсдэлтэй 14 (12%)</li> </ul> Халдвар судлалын хяналтын чиглэлээр 107 объект <ul style="list-style-type: none"> <li>• их эрсдэлтэй 51 (47.6%)</li> <li>• дунд эрсдэлтэй 55 (51.4%)</li> <li>• бага эрсдэлтэй 1 (0.9%)</li> </ul> Хүүхдийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 53 объект <ul style="list-style-type: none"> <li>• их эрсдэлтэй 14 (26.5%)</li> <li>• дунд эрсдэлтэй 27 (51%)</li> </ul> бага эрсдэлтэй 12 (22.5%) тус тус үнэлэгдэж шилэн хяналтын системд бүртгэж ажиллав.	100
--	--	----------------------------	---------------------------------------	---	--	---	-----

6.2	<p><b>Арга хэмжээ 6.2.2</b> Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлагдсан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 36 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулна.</p>	Улсын төсөв	Объектын хамралтын хувь	2023 онд объектын хамралт 77.3%	100%	<p>Тайлант хугацаанд нийт 36 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, биелэлт 100 хувьтай байна. Хяналт шалгалтад хамрагдсан объектоос 14 (39%) нь бага эрсдэлтэй, 19 (53%) нь дунд эрсдэлтэй, 3 (8%) нь их эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн бөгөөд эрсдэл үүсэх магадлал дунджаар 32.4% буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 68.1% байна. Шалгалтын явцад нийт 741 зөрчил дутагдал илрүүлэн 345 зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, бусад илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн нийт 369 заалт бүхий 36 албан шаардлага хүргүүлэн ажилласан бөгөөд хэрэгжилт 79.4% биелсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар 27 (75%) нь бага эрсдэлтэй, 9 (25%) нь дунд эрсдэлтэй үнэлэгдэж, их эрсдэлтэй объектын эрсдэлийг бууруулж ажилласан бөгөөд эрсдэл үүсэх магадлал дунджаар 20.04% буюу бага эрсдэлтэй үнэлэгдэж 12.3%-иар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Улмаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 79.5% болж, 11.4%-иар нэмэгдсэн. Шалгалтаар 3 ААНБ-д 3 зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж 2.500.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, эрх бүхий албан тушаалтын 3 заалт бүхий албан даалгавар хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж ажилласан.</p>	100
			Эрсдэлийн түвшин	Дунд-41.4% Их-9.2%	Их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувийг 3 хүртэл хувиар бууруулна.		
			Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	66%	68%		
	<p><b>Арга хэмжээ 6.2.3</b> Иргэн, ААН, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ.</p>	Батлагдсан төсвийн хүрээнд	Шийдвэрлэлтийн хувь	100%	100%	<p>Тайлант хугацаанд ААНБ, иргэнээс 25 хүсэлт, өргөдөл ирж төлөвлөгөөт бус шалгалт хийгдсэн бөгөөд шийдвэрлэлт 100% байна. Шалгалтын явцад нийт 327 зөрчил дутагдал ирлүүлэн 37 зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, бусад илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн нийт 159 заалт бүхий 18 албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт дунджаар 68% биелэгдсэн. Мөн 33 заалт бүхий 3 зөвлөмж гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн. Шалгалтаар 363 хүнсний бүтээгдэхүүн, ус, орчны эд зүйлийн арчдас, хөрсний шинжилгээнд дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд 55 (15.1%) дээж нь стандартын шаардлага хангаагүй. Шалгалтын явцад 4 ААН-д 6 зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулснаас 5 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 1 зөрчилд хэрэг нээж шийдвэрлэсэн бөгөөд нийт 19.000.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, 15.900.000 төгрөгийн нөхөн төлбөрийг</p>	100

						улсын байцаагчийн актаар тогтоож ажилласан. Мөн 1 ААН-ийн үйл ажиллагааг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг үндэслэн актаар түр зогсоож, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авснаар үйл ажиллагааг сэргээж ажилласан. Мөн ажлын байрны 3 дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.	
	<p><b>Арга хэмжээ 6.2.4</b> Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийнэ.</p>	Батлагдсан төсвийн хүрээнд	Шийдвэрлэлтийн хувь	100% /Газрын байршил – Зураг төсөл 155 Комисс 17/	100%	<p>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 252 ажлын болон загвар зурагт хяналт хийснээс шалгалтын явцад богино хугацаанд арилгах боломжтой 186 зөрчлийг тухай бүр арилгуулж, холбогдох хууль, норм дүрэм, стандартын шаардлага хангасан тухай улсын байцаагчийн 234 дүгнэлт гаргаж, зураг төслийг баталгаажуулан ажилласан.</p> <p>Харин 18 зураг төслийг албан бичгээр хариу хүргүүлэн буцаасан. Үүнээс 14 зураг төсөлд холбогдох хууль, норм дүрэм, стандартын шаардлага хангаагүй нийт 32 зөрчил дутагдал илэрч, баталгаажуулахгүй буцаасан бол 2 зураг нь баригдаж дууссан барилга, 1 зураг нь хүн ажиллах байнгын ажлын байр биш, 1 зураг нь барилга байгууламжийн төвөгшилөөр Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтыг газарт хянагдах зураг байсан.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжаар томилсон барилга байгууламжийг ашиглалтад оруулах 55 улсын комисст ажиллан 102 объектыг ашиглалтад оруулахад эрүүл ахуйн хяналтыг хийсэн. Тус хяналтын явцад үүрэг даалгаврын биелэлтийн хуудсанд давхардсан тоогоор 204 үүрэг даалгавар өгч, хуулийн хугацаанд арилгуулснаар комиссын дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулж ажилласан. Мөн барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас өмнө 9 объектын ундны усны дээжид лабораторийн шинжилгээ хийлгэж, стандартын холбогдох заалтад нийцсэн тухай дүгнэлт гаргаж хүргүүлэв.</p> <p>Даланзадгад суманд баригдсан 200 хүүхдийн цэцэрлэгийг ашиглалтад хүлээн авахад 4 бүлгийн агаараас нийлбэр дэгдэмхий органик бодис, формальдегид, бензол, толуол, этилбензол, ксилол зэрэг үзүүлэлтийг Улаанбаатар хотын Ногоон титэм ХХК-ийн лабораторид шинжилгээ хийлгүүлсэн бөгөөд шинжилгээний дүнг Барилгын материалын эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлт, зөвшөөрөх дээд хэмжээтэй харьцуулахад шаардлагад нийцэж байв.</p>	100

	<p><b>Арга хэмжээ 6.2.5</b> Салбарын хяналтын газраас баталсан удирдамжийн дагуу 20 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.</p>	<p>Батлагдсан төсвийн хүрээнд</p>	<p>Хамруулсан объектын тоо, Арилгуулсан зөрчлийн хувь, Хэрэгжилтийн хувь</p>	<p>-</p>	<p>Гүйцэтгэлээр</p>	<p>Салбарын хяналтын газраас баталсан удирдамжийн дагуу 20 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийгдэхээс 17 чиглэлийн урьдчилан сэргийлэх шалгалт хийгдсэн. 3 удирдамжийн чиглэлээр хүсэлт ирээгүй тул хийгдээгүй байна. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 235 объектод хяналт шалгалт хийж, 1171 зөрчил дутагдал ирлүүлэн 781 (66.6%) зөрчлийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч, бусад илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн нийт 279 заалт бүхий 42 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 72%-тай байна. Мөн улсын байцаагчийн 170 дүгнэлт үйлдсэнээс ажлын байрны тухай 157 дүгнэлт, бүтээгдэхүүний тухай 13 дүгнэлт байна. Шалгалтаар бүтээгдэхүүнээс дээж авах акт 3, 60 унд ахуйн ус, хөрс, бохир усны шинжилгээнд дээж авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд стандартын шаардлага хангаагүй дээж байхгүй. Мөн 7 ААН-д 7 зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж 7.000.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, эрх бүхий албан тушаалтын 7 заалт бүхий албан даалгавар хүргүүлэн ажилласан.</p>	<p>100</p>
<p>2024 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын 116 арга хэмжээг төлөвлөн ажилласан байна. төлөвлөгөөний жилийн эцсийн гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийхэд үр дүнтэй хэрэгжсэн буюу 100 хувийн гүйцэтгэлтэй –97 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хувийн гүйцэтгэлтэй –17 арга хэмжээ, 31-69 хувийн буюу “эрчимжүүлэх шаардлагатай” 2 арга хэмжээ дундаж үнэлгээ 98,3 хувь буюу Тодорхой үр дүнд хүрсэн байна.</p>							

ТАЙЛАГНАСАН: ЭМГ-ЫН УТСХ-ИЙН ДАРГА *Б.Талцрагаай* Б.ГАНШАГАЙ

ХЯНАСАН: ЭМГ-ЫН ХШҮМХ-ИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *БМ* Б.ЦАГААНЦЭНД

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ  
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.12.11

Засгийн газрын 2020 оны 217 тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ыг удирдлага болгон Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн ажлын төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗОРИЛГО:**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:**

Засгийн газрын 2020 оны 217 тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам, 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай 374 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг 2024 оны 12 дүгээр сарын 10-11-ны өдрүүдэд зохион байгууллаа. Хяналт үнэлгээг эрүүл мэндийн газрын 4 хэлтэс, 1 төвийн ирүүлсэн тайланд нэгтгэн хийлээ.

**ГУРАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ , ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮР ДҮН**

№	Зорилт арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Дундаж хэрэгжилтийн хувь
1	Зорилт арга хэмжээ 1.1	12	98,2
2	Зорилт арга хэмжээ 1.2	22	96,5
3	Зорилт арга хэмжээ 1.3	2	97,5
4	Зорилт арга хэмжээ 1.4	2	100
5	Зорилт арга хэмжээ 2.1	8	96,8
6	Зорилт арга хэмжээ 2.2	7	97,3
7	Зорилт арга хэмжээ 2.3	5	94
8	Зорилт арга хэмжээ 3.1	6	98,2
9	Зорилт арга хэмжээ 4.1	9	100
10	Зорилт арга хэмжээ 4.2	7	97,8
11	Зорилт арга хэмжээ 4.3	6	98,8
12	Зорилт арга хэмжээ 5.1	7	100
13	Зорилт арга хэмжээ 5.2	6	100
14	Зорилт арга хэмжээ 5.3	5	100
15	Зорилт арга хэмжээ 5.4	4	97,6
16	Зорилт арга хэмжээ 6.1	1	100
17	Зорилт арга хэмжээ 6.2	5	100
	Нийт	116	98,3

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 онд хэрэгжүүлэхээр 17 зорилтын 116 арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэн тайлагнаснаас:

- 100 хувь буюу “үр дүнтэй”- 97 арга хэмжээ
- 70-99 хувийн буюу “тодорхой үр дүнд хүрсэн” 17 арга хэмжээ
- 31-69 хувийн буюу “эрчимжүүлэх шаардлагатай” 2 арга хэмжээ
- 0-30 хувийн буюу “үр дүнгүй” арга хэмжээ байхгүй байна.

**“Үр дүнтэй” гэж үнэлэгдсэн зарим ажлуудаас дурдвал:**

2024 онд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Манлай, Номгон, Хүрмэн сумын эрүүл мэндийн төвийг шинээр барьж Цогт-Овоо өргөтгөлийн засвар, ашиглалтад оруулснаар иргэдэд ээлтэй орчинд тусламж үйлчилгээ үзүүлэх, эмч эмнэлгийн ажилтнууд ая тухтай орчинд ажиллах орчин нөхцөлийг сайжруулсан.

Эрүүл мэндийн салбарт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдад эрүүл мэндийн тухай хуулийн дагуу 146 хүнд 1,4 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон.

Аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг хөтөлбөр”-ийн хүрээнд төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Нутгийн дэм” хөтөлбөрийг хэрэгжүүлж эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа нийт эмч, эмнэлгийн ажилчдад сар бүр 400.000 төгрөг олгодог ба 2024 онд 758 эмнэлгийн ажилчдад 303,2 сая төгрөг олгосон байна. Мөн орон нутгийн төсвөөс бүх төрийн байгууллагын албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 25 хувиар тооцон олгож байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумдын эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 2024 онд Номгон, Сэврэй сумдын ЭМТ-ийг 220/380В-ийн 5,5-6 квт хүчин чадал бүхий дизель хөдөлгүүрээр тус тус хангаж, ашиглалтад оруулсан. Ингэснээр БОЭТ,14 сумын Эрүүл мэндийн төвүүд, 3 Өрхийн эрүүл мэндийн төв цахилгаан тасарсан үед найдвартай нөөц цахилгааны эх үүсвэрээр бүрэн хангагдсан.

2023 онд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн оношилгооны системийг ашиглалтад оруулан тусламж үйлчилгээг 2024 он гарснаар 167 хүнд тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнээс умайн хүзүүний улайлт өөрчлөлттэй 15 эмэгтэйг эсийн шинжилгээнд, 5 эмэгтэй эдийн шинжилгээнд хамруулсан.

БОЭТ-хамтран Цогт-овоо-, Мандал-овоо, Баяндалай суманд 216 хүнийг үзлэгт хамруулсан байна. Үүнээс умайн хүзүүний улайлттай 35 эмэгтэйг лавлагаа шатлалын эмнэлэгт шилжүүлсэн байна. Мөн CERVICARE AI систем буюу хиймэл оюун ухаанд суурилсан оношилгоог орон нутагт Түмэн мэлмий хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага нэвтрүүлэн -468 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 318 хэвийн, умайн хүзүүний шарх улайлттай давтан үзлэгт орох-86, умайн хүзүүний хавдрын урьдал болон сэжигтэй-64, эдийн шинжилгээнд хамруулсан-64 байна. Хиймэл оюун ухаанд суурилсан оношилгоонд хамрагдсан хүний тоо –851

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хөхний хавдрыг илрүүлэх маммографийн аппаратыг орон нутгийн төсвийн 380 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэн эмчилгээ оношилгоо дээр дэвшилтэд шинэ технологийг нэвтрүүлээд байна. Тоног төхөөрөмж ажиллуулахад шаардлагатай 1 эмч, мэргэжилтнийг лавлагаа шатлалын эмнэлэгт ажлын байрны

дагалдан сургалтад хамруулан чадавхжуулсан. 2024 оны байдлаар 118 иргэнд хөхний хавдрыг илрүүлэх маммографийн оношилгоог хийгээд байна.

“Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 18 арга хэмжээг төлөвлөн 92%-тай хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд 6 сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинет, хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг, Говь дент шүдний төв, БОЭТ зэрэг нийт 16 кабинетаар амны хөндий, шүдний тусламж үйлчилгээг амбулаториор 35,430 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. Хөдөө орон нутагт тусламж үйлчилгээг өргөжүүлэхээр Номгон, Цогт-овоо сумдад шүдний кабинет тохижуулахаар шаардлагатай багаж тоног төхөөрөмж, урвалж материалын эрүүл шүд хөтөлбөрөөс 10 сая төгрөгийн багаж, төхөөрөмжийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн. Иймд Ханбогд, Номгон, Цогт-овоо, Гурвантэс, Цогтцэций, Манлай шүдний кабинет ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлсэн. 11 сарын байдлаар сумын эрүүл мэндийн төвүүд 4951 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн Говь дент шүдний төв 9445 иргэнд амны хөндийн тусламж үйлчилгээ, 2142 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг үнэ төлбөргүй зохион байгуулсан.

“Шүдний явуулын үзлэг” арга хэмжээг 12 сумын 6,12 настай 700 хүүхдэд фтор түрхлэг, 500 орчим иргэнд тусламж үйлчилгээ хүргэхээр төлөвлөн Говь дент шүдний төвөөр гүйцэлдүүлэхээр ажлыг эхлүүлсэн. 12 сарын байдлаар Цогт-овоо, Баяндалай, Гурвантэс суманд ажиллаж амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 501 хүнд үзлэг эмчилгээ, эрдэсжүүлэх түрхлэг хийсэн. Үүнээс шүдний ломбо эмчилгээ -149 хүнд, Шүдний чулуу түүх эмчилгээ -6 хүнд, Шүд авалт-42 хүнд, Фторт түрхлэг-326 хүнд хийгдсэн байна. 6-12 настай-249 хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, эрдэсжүүлэх буюу фторт түрхлэг хийсэн. Үүнээс Эрүүл хүүхэд-70, Цоорлын тархалт-86.3% байна.

Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо-14396

Орон нутагт 2 дахь удаагаа “Эрүүл шүд” хөтөлбөрийн хүрээнд 9-12 насны сурагчдын дунд “Шүд угаалтын аварга” шалгаруулах тэмцээнийг 6 сургуулийн 17 багийн 144 сурагчид оролцуулан зохион байгуулсан. Асран хамгаалагчид болон хүүхдүүдээс тэмцээний өмнө болон дараа авсан асуумж судалгаагаар амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг 92,1% -100% нэмэгдсэн байна.

2024 онд сүү тараг хөтөлбөрт хамрагдвал зохих 6-12 сартай 5017 хүүхэд, 2 хүртэл насны ихэр 218 хүүхэд, 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1,392 хүүхэд, жингийн алдагдалтай, өсөлтийн хоцрогдолтой 816 хүүхэд буюу нийт давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 7443 хүүхдийг хамруулан ажилласан. Сүү тараг хөтөлбөр болон зуны сувилалд хамрагдсан хүүхдүүд жингийн алдагдалтай, өсөлт хоцрогдолтой хүүхэд дунджаар 1,1-1,3 кг жин, 1,5-3см өндөр нэмэгдсэнээр хөтөлбөрт удаан хугацаанд хамрагдах нь хүүхдийн биеийн өсөлт хөгжилд илүү сайнаар нөлөөлж байгааг баталж байна.

Хоол зүй монголын нийгэмлэг ТББ-тай хамтран аймгийн БОЭТ, СЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын эмнэлзүйн хоолны тогооч нарт ЭМС-ын 2023 оны А/440 тушаалыг мөрдөж ажиллахтай холбоотойгоор эмнэл зүйн хоолны онол, дадлага, хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд 14 хоногт давтагдахгүй хоолны цэсээ зөв төлөвлөх, мөн ажлын байр нь дээрх арга барил, ур чадвар сайжирсан. Эмчлүүлэгчдээ долоо хоногт нэг удаа иж бүрдэл эмнэл зүйн хоолыг нэвтрүүлэн үйлчилж байна. Ингэснээр хэвтэн эмчлүүлэгчдийн сэтгэл ханамж сайнаар нөлөөлж байна.

АНУ-ын Эрүүл зөв хооллолтын холбооны эмч АНУ-ын Иллинойс их сургуулийн доктор, профессор Ханна Миттер хамтран чихрийн шижин өвчний үеийн хооллолт, эмчилгээ оношилгооны чиглэлээр сургалтыг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж 100 гаруй ард иргэд, эрүүл мэндийн салбарын 40 гаруй эмч, мэргэжилтэн хамрагдсан.

Аймгийн хэмжээнд 2024 онд сүрьеэгийн эрсдэлт бүлгийн судалгааг шинэчлэн нийт 2,921 хүнийг бүртгэн мэдээллийг цуглуулсан. Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын 23,7%-ийг илрүүлэг, үзлэг шинжилгээнд хамруулсан байна. ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт сэргийлэлтийн албанаас хяналт үнэлгээ хийхтэй холбоотой 12 сум, өрх буюу 70,5 хувьд нь дэмжлэг хяналт хийж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан. 2023 онд сүрьеэгийн өвчлөл 23 бүтгэгдсэн бол 2024 онд 13 бүртгэгдэж түвшин 10000 хүн амд 1,7 промилль байна.

Om.mohs.gov.mn цахим хуудсанд 18 мэдээ, мэдээллийн санд 34 удаагийн шинэчлэлт хийсэн. Фейсбүүк пэйж хуудас цаг үеийн мэдээллийг тухай бүр нийт 210 пост, 154 бичлэг оруулж 651,886 хандалт авсан нь өмнөх оноос 199.8% өссөн. 2500 дагагч нэмэгдсэн нь өмнөх оноос 176.4% өссөн Нийт пэйж хуудас руу зочилж орсон тоо 60.900 бөгөөд өмнөх оноос 60.8% өссөн үзүүлэлттэй байна.

**“Тодорхой үр дүнд хүрсэн”** үнэлэгдсэн ажлуудаас ажлуудаас дурдвал:

“Хавдрын хими эмчилгээний хэсэг”-ийг 2023 оны 11 сард байгуулан үйл ажиллагааг тогтмолжуулан 2024 онд 26 хүнд давхардсан тоогоор нийт 136 удаагийн хавдрын хими, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг хүргээд байна. Хавдраар оношлогдсон 608 хүнээс ХСҮТ-д 30 хүн хими эмчилгээнд хамрагдаж байна. Орон нутагтаа хими эмчилгээг эхлүүлснээр 86,6% нь орон нутагтаа хамрагдсан байна. 2024 онд нийт хөнгөвчлөх тасагт 85 хүн хэвтэн эмчилгээнд хамруулан ажилласан. Хавдрын хөнгөвчлөх, хими эмчилгээ хийхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн стандарт хангалтыг 100 хувьд хүргэсэн.

Аймгийн “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 3 зорилт, 29 заалт бүхий төлөвлөгөө гарган, 100 сая төгрөгийг төсөвлөн, хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,2%-тай хэрэгжүүлж, дараах үр дүн гарсан. Үүнд эхийн эндэгдэлгүй, эхийн ноцтой хүндрэлийн 4 тохиолдол бүртгэгдсэн ч шуурхай хариу арга хэмжээ авч, эхийн амь насыг аварсан. Амьгүй төрөлтийг 6 тохиолдлоор, охидын төрөлтийг 7 тохиолдлоор бууруулсан. Нярайн эндэгдлийн тоо 6 тохиолдлоор өссөн ба 1-5 насны эндэгдэл 1, Жирэмсний эрт хяналтын хувийг өмнөх оны мөн үеэс 0,6%-р нэмэгдүүлж, 90,5% болсон.

Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, хүн амын дундах эрт илрүүлэг үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахаар 100.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн эрт илрүүлгийн үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар насанд хүрэгчдийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулахаар “Жасминдра” клиниктэй гэрээлэн ажиллаж байна. Мөн эрт илрүүлэг үзлэгийн эрчимжүүлэх зорилгоор Улсын нэг дүгээр төв эмнэлэг болон CLINICO HEALTH CENTRE эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарийн хамтарсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо “Нүүдлийн эмнэлгийн үзлэг” арга хэмжээг амжилттай зохион байгуулж нийт 1165 иргэнийг хамруулсан. Үүнээс 481 малчин хамрагдсан. Үзлэгээр хавдрын урьдал-4, шинэ чихрийн шижин-3, бөөрний хоргүй хавдар-1, элэгний миоплазм-2, уушгины хавдрын сэжигтэй тохиолдол-1, ходоодны шарх-6, зүрх судасны эмгэгтэй 156 хүн илэрч, өрх сумын эрүүл мэндийн төвд мэдээлэх, лавлагаа шатлалд шилжүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж



байна. Нийт үзлэг хамрагдсан иргэдийн 14.8% нь өвчлөл илэрсэн байна. Үзлэгийн мэдээллийг насны багцаар үзвэл: 0-5 нас 6101/57.8%/, 6-17 нас 12873/74%/, 18-30 нас 2133/16%/, 31-45 нас 2874/15,7%/, 46-60 нас 2348/22,2%/, 61+ нас 1044/21.4%/ хамрагдсан байна. Эрт илрүүлгийн хувь 36,5 байна. Улсын дунджаас 9,5%-аар бага байна.

Зүрх судасны өвчний хүндрэлээс сэргийлэх зорилгоор орон нутгийн дэмжлэгээр Бүсийн оношилгоо

эмчилгээний төвд ангиографийн оношилгоо, эмчилгээний тусламжийг нэвтрүүлж, 87 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн ЭМЯ-наас томилогдсон Үндэсний баг 2 удаа ирж, зүрх судас, хэвлийн, мэдрэлийн, хавдрын ангиографийн тусламж үйлчилгээг нэвтрүүлж, ажлын байрны сургалт зохион байгуулж, эмч, мэргэжилтнүүдийг багаар нь дагалдуулсан.

### **Эмнэлгийн тусламж үйлчилгээнд 2024 онд нэвтрүүлсэн шинэ технологиуд:**

1. Молекул биологийн лабораторид BIO RAD ПСР аппарат, BIO NEER ялгах аппаратыг нэвтрүүлсэн. Тус аппаратаар доорх нэр төрлийн шинжилгээ хийгдэж байна.

-Бэлгийн замын далд халдвар илрүүлэх STI-14 ийн шинжилгээ - 473 хүнд

-Хүний хөхөнцөр вирусийн 29 генотипийг илрүүлэх HPV, 200 хүнд

-Элэгний ачаалал үзэх HBV, HDV, HCV, 1,029 хүнд

-Улаан бурхан улаануудын шинжилгээ, 3 хүнд

2. БОЭТ-н эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг илрүүлэх сүүлийн үеийн суурин samsung V8 загварын ЭХО аппаратыг нийлүүлсэн. Ингэснээр орон нутагт ургийн гажгийг тодорхойлох бусад нарийн шинжилгээг хийх боломжтой болсон. ашиглалтад орсноос хойш 1930 эмэгтэй тус аппаратаар ЭХО оношилгоонд орсон байна)

3.Хавдрын маркерийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн. Одоогоор 6 төрлийн хавдрын маркерийн шинжилгээг хавдар илрүүлэх, оношлох, тавиланг таамаглах, эмчилгээний үр дүнг хянах болон хавдрын дахисан эсэхийг илрүүлэх зорилгоор эмнэлзүйн практикт ашиглаж байна.

-AFP- Элэгний эсийн хорт хавдар, үр хөврөлийн эсийн хавдрын маркери.

-CA-125- Өндгөвчний хавдрын эмчилгээ, оношилгооны гол маркери.

-CEA-Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын маркери.

-CA19-9 Нойр булчирхайн хавдрын гол маркери.

-CA15-3-Хөхний хавдрын маркери.

-CA-72-4-Ходоодны хавдрын маркери.

4.Дотор болон хөнгөвчлөхийн тасгийн үйлчлүүлэгчдэд эмчилгээний зорилгоор төвийн венийн гуурсыг цээжний болон хэвлийн хөндийд байршуулж байна. 2024 онд нийт 8 хүнд цээжний гуурс байрлуулсан. 20 хүнд хэвлийн гуурс байрлуулж эмчилгээ хийсэн.

5.Ангиографийн тусламж үйлчилгээг зүрх судасны, мэдрэлийн, хэвлийн, хавдрын чиглэлээр үзүүлж эхэлсэн. ЭМЯ-аас томилогдсон Үндэсний багыг БОЭТ-ийн эмч, мэргэжилтнүүд дагалдан суралцаж, орон нутагт нутагшуулахаар ажилласан.

6. 2024 онд Орон нутгийн хэмжээнд анх удаа Гурвантэс сумын эрүүл мэндийн төвд умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт CERVICARE AI систем буюу хиймэл оюун ухаанд суурилсан оношилгооны аппаратыг Орон нутгийн төсвийн 49,0 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэн хүлээлгэн өгсөн үзлэг хийгдэж эхлээгүй байна.

### **Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнээс дурдвал:**

Эрүүл мэндийг дэмжих төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, хүн амын дундах эрт илрүүлэг үзлэгт хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахаар 100.0 сая төгрөгийг орон нутгийн

төсвөөс шийдвэрлэн эрт илрүүлгийн үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлсэн. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаар насанд хүрэгчдийн эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулахаар “Жасминдра” клиниктэй гэрээлэн ажиллаж байна. Мөн эрт илрүүлэг үзлэгийн эрчимжүүлэх зорилгоор Улсын нэг дүгээр төв эмнэлэг болон CLINICO HEALTH CENTRE эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарийн хамтарсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо "Нүүдлийн эмнэлгийн үзлэг" арга хэмжээг амжилттай зохион байгуулж нийт 1165 иргэнийг хамруулсан. Үүнээс 481 малчин хамрагдсан. Үзлэгээр хавдрын урьдал-4, шинэ чихрийн шижин-3, бөөрний хоргүй хавдар-1, элэгний миоплазм-2, уушгины хавдрын сэжигтэй тохиолдол-1, ходоодны шарх-6, зүрх судасны эмгэгтэй 156 хүн илэрч, өрх сумын эрүүл мэндийн төвд мэдээлэх, лавлагаа шатлалд шилжүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийт үзлэг хамрагдсан иргэдийн 14.8% нь өвчлөл илэрсэн байна. Үзлэгийн мэдээллийг насны багцаар үзвэл: 0-5 нас 6101/57.8%, 6-17 нас 12873/74%, 18-30 нас 2133/16%, 31-45 нас 2874/15,7%, 46-60 нас 2348/22,2%, 61+ нас 1044/21.4%/ хамрагдсан байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад эрт илрүүлэг үзлэгтэй холбоотой тушаал, шийдвэр, үзлэг идэвхжүүлэх зөвлөмж бичгийг 22 удаа, төрийн болон төрийн бус албан байгууллага, уул уурхайн компаниудад үзлэгт хамрагдах зааврыг 4 удаа хүргүүлсэн. Иргэдийг уриалах, заавар зөвлөмжөөр хангах 40 мэдээлэл бэлтгэн цахим сүлжээнд байршуулсан, ойролцоогоор 10000 иргэний хандалттай байна. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу эрт илрүүлгийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зөвхөн Бүсийн оношилгоо эмчилгээний төв дээр суурилан зохион байгуулан ажиллаж байгаа нь хамралт хангалтгүй байх, очер дараалал үүсэх шалтгаан болж байна. Цаашид хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын чадавхыг нэмэгдүүлэн эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ оны 8 дугаар сараас хойш байгууллагуудад эрүүл мэндийн даатгалын санхүүжилт олгогдохгүй, өр зээлийн асуудал үүссэнтэй холбоотойгоор эрт илрүүлгийн хамралт удааширч байна.

Эрт илрүүлгийн хувь 36,5 байна. Улсын дунджаас 9,5%-аар бага байна.

Эрүүл мэндийн сайдын А/760 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөө, аймгийн “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 3 зорилт, 29 заалт бүхий төлөвлөгөө гарган, 100 сая төгрөгийг төсөвлөн, хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,2%-тай хэрэгжүүлж, дараах үр дүн гарсан. Үүнд эхийн эндэгдэлгүй, эхийн ноцтой хүндрэлийн 4 тохиолдол бүртгэгдсэн ч шуурхай хариу арга хэмжээ авч, эхийн амь насыг аварсан. Амьгүй төрөлтийг 6 тохиолдлоор, охидын төрөлтийг 7 тохиолдлоор бууруулсан. Нярайн эндэгдлийн тоо 6 тохиолдлоор өссөн ба 1-5 насны эндэгдэл 1, Жирэмсний эрт хяналтын хувийг өмнөх оны мөн үеэс 0,6%-р нэмэгдүүлж, 90,5% болсон.

Аймгийн хэмжээнд 11 сарын байдлаар 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдсэн нь /1000 амьд төрөлтөд 16.5/ өнгөрсөн оны мөн үеэс 12 тохиолдлоор өссөн, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн 1000 амьд төрөлтөд 9,1 байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

Эрүүл мэндийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нийт 17 зорилтын 116 ажил арга хэмжээ төлөвлөж биелэлтийг төлөвлөгөөний дагуу 100 хувь тайлагнасан байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцын үнэлгээг хагас жилд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс хийж анхаарах асуудлаар зөвлөмж өгч ажилласны дагуу үйл ажиллагааг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй харьцуулан зөв

тайлагнасан байна. Шалгуур үзүүлэлтийг бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэлд үндэслэн хүрэх түвшингээ тодорхойлсон ба хүрэх түвшиндээ хүрсэн түвшингээ харьцуулан товч тодорхой тайлагнасан байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг хугацаанд нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хүргүүлсэн. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг улиралд цаасан хэлбэрээр, хагас бүтэн жилээр тайлангийн хурал хэлбэрээр зохион байгуулан үнэлж, удирдлагын багаар хэлэлцэж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан болно.

#### ТАВ. ЗӨВЛӨМЖ САНАЛ


- Эрчимжүүлэх шаардлагатай ажлуудын чанарын үзүүлэлтийг сайжруулах, 2025 оны төлөвлөлтөд зөв төлөвлөн, хэрэгжилтэд явцын үнэлгээ хийх.
- Судалгаанд тулгуурлан хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтээ бодитой оновчтой тодорхойлох.
- Жилийн эцсийн мэдээлэл, тайлан гараагүй байхад гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан бичиж үнэлэгдэх тул явцын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгээ зөв тайлагнахад анхаарах.
- Тайланд илүү үр дүнтэй хийсэн ажлуудын талаарх мэдээллийг хавсаргаж тайлагнах.

ТАНИЛЦСАН:  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН :  
ХШҮМХ-ИЙН ДАРГА



Б.ЦАГААНЦЭНД

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН УДИРДЛАГЫН  
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Даланзадгад

2024.12.12

**Хаана** Өмнөговь аймаг Эрүүл мэндийн газрын сургалтын өрөөнд

**Хэзээ** 2024 оны 12 сарын 12-ний өдрийн 12 цагт

Хурлын бүрэлдэхүүн ирц

1. Эрүүл мэндийн газрын дарга
2. УТСХ-ийн дарга
3. ЭТҮХ-ийн дарга
4. НЭМТ-ийн дарга
5. ХШҮМХ-ийн дарга
6. ХШХ-ийн дарга нар оролцож 100 хувийн ирцтэй хуралдав

**Хэлэлцэх асуудал:** 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн дотоод хяналт үнэлгээний дүнтэй танилцан дүгнэлт зөвлөмж гаргах.

**ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга Б.Цагаанцэнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад тайлангуудыг хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийсэн тухай танилцуулга хийв /тайланг хавсаргана/. Нийт 116 арга хэмжээг 98,3 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлагналтыг зөв хүснэгтээр хугацаанд нь тайлагнаж ажилласан нь дотоодын сургалт болон явцын хяналт үнэлгээний зөвлөмж 100 хувь хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

**ХУРЛААС ГАРСАН ДҮГНЭЛТ:**

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт тодорхой үр дүнд хүрсэн буюу 98,3 хувьтай үнэлэгдэж байгаа нь Хэлтсүүдийн төлөвлөгөөний биелэлт болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой гэж дүгнэж байна.
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон эрүүл мэндийн үзүүлэлтэд ахиц дэвшил гаргаж ажиллахад төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалт, бусад дэмжлэгүүд, Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэмжлэгт хяналт, сургалтууд, цахим зөвлөгөө сургалт, удирдлага аргагүйн маш их дэмжлэг болсон гэж үзэж байна.
3. Хүрэх түвшиндээ хүрээгүй үзүүлэлтийг анхаарч дараа жилийн төлөвлөлтөд оруулж ажиллах шаардлагатай. гэсэн дүгнэлтүүд гарлаа.

**ХУРЛААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ**

1. Монгол улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын арга аргачлал, загварын дагуу

2025 оны төлөвлөлтийг хийх. Төлөвлөлтөд шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлох, энэ чиглэлээр ХШҮМХэлтэс ажилчдад 1 дүгээр сарын 15-ний дотор дотоодод сургалт хийх.

2. Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс нь төлөвлөлтөд хяналт шинжилгээ үнэлгээний зөвлөмж дүгнэлтийг тусгаж, чанарын үзүүлэлтийг илүү сайжруулахад анхаарч үр дүнтэй ажил төлөвлөхөд арга зүйгээр хангах ажиллах,
3. Төлөвлөгөөний загвар аргачлалаар хийсэн эсэх, шалгуур хүрэх түвшинг зөв тодорхойлсон эсэхэд ХШҮМХ-с байгууллага нэгжийн, төрийн жинхэнэ албан хаагчийн бүх төлөвлөгөөнд хяналт шинжилгээ хийж, зөвлөмж аргачлалаар хангах.
4. Өсвөр үеийн эрүүл мэндийн боловсрол, ялангуяа охидын нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, хандлага, зан үйлийг өөрчлөхөд илүү анхаарсан ажлыг төлөвлөхөд анхаарах.
5. Эмэгтэйчүүд ялангуяа зорилтод бүлэгт хэрхэн хүрч ажиллах, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн байдалд судалгаа хийж бууруулах чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах.
6. Эрт илрүүлэг арга хэмжээг эрчимжүүлэх.
7. Жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулах. аргазүйгээр хангах
8. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөмж гаргах, нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөөний тодотгол хийж сайжруулж ажиллах.
9. Төлөвлөгөөнд шинээр гарч байгаа бодлогын баримт бичгүүд, орон нутгийн үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг уялдааг тооцоолж оруулах.

Хурал дууссан хугацаа 2024 оны 12 сарын 12-ний өдрийн 12:00 цагаас 15 цаг 10 минут

ТАНИЛЦСАН :

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ  
МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦАГААНЦЭНД

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**  
**ӨМНӨГОВЬ АЙМАГ.ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР 2024 ОН**

2024.12.05

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
<b>Нэг. Чиг үүрэг үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдал</b>			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх	<p>Байгууллагын эрхэм зорилго, зорилт, алсын харааг байгууллагын ажлын байрны үүдэн хэсэгт болон Эрүүл мэндийн газрын цахим хуудаст байршуулж веб хуудасны үйл ажиллагааг тухай бүр шинэчилж байна.</p> <p>Om.mohs.gov.mn цахим хуудсанд 18 мэдээ, мэдээллийн санд 34 удаагийн шинэчлэлт хийсэн. Фэйсбүүк пэйж хуудас цаг үеийн мэдээллийг тухай бүр нийт 210 пост, 154 бичлэг оруулж 651,886 хандалт авсан нь өмнөх оноос 199.8% өссөн. 2500 дагагч нэмэгдсэн нь өмнөх оноос 176.4% өссөн Нийт пэйж хуудас руу зочилж орсон тоо 60.900 бөгөөд өмнөх оноос 60.8% өссөн үзүүлэлттэй байна.</p>	100
1.2	Чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	<p>Цахим хаяг - om.mohs.gov.mn-т Эрүүл мэндийн газрын бүтэц 1 төв, 4 хэлтсийн ажиллагсдын мэдээллийг албан тушаал, харилцах утас, албаны мэйл хаягийг ил тод байршуулсан.</p> <p>Цахим шуудан - emg@om.mohs.gov.mn</p> <p>Албан ёсны хаяг – Өмнөговь Даланзадгад.3-р баг</p> <p>утас- 70532307 70533719</p>	100
1.3	Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт	Байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааны ил тод цэсэд тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө тайлангууд ил тод мэдээлж ажиллаж байна.	100

	шинжилгээ үнэлгээ дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан акт дүгнэлт албан шаардлага зөвлөмж	Эрүүл мэндийн газар нь 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын байгууллагын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлт авч ажилласан ба төрийн аудитын газрын <a href="http://www.fas.audit.mn">www.fas.audit.mn</a> цахим хаягаар хэрэгжилтийг гарган хүргүүлсэн. Аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг Эрүүл мэндийн яаманд албан тоот, нотлох баримтын хамт нэгтгэн хүргүүлсэн.	
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын шинжилгээний тайлан	<p>Хяналт шалгалтын хэлтэс тайлант хугацаанд нийт 36 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, биелэлт 100 хувьтай байна. Хяналт шалгалтад хамрагдсан объектоос 14 (39%) нь бага эрсдэлтэй, 19 (53%) нь дунд эрсдэлтэй, 3 (8%) нь их эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн бөгөөд эрсдэл үүсэх магадлал дунджаар 32.4% буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 68.1% байна. Шалгалтын явцад нийт 741 зөрчил дутагдал илрүүлэн 345 зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, бусад илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын /ахлах/ байцаагчийн нийт 369 заалт бүхий 36 албан шаардлага хүргүүлэн ажилласан бөгөөд хэрэгжилт 79.4% биелсэн.</p> <p>Гүйцэтгэлийн шалгалтаар 27 (75%) нь бага эрсдэлтэй, 9 (25%) нь дунд эрсдэлтэй үнэлэгдэж, их эрсдэлтэй объектын эрсдэлийг бууруулж ажилласан бөгөөд эрсдэл үүсэх магадлал дунджаар 20.04% буюу бага эрсдэлтэй үнэлэгдэж 12.3%-иар буурсан эерэг үзүүлэлттэй байна. Улмаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 79.5% болж, 11.4%-иар нэмэгдсэн.</p> <p>Шалгалтаар 3 ААНБ-д 3 зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж 2.500.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, эрх бүхий албан тушаалтын 3 заалт бүхий албан даалгавар хүргүүлэн хэрэгжилтийг хангуулж ажилласан.</p>	100
1.5	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	Хүн амын дундаж наслалтыг уртасгах, эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол мэдлэг, хандлага, дадлыг төлөвшүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг Өмнөговь аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгийн хүрээнд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг	100

		<p>нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлээр аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 7 төрлийн төсөл арга хэмжээг тусган шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт суулган хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал Хавдрын эсрэг арга хэмжээ, Сүү тараг, Эрүүл элэг, Эрүүл-шүд, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих, Харшлын эсрэг хамтдаа зэрэг орон нутгийн бодлого хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжих, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд нийт 27,174 хүн оролцсон байна. Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ “Хавдрын эсрэг арга хэмжээ”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих, Харшлын эсрэг хамтдаа зэрэг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг 90.0%-тай хэрэгжүүлж, тайлагнаж ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад 2%-аар нэмэгдсэн байна.</p> <p>Нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр аймгийн 43 спорт заал, 2 усан бассейн, 5 фитнес клуб, 4 иог, бясалгалын төв, 2 бүжгийн клуб зэрэг нийт 56 байгууллага аж ахуй нэгжтэй хамтран хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжин ажилсан.</p>	
1.6	<p>Үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж Засгийн газрын шийдвэр бусад эрх зүйн акт</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын хяналт үнэлгээг хийж 89,7 хувьтай үнэлэгдсэн. Хяналт үнэлгээний дүнд зөвлөмж ирүүлсний дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн.</p> <p>УИХ-ын тогтоол- 2, Монгол улсын хууль-3 Ерөнхийлөгчийн зарлиг-2</p>	100



		<p>Засгийн газрын тогтоол-12</p> <p>Засгийн газрын албан даалгавар-1</p> <p>Сайдын тушаал-47</p> <p>АИТХ-ын тогтоол-9</p> <p>ЗДҮАХ-ийн заалт-26</p> <p>Засаг даргын захирамж-1</p> <p>Засаг даргын албан даалгавар-3</p> <p>Дэд хөтөлбөр -5</p> <p>Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний заалт-17</p> <p>Бусад-2 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг программд оруулсан</p>	
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг эхийн нэр өөрийн нэр албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	<p>Байгууллагын бүтэц, үйл ажиллагааны чиглэл, бүх албан хаагчдын албан тушаалын нэр, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг, ажлын байрны үндсэн зорилгыг 2025 онд хос бичигтэн болох ажлын хүрээнд албан хаагчдын мэдээлэл, өрөө бүрийн үүдэнд шинэчлэн байршуулсан. Эрүүл мэндийн газраар үйлчлүүлж байгаа иргэд, албан байгууллагуудад ойлгомжтой байдлаар өрөөнүүдийн мэдээллийн самбар /дуугүй хөтөч/-ыг байгууллагын үүдний хэсэгт байрлуулж мөн байгууллагын гадна болон дотор хаяг, байгууллагын ил тодын самбарыг монгол бичгээр бичиж байрлуулсан.</p>	100
1.8	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ	<p>2024 онд нийт 31 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн.</p> <p>Үүнд: Засгийн газрын 11-11 утсанд 24</p> <p>70530001- утсанд -2</p> <p>Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд утсаар хүсэлт-1</p>	100

		<p>Бичгээр эмчилгээний төлбөрийн дэмжлэг хүссэн хүсэлт -1</p> <p>Бичгээр гомдол-3</p> <p>Мөн өргөдөл гомдлын тайланг 4 удаа улирал бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-т хүргүүлсэн</p>	
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	<p>Сар бүр Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүгнэлт хийж сарын мэдээг 11 удаа дараа сарын 05-ны дотор гаргаж эрүүл мэндийн байгууллагууд болон орон нутгийн удирдлага төрийн байгууллагуудад дотоод сүлжээгээр хүргүүлсэн.</p> <p>Сарын мэдээ-12 удаа, эх хүүхдийн тандалтын мэдээ-7 хоног бүр 52 удаа, халдварт өвчний мэдээ тохиолдол гарах бүрд-48 удаа, осол гэмтлийн мэдээ сар бүр 12 удаа, ТТӨ мэдээ- 7 хоног бүр 52 удаа, хоног тутмын мэдээг 2024 оны 09 сарын 01-ээс эхлэн өдөр бүр, холбогдох дээд байгууллагад хүргүүлж байна.</p> <p>Эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтээр хүн амын өвчлөл, сэргийлж болох өвчлөл зэрэг зарим үзүүлэлтийн мэдээг видео хэлбэрээр 4 удаа байгууллагын цахим хаягаар дамжуулан иргэдэд хүргэсэн.</p> <p>Орон нутгийн хүн амын өвчлөл статистик мэдээг өдөр тутамдаа -18 үзүүлэлтээр, 7 хоногийн өвчлөлийн мэдээг-20 үзүүлэлтээр эрүүл мэндийн 18 байгууллагаас авч эргэн мэдээллэж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. 2024 оны улирлын эргэн мэдээллийн номыг улирал бүр өмнөх оны мөн үетэй харьцуулан 3 удаа гаргасан.</p> <p>3 улирлын эргэн мэдээллийн ном гаргаж дүгнэлт хийж хүргүүлсэн ба 4 дүгээр улирлын ном 2025 оны 01 сарын 05-нд буюу эрүүл мэндийн чанарын үзүүлэлт гарсны дараа гарна.</p> <p>2003-2023 он хүртэлх эрүүл мэндийн 100 гаруй статистик үзүүлэлтээр ном эмхэтгэл хийж 100 ширхгээр хэвлүүлэн олны хүртээл болгосон.</p>	100
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	<p>аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд 7 төрлийн төсөл арга хэмжээг тусган шаардлагатай 1.2 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт суулган хэрэгжүүлэн ажилласан. Тухайлбал Хавдрын эсрэг арга хэмжээ, Сүү тараг,</p>	90

		<p>Эрүүл элэг, Эрүүл-шүд, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих, Харшлын эсрэг хамтдаа зэрэг орон нутгийн бодлого хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжих, нийтийн биеийн тамирын арга хэмжээнд нийт 27,174 хүн оролцсон байна. Салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот арга хэмжээ “Хавдрын эсрэг арга хэмжээ”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээ, Эх хүүхдийн эрүүл мэнд дэмжих, Харшлын эсрэг хамтдаа зэрэг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг 90.0%-тай хэрэгжүүлж, тайлагнаж ажилласан. “Элэг бүтэн монгол” арга хэмжээ, “Эрүүл элэг” орон нутгийн дэд хөтөлбөрийн хүрээнд зорилтод насны хүн амын 60,3 хувь буюу 18015 иргэнийг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулсан. Эрт илрүүлгийн хувь-60,3,</p> <p>“Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх 18 арга хэмжээг төлөвлөн 92%-тай хэрэгжүүлэн ажилласан. Амны хөндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо-35430 Эмчлэн эрүүлжүүлсэн хүний тоо- 23029, “Эх, хүүхдийн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд 3 зорилт, 29 заалт бүхий төлөвлөгөө гарган, 100 сая төгрөгийг төсөвлөн, хэрэгжүүлэн ажилласан. Хөтөлбөрийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 91,2%-тай хэрэгжүүлж, дараах үр дүн гарсан.</p> <p>“Харшлын эсрэг” хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхэд шаардагдах 50,0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж ажиллаж байна. 3 зорилтын хүрээнд 17 үйл ажиллагаа хийгдэхээр төлөвлөгдсөнөөс 16 үйл ажиллагааг зохион байгуулж Хөтөлбөрийн Хэрэгжилт 94,1 хувьтай. Аймгийн хэмжээнд 22 эрүүл мэндийн байгууллагыг унд ахуйн усны эрүүл зүйн шинжилгээнд хамруулан шинжилгээгээр ундны усны MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна. 2024 онд сүү тараг хөтөлбөрт хамрагдвал зохих 6-12 сартай 5017 хүүхэд, 2 хүртэл насны ихэр 218 хүүхэд, 12 хүртэл насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 1,392 хүүхэд, жингийн алдагдалтай, өсөлтийн хоцрогдолтой 816 хүүхэд буюу нийт давхардсан тоогоор аймгийн хэмжээнд 7443 хүүхдийг хамруулан ажилласан.</p>	
<b>Хэсгийн дундаж хувь</b>		<b>99</b>	
<b>Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал</b>			

2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<p>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд шаардлагатай байгаа сул орон тооны зарыг байгууллага тус бүрээр болон ажил мэргэжлийн агуу гарган Эрүүл мэндийн хөгжлийн төв, байгууллагын <a href="http://om.mohs.gov.mn">om.mohs.gov.mn</a> веб хуудас, Эрүүл мэндийн газрын <b>Өмнөговь аймаг Эрүүл Мэндийн газар</b> цахим хуудаст байршуулж иргэдэд нээлттэй зарласнаар 2024 онд шинээр 130 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан ажилд орж сул орон тоо нөхөгдсөн байна. Мөн эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог улирал бүр Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж тусгай шалгалтад тэнцсэн нэр дэвшүүлэх тогтоолоор 4 сул орон тоо нөхөгдсөн. Шаардлагатай байгаа сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн олон нийтэд зарлаж байна.</p>	100
2.2	Албан хаагч ажилтны сонгон шалгаруулах журам	<p>Төрийн албаны тухай хуулийн хүрээнд төрийн албан хаагчийн сонгон шалгаруулах журмын дагуу албан хаагчдыг төрийн албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт авах журмын дагуу сонгон шалгаруулж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн газарт Төрийн албан хаагчийн тусгай шалгалтад орж хамгийн өндөр оноо авсан 4 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчаар томилсон. Нэг албан хаагчийг шилжүүлэн томилон ажилд авсан. Эрүүл мэндийн байгууллагууд шинэ ажилтан сонгон шалгаруулах журам боловсруулж журмын дагуу сонгон шалгаруулж ажилд томилж байна.</p>	100
2.3	Албан хаагч ажилтны ёс зүйн дүрэм	<p>2019 оны а/406 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” ёс зүйн дүрмүүдийг байгууллагын цахим хуудас болон байгууллагын ил тодын самбарт байрлуулсан. Мөн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүдийг томилсон тушаал, гишүүдийн мэдээллийг цахим хуудас, байгууллагын ил тодын самбарт байршуулсан.</p> <p>Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа, эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал, эмч эмнэлгийн ажилчдын ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр иргэдээс байгууллага болон албан тушаалтанд ирүүлэх өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах журмыг боловсруулж ЭМГ-ын даргын 2023.01.18-ны А/03 тоот тушаалаар баталж эрүүл мэндийн байгууллагуудад</p>	95

		<p>мөрдүүлэн ажиллаж байна. Иргэдийн санал, хүсэлтийг түргэн шуурхай хүлээн авах зорилгоор 70532307 утсыг ажиллуулж байна.</p> <p>Улирал бүр 17 эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн дэд хорооны тайланг төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэн тайлагнаж байна.</p> <p>Эрүүл мэндийн газрын ёс зүйн дэд хороо 1 өргөдөл хүлээн авч ажилласан.</p>	
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам	<ul style="list-style-type: none"> <li>Аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж байгаа “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг дэмжих тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ын хүрээнд 42 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 288 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгт хамруулж амьдрах орчныг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ба 1 эмчид сургалтын зардалд 2 сая, 2 хүнд эмчилгээний зардалд 7 сая төгрөгийн дэмжлэг нийт 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 297 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Мөн нэн шаардлагатай хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор БОЭТ-ийн 3 эмчид амьдрах орчноо сайжруулахад нь 18 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Даланзадгад СЗДТГ-с “Оюуны үр хөтөлбөр”-ийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвийн 2 эмнэлгийн ажилтанд орон сууцны дэмжлэгт 6 сая төгрөг олгосон байна. Эмч нарын баярыг тохиолдуулан Баян-Овоо сумын залуу эмчид амьдрах орчин нөхцөлөө сайжруулахад АЗДТГ-аас дэмжлэг болгож 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 1 сувилагчид таван ханатай гэр чип дулаалгын хамт 2 сувилагчид гэрийн чип дуулаалга олгож амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан байна. 2024 онд нийт <b>54</b> эмч, эмнэлгийн ажилчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, сургалт болон эмчилгээний зардалд нийт <b>324 сая</b> төгрөгийн дэмжлэгт хамруулсан.</li> </ul>	95
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	<p>Эрүүл мэндийн салбарт дутагдалтай орон тооны судалгааг эрүүл мэндийн байгууллагуудаас авч Эрүүл мэндийн хөгжлийн төв, Эрүүл мэндийн байгууллагын веб хуудас, фейсбүүк хуудаст байршуулсан. Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга, Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан тушаалын сул орон тоог Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж тусгай шалгалтад тэнцэж хамгийн өндөр оноо авсан нэр дэвшүүлэх тогтоолын дагуу томилж сул орон тоо нөхөгдсөн. Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой</p>	100

		хамтран 12 сумын эрүүл мэндийн төвийн дарга нарыг Удирдлагын академийн “Сумын эрүүл мэндийн төвийн удирдлагын хөгжил” сэдэвт богино хугацааны сургалтад хамруулахаар хүсэлтийг хүргүүлж 2-р ээлжид сурахаар төлөвлөгдсөн.	
2.6	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	Байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга, ил тод, тогтоол журмын дагуу болгох зорилгоор Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, ЗГХЭГ-ын даргын 98 дугаар тушаалын дагуу байгууллагын үнэлгээний баг шинэчлэн байгуулсан. Дотоодын сургалтаар 1 удаа нийт 24 албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх болон үнэлгээний багийн ажиллах журмын талаарх мэдээллийг хүргэсэн. Журмын дагуу албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх үйл ажиллагааг үнэлгээний багийн гишүүдийн олонхын зарчмаар шийдвэрлэн ажиллаж байна. 2024 онд үнэлгээтэй холбоотой санал гомдол гараагүй байна.	100
<b>Хэсгийн дундаж хувь</b>			<b>98,3</b>
<b>Гурав.Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх</b>			
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Эрүүл мэндийн салбарын 2025 оны төсвийн төсөөллийг БОЭТөв, ЗӨСТөв, ЭМТөв, ӨЭМТөвүүд зэрэг 20 байгууллагуудыг байгууллага тус бүрээр пискал программд шивж, нэгтгэн 2024 оны төсвөөс 23.1% нэмэгдүүлсэн төсвийг Эрүүл мэндийн яаманд тайлагнасан. Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг байгууллагын шилэн дансны хуулийн хугацаанд цахим системд мэдээллийг байршуулж, ил тодын мэдээллийн самбарт байршуулж мэдээллэж ажилласан.	100
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан	Эрүүл мэндийн салбарын 17 байгууллагын санхүүгийн тайланг 19 төрлийн тайлангийн батлагдсан маягтын дагуу Эрүүл мэндийн яаманд нэгтгэн тайлагнасан. Санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтийг мөн үеийнхтэй харьцуулхад Санхүү байдлын тайлан 1.4 % буурсан, Орлого үр дүнгийн тайлан 2.4 % буурсан, Мөнгөн гүйлгээний тайлан 1.1% буурсан, Өмчийн өөрчлөлтийн тайлан 9.6% өссөн, эргэлтийн хөрөнгө 6.6 тэр бум буюу 2.5 хувиар буурсан,	100

		эргэлтийн бус хөрөнгө 61.8 тэр бум буюу 1.2% өссөн, өр 3.1 тэр бум буюу 28% өссөн, авлага 267.5 сая буюу 64% өссөн үзүүлэлтэй байна. Хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд үнэ зөв гаргаж гүйцэтгэлийг е-тайлан онлайн программд тайлагнаж, баримтын иж бүрэн байдалд хяналт тавих, хагас жилийн санхүүгийн тайланг гарган тайлагнасан.	
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2023 оны аудитын байгууллагын дүгнэлтээр ЭМГ, ЗӨСТөв, СЭМТөвийн 12, нийт 14 байгууллага зөрчилгүй буюу өөрчлөлтгүй дүгнэлтийг авсан. хязгаарлалттай дүгнэлтийг 3 байгууллага буюу БОЭТөв, Цогт-Овоо, Манлай зэрэг эдгээр байгууллагууд авч, Сөрөг дүгнэлтгүй ЭМСалбарын тайланг нэгтгэж Эрүүл мэндийн яаманд тайлагнагдсан байна. 2022 оны Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлтээс 82.36% нь өөрчлөлтгүй дүгнэлт авч мөн үеийнхтэй харьцуулахад 11.77% өссөн үзүүлэлттэй байна. Аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг Эрүүл мэндийн яаманд албан тоот, нотлох баримтын хамт нэгтгэн тайлагнасан мөн төрийн аудитын газрын <a href="http://www.fas.audit.mn">www.fas.audit.mn</a> цахим хаягаар хэрэгжилтийг гарган хүргүүлсэн.	100
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Тусгай зөвшөөрөл сунгуулах болон шинээр олгох байгууллагад Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 27-р зүйлийн дагуу аймгийн татварын дансанд төвлөрүүлэн ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар нийт 52 байгууллагын шинээр олголт болон тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулсны улсын тэмдэгтийн хураамж болох 7,910,000 төгрөгийг татварын дансанд төвлөрүүлсэн.	100
.3.5	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Эрүүл мэндийн газрын 2023 оны батлагдсан төсөв нь ХБГүйцэтгэл 2823,2 сая төгрөг батлагдсанаас нийт зарцуулалт 2533,7 сая төгрөгийг зарцуулж, нийт 289,6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсөвт татан төвлөрүүлсэн. Хэмнэгдсэн зардлаар авч үзвэл Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2 дахь заалтын дагуу олгодог тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас 188,4 сая төгрөг, томилолтын зардал 1,2 сая төгрөг, аудитын төлбөр 0,1 төгрөг тус тус хэмнэгдсэн байна. Хэмнэгдсэн гол шалтгаан нь тэтгэвэр тогтоолгох насанд	100

		хүрсэн боловч тэтгэвэртээ тогтоолгоогүй шалтгааны улмаас хэмнэгдсэн зардал болно.	
3.6	Таван сая түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг	Таван сая төгрөгөөс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний 458 төрлийн 1055,7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, шинжилгээний зардлын гүйлгээний мэдээллийг шилэн дансны тухай хуулийн дагуу цахим мэдээллийн системд хугацаанд нь сар бүр мэдээллэсэн байна.	100
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 95 төрлийн 3282,7 сая төгрөгийн орлого, 84 нэр төрлийн 1187,7 сая төгрөгийн зарлагын гүйлгээ, нийт 179 төрлийн 4470,4 сая төгрөгийн гүйлгээний мэдээллийг шилэн дансны тухай хуулийн дагуу цахим мэдээллийн системд орлого, зарлагын гүйлгээг сар бүр хугацаанд нь оруулж мэдээллэсэн байна. Нийт төсвийн 83,4%-ийг цахим системд 5 саяаас дээш үнийн дүн бүхий мэдээллийг 100 хувь мэдээллээр ханган ажилласан байна.	100
3.8	Бонд зээл өрийн бичиг баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ концесс төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр.	Эрүүл мэндийн газрын даргын тушаал, шийдвэрийг PDF файл болгон сар бүр шилэн дансанд тогтмол байршуулснаас А тушаал 80 ширхэг, Б тушаал 92 ширхэг, нийт 172 ширхэг мэдээлэл болон 1835,9 сая төгрөгийн тушаал, шийдвэрийг Шилэн дансны тухай хуулийн хугацаанд цахим мэдээллийн системд оруулж мэдээллэсэн байна.	100
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн	Өмнөговь аймгийн санхүү хяналт болон Эрүүл мэндийн яамны дотоод аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу шилэн дансны мэдээллийг шилэн дансны тухай хуулийн хугацаанд мэдээллийг үнэ зөв байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2024 оны нийт оруулах 159 мэдээлэл оруулахаас 159 мэдээллийг байршуулсан бөгөөд 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн. Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаа хоцроож байршуулсныг мөн үеийнхтэй харьцуулбал 99 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	95



3.10	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан тендерийн бичиг баримт тендерийн шалгаруулалт явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл шалтгаан</p>	<p>Өмнөговь аймгийн сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 22 багцтай тендерийн баримт бичгийг боловсруулж ЭМГ-н даргаар батлуулж, [ӨМАЭМГ/20240102007] урилгын дугаартай тендер шалгаруулалтыг цахим системээр нээлттэй журмаар 1 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 13 тендерт оролцогчийн 51 багцын үнэлгээ хийгдэж, тендерийн баримт бичигт заасан ерөнхий болон тусгай нөхцөлийн дагуу үнэлгээ хийгдэж шаардлага хангасан 10 эм ханган нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, гэрээний дагуу зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл урвалж оношлуурыг татан авч 14 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвд тогтвортой хангаж ажилласан. Мөн ерөнхий гэрээний нөхцөлөөр, цахим дэлгүүрээс 6 удаа нэгдсэн худалдан авалтыг, сум өрхийн эрүүл мэндийн төвийн захиалгын дагуу зохион байгуулсан.</p> <p>ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 27 дугаар зүйл.Тендер үнэлэх. 27.6.Эм, эмнэлгийн хэрэгслийн тендерийг үнэлэхэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан аргачлал, зааврын дагуу онооны дарааллаар эрэмбэлж, хамгийн өндөр оноотой тендерийг хамгийн сайн тендер гэж үнэлж дараах байгууллагуудтай гэрээ байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Монос трейд ХХК</li> <li>2.Тэгш-Анар ХХК</li> <li>3.Эм Эс Ай Си Си</li> <li>4.Айвико ХХК</li> <li>5.Сүвэн-Уул ХХК</li> <li>6.Мөнхийн тун ХХК</li> <li>7.Медклиин ХХК</li> <li>8.Медиконт ХХК</li> <li>9.Монбиофарм ХХК</li> </ol>	100
------	---	---	-----

		<p>10.ДЕС ХХК</p> <p>ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 26 дугаар зүйл.Тендер хянан үзэх. 26.10.Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж шаардлагад нийцээгүй буюу гэрээ байгуулахаас татгалзсан дараах байгууллагуудад үндэслэл бүхий албан тоотыг хүргүүлж ажилласан. Үүнд:</p> <p>1.Мон-Интра ХХК</p> <p>2.Оюудент</p> <p>3.Монфа трейд ХХК</p>	
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит бусад хяналт шалгалтын тайлан дүгнэлт	Тендер шалгаруулалттай холбоотой хяналт үнэлгээ хийгдээгүй гомдол санал гараагүй	-
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил арга зүйн зөвлөгөө зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	<p>Эмийн тендерээс бусад худалдан авах ажиллагаа нь АЗДТГ-ын Худалдан авах ажиллагааны газар дээр зарлагддаг ба мэргэжилтнүүд худалдан авах ажиллагааны дагуу бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгдэхэд комисст орж ажилладаг.</p> <p>2024 онд орон нутгийн төсвөөс 1,7 тэрбум Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулахаар нийт 7 худалдан авалт төлөвлөгдсөнөөс 4-р улирлын байдлаар бүх тендер зарлагдаж, үүнээс 6 ажил амжилттай гэрээ хийгдэн нийлүүлэгдсэн байна. Үүнд:</p> <p>-БОЭТ-н эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг илрүүлэх сүүлийн үеийн суурин ЭХО аппарат (“Мед импекс” ХХК шалгарч 6-р сарын 11-нд Төрөх эмэгтэйчүүдийн тасагт ургийн гажиг тодорхойлох боломжтой шинэ технологийн samsung V8 загварын ЭХО аппаратыг хүлээн авч комисс ажилласан. Ингэснээр орон нутагт ургийн гажгийг тодорхойлох бусад нарийн шинжилгээг хийх боломжтой болж байгаа юм. Ашиглалтад орсноос хойш 1930 эмэгтэй тус аппаратаар ЭХО оношилгоонд орсон байна)</p>	100

		<p>-БОЭТ-ийн ходоодны дуран, принтер, дагалдах нэг удаагийн хэрэгслийн хамт (6-р сарын 11-нд “Мед импекс”ХХК гэрээний дагуу 89.463.000 төгрөгийн төсвөөр БОЭТ-ийн дурангийн кабинетад olympus HQ-190 маркын ходоодны дуранг, дагалдах нэг удаагийн хэрэгслийн хамт хүлээн авч комисс ажилласан. Тус дуран нийлүүлэгдсэнээр БОЭТ 3 ээлжийн ходоодны уян дурантай болж иргэдийн оношилгоонд хамрагдах хүлээгдэл багассан. 2024 оны 8-р сараас хойш нийт 310 хүн дурангийн оношилгоонд орсон байна)</p> <p>-Умайн хүзүүний хавдрыг эрт оношлох хиймэл оюун ухааны аппарат Гурвантэс СЭМТ-д (“Сүвэн-уул” ХХК шалгарч 2024 оны 11-р сард 49.026.000 төгрөгийн төсвөөр умайн хүзүүний хавдрыг эрт үед нь илрүүлэх хиймэл оюун ухааны аппаратыг Гурвантэс СЭМТ-д нийлүүлж ашиглалтад өгсөн)</p> <p>-Сумдын ЭМТ-үүдэд шаардлагатай эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжүүд (“Мехатроник” ХХК шалгарч 400.000.001 төгрөгийн гэрээ хийсэн ба 2024 оны 10-р сарын 9-ний өдөр ЭМБ-уудад хүлээлгэн өгсөн. 14 ЭМБ-д нийт 33 нэр төрлийн 64ш эмнэлгийн тоног төхөөрөмжийг ЭМГ-ын даргын тушаалын дагуу хуваарилан өгсөн. Гэрээний дагуу ариутгалын гэрлийг техник үзүүлэлтэд нийцүүлж өгөхөөр албан тоот ирүүлсэн байгаа)</p> <p>-Сэврэй, Баяндалай, Хүрмэн сумдын ЭМТ-д шаардлагатай эмнэлгийн болон сургалт, гал тогооны тоног төхөөрөмж, тохижилтод шаардлагатай тавилгууд (“Космос тек”ХХК шалгарч гэрээ хийгдсэн. Нийт төсөв 618 сая. Хүрмэн СЭМТ-д 247.017.911 төгрөгийн төсвөөр нийт 59 нэр төрлийн 214 ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Баяндалай СЭМТ-д 140.363.830 төгрөгийн төсвөөр нийт 35 нэр төрлийн 79 ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, Сэврэй СЭМТ-д 230.618.259 төгрөгийн төсвөөр нийт 87 нэр төрлийн 296ш тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл нийлүүлэгдсэн байна)</p> <p>-Сэврэй сумын ЭМТ-д зөөврийн рентген аппарат нийлүүлэгдэн ашиглалтад орсон байна (“Био реагент” ХХК 94 сая төгрөгийн төсвөөр зөөврийн рентген аппаратыг Сэврэй СЭМТ-д 2024 оны 5-р сард нийлүүлсэн)</p>	
--	--	---	--

		<p>-Шүдний төвд шаардлагатай тоног төхөөрөмж 50 сая төгрөгийн төсөвтэй ажил нь оролцогч орж ирэхгүй байгаа учир дахин тендер зарлагдаад явж байна.</p> <p>-Нэмэлтээр аймгийн онцгой комиссоос -189,745,000 БОЭТ-ийн гемодиализийн тасагт нэн шаардлагатай байгаа диализийн аппарат болон усны систем, мөн ангиографын аппаратыг байнгын хэвийн ажиллагаанд оруулахтай холбоотой худалдан авалтыг хийхээр төсвийг аймгийн онцгой комиссоор шийдвэрлүүлж худалдан авалт амжилттай зохион байгуулагдаж ашиглалтад орсон.</p> <p>-БОЭТ-ийн лабораторийн тасагт Элэгний В,С вирусийн идэвхжил тоолох болон бэлгийн замын далд халдвар илрүүлэх шинжилгээг хийх боломжтой ПСР аппаратыг хүлээж аван, ашиглалтад оруулсан. “Антиген” ХХК нийт 110 сая төгрөгөөр нийлүүлсэн.</p> <p>“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар 172,700,000, БОЭТ-ийн угаалгын хэсэгт шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд зориулалтын угаалгын машин-2ш, Хатаагч-2ш, бул индүү болон уурын индүү тус тус 1-ш мөн “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн. 928,884,000-БОЭТ, ЗӨСТ, ЭМГ-т шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд сургалтын тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн..</p>	
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц үр дүн	2018-2021 онд Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилласан. ХБГүйцэтгэл 2022-2025 онд Нэгдсэн хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гарган санхүүжилтийн 60% болох 600,0 сая төгрөгийн санхүүжилтийг авч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хуулийн дагуу тоног төхөөрөмж болон удирдамж, хөтөлбөрийн дагуу 23 төрийн сургалт, худалдан авалтыг зохион байгуулан нийт 554,1 сай төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийн мэдээллийг шилэн дансанд байрлуулан ажиллаж байна.	100

3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа шинжилгээний ажил, түүний тайлан	<p>Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хүн амын өвчлөл, тархалтыг тогтоох оновчтой хариу арга хэмжээг авч ажиллах хүрээнд 4 төрлийн судалгаа шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс Өмнөговь аймгийн Даланзадгад сумын хэмжээнд умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч папилома вирусийн тархалтыг 100 эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулсан. Судалгаанд 30-аас дээш насны 100 эмэгтэй оролцсон ба эмэгтэйчүүдийн 41%-д нь папилома вирусийн хэв шинж илэрсэн ба үүнээс өндөр эрсдэлтэй 16 төрөл, бага эрсдэлтэй 4 төрлийн хэв шинжүүд илэрсэн байна. Мөн умайн хүзүүний хорт хавдар үүсгэгч хүний папилома вирусийн өндөр эрсдэлтэй 16 дугаар хэв шинж 9%-д илэрсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн 6-16 настай хүүхдүүдийг 12 төрлийн үзүүлэлт, 2 төрлийн асуумж судалгаагаар 22 сургуулийн 10000 гаруй хүүхдийг судалгаа шинжилгээнд хамруулахаас нийт судалгаанд оролцогчдын 50%-ийг хамруулж дата мэдээллийг нэгтгэж байна. Судалгааны үр дүнд 6-16 настай хүүхдүүдийн өвчлөлийн тархалт, эрдсийн түвшин, бөөс, цагаан хорхой, илүүдэл жин, зэрэг чиглэлээр судалгаа шинжилгээний мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийгдэнэ. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын үсчин гоо сайхны үйл ажиллагаа эрхэлдэг 20 аж ахуй нэгжээс 2 төрлийн эмгэг төрүүлэгч илрүүлэх судалгаа шинжилгээг 10 төрлийн багаж хэрэгсэл, бусад цэгүүдээс 200 арчдас шинжилгээ судалгааг авсан. Үүнээс стафилококк (<i>Staphylococcus aureus</i>) эмгэг төрөгч 4,5%(9), <i>E.coli</i> эмгэг төрөгч 1%(2) илэрсэн байна. Стафилококк (<i>Staphylococcus aureus</i>) эмгэг төрөгч илэрсний 33,3%(3) нь хумсны маникюрын хэрэгслээс, 44,4%(4) үсчин гоо сайханчдын ажлын хувцас, хормогч, нөмрөгт илэрсэн байна. Өмнөговь аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн 6-16 насны 16197 хүүхдээс стрептококкийн халдварын тархалтыг тогтоох судалгааны ажлын хүрээнд судалгаанд 14513 хүүхдийг хамруулж 51,2%(7430)-ийг эрэгтэй хүүхэд эзэлж байна. Судалгаанд оролцогчдын 2.9%(418) нь стрептококкийн халдвар эерэг үзүүлэлтэй байна.</p> <p>Судалгааны нэг агшингийн загвар ашиглан дээрх 4 төрлийн судалгааг шинжилгээний ажлыг аймаг орон нутгийн түвшинд зохион байгуулан ажилласан. Судалгаа шинжилгээний үйл ажиллагаанд 19613 иргэн, 42 объект хамрагдсан байна.</p>	100
------	---	---	-----

		Хийгдсэн судалгааны тоо-4	
<b>Хэсгийн дундаж хувь</b>			<b>99,6</b>
<b>Дөрөв. Үзүүлж байгаа тусламж үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдал</b>			
4.1	Үйлчилгээний төрөл шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг түүний загвар төлөх төлбөр хураамж зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	<p>Байгууллагын цахим хуудасны Төрийн үйлчилгээ линк хэсэгт тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, эмнэлгийн эмч, мэргэжилтний эмчлэх эрх гэсэн хэсэгт журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний төлбөр хураамж, төлбөрийн хэмжээ, мэдээлэл авах мэргэжилтний мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхийн эрүүл мэндийн байгууллагууд, Магадлан итгэмжлэлтэй эмнэлгүүдийн мэдээлэл жагсаалтыг ил тод тавьж мэдээллийг тухай бүр шинэчилж байна.</p> <p>2024 онд аймгийн хэмжээнд эмнэлгийн магадлан итгэмжлэлд орох 11 эрүүл мэндийн байгууллагад тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах талаар мэргэжил аргазүйн зөвлөмж өгч ажилласан.</p> <p>2024 оны II улиралд 6 сумын эрүүл мэндийн төв, 2 хувийн хэвшлийн эмнэлэг, 1 өрхийн эрүүл мэндийн төв, III улиралд 1 сумын эрүүл мэндийн төв 1 хувийн хэвшлийн эмнэлэг төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу магадлан итгэмжлэлийн шинжээч нар ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/426 дугаар тушаалаар Ноён сумын эрүүл мэндийн төв 1 жил, Хүрмэн сумын эрүүл мэндийн төв 2 жилээр, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 сарын 13-ны А/346 дугаар тушаалаар, Шимбилэг өрхийн эрүүл мэндийн төв 2 жил, Баяндалай сумын эрүүл мэндийн төв 2 жил, Баян-Овоо сумын эрүүл мэндийн төв 4 жил, Мандал-Овоо сумын эрүүл мэндийн төв 2 жил, Маналговь эмнэлэг 1 жилээр, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/296 дугаар тушаалаар Гурвантэс сумын эрүүл мэндийн төв 2 жил, Булган сумын эрүүл мэндийн төв 2 жил тус тус магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт хангаж, магадлан итгэмжлэгдсэн.</p>	100

4.2	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг салбар төлөөлөгчийн газар зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хугацаа	<p>Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс 11 удаа хуралдаж, нийт дараах чиглэлийн 89 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.</p> <p>1.Шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 21 төсөлд эхний шатны хэрэгцээний үнэлгээ хийгдэж, 4 төслийг буцаасан.</p> <p>2.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 36 ЭМБ-н хүсэлтийг хэлэлцэж, үүнээс 9 эмнэлэг, 1 сувилал, 2 АШМУХ, 18 эмийн сангийн хугацааг сунгасан.</p> <p>3.Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шаардлага хангаагүй 2 эмнэлэг, 1 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг цуцалсан.</p> <p>4.Эмнэлгийн тусламж үйлчилгээний чиглэл нэмэх болон хасах 6 эмнэлгийн хүсэлтийг шийдвэрлэв.</p> <p>5.Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлын хүрээнд 5 удаа хэлэлцсэн.</p> <p>Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаас гарсан шийдвэрийг ЭМГД-н 9 удаагийн тушаалаар баталгаажуулж, 9 удаагийн удирдамжаар 22 ЭМБ-д шинжээчийн баг ажиллуулж үнэлгээ дүгнэлт гаргуулсан ба 84 ЭМБ-д комиссын зөвлөмжийг хүргүүлсэн. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд license.mn цахим системийг нэвтрүүлж, тусгай зөвшөөрөл бүхий 124 ЭМБ-ын мэдээллийг шивж мэдээллийг санг үүсгэсэн. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан байгууллагын тоо-36. Шинээр олгосон тоо -16. Тусгай зөвшөөрлийг цуцалсан-3. Хяналт үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо-22.</p>	100
<b>Хэсгийн дундаж хувь</b>			<b>100</b>
Тав. Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал			
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын	Эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг үнэлэх журмын төслийг мэргэжилтнүүдээс санал авч шинэчлэн боловсруулж, удирдлагын багын хурлаар хэлэлцүүлэн ЭМГ-н даргын А/59 дүгээр тушаалаар баталгаажуулан	100

	төсөл, тэдгээрийн танилцуулга холбогдох судалгаа бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	эмнэлгүүдэд хүргэсэн ба байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Мөн байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга тогтоол журмын дагуу болгох зорилгоор ЗГХЭГ-н даргын 98 дугаар тушаалын дагуу байгууллага дээр үнэлгээний багийг байгуулж, үнэлэх болон үнэлгээний багийн ажиллах журмыг боловсруулан нийт ажилчдад сургалт зохион байгуулах, батлуулсан тушаалыг цахим хуудсанд байршуулсан. ЭМЯамнаас ирүүлсэн Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам, Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам"-ын төсөлд тус тус санал өгч ажилласан.	
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	байхгүй	
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл	Эрүүл мэндийн газрын дансанд бүртгэлтэй албан конторын зориулалтаар 600м2 талбай бүхий 15,000,000 төгрөгийн газрын эзэмших гэрчилгээг 2021 оны 09 сард шинээр нэмж бүртгэсэн боловч Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 04 сарын 30-ны өдрийн 17/17 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн данснаас хасаж шийдвэрлэсэн.	100
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан Эрүүл мэндийн газрын дансанд бүртгэлтэй 4 газрыг газар эзэмших гэрээний дагуу 15 жилийн хугацаанд ашиглах албан конторын барилгын зориулалтай нийт 31203 м2 талбай бүхий 765075000 төгрөгийн үнийн дүнтэй газрыг үндсэн хөрөнгөнд бүртгэн эзэмшиж байна .	100
5.5	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр хаяг дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг алдагдлын тайлан,	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд байхгүй.	-



	нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг		
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг эхийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд байхгүй.	-
5.7	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх хувьчлах төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд байхгүй.	-
5.8	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл үйлчилгээ, ашиглаж байгаа техник технологийн хүн мал амьтны эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх буюу	хамааралгүй	-


	үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл		
5.9	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн салбарт баригдаж байгаа эмнэлгийн барилгыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Онцгой байдлын газар, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Өмнөд бүсийн цахилгаан түгээх ТӨХК, Дулааны цахилгаан станц ТӨХК болон захиалагч талаас Эрүүл мэндийн газар, АЗДТГазар гэх мэт холбогдох байгууллагын мэргэжлийн багийг томилж хүлээн авч байна. 2024 онд Баяндалай суманд 15 ортой, лифттэй сумын эрүүл мэндийн төв, Манлай, Хүрмэн, сумын 15 ортой эмнэлгийн барилгад улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авч ашиглалтад оруулсан.	100
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42-р зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ	Байхгүй.	
5.11	Нэвтрэх ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	2015 оноос хойш байгууллагын албан хэрэг хөтлөлтийн явцад ABLE, E-OFFICE, архивын ARMS-ORGANIZATION програмуудыг тус тус нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашигладаг. 2024 онд ирсэн бичиг-1641, явсан бичиг-953, Эрүүл мэндийн газрын даргын А, Б тушаалууд-194 гарсныг тогтмол бүртгэж цахимжуулан ажиллаж байна.	100
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг эхийн нэр өөрийн нэр суралцаж байгаа улс сургуулийн нэр, мэргэжил суралцах хугацаа мэдээлэл хариуцагчаас	2024-2025 оны төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад-7, төрөлжсөн мэргэшлийн сургалтад-12, мэргэшил дээшлүүлэх сургалтад 13 их эмч, 7 сувилагч, тусгай мэргэжилтэн суралцахаар эрүүл мэндийн сайдын А/125 дугаар тушаалаар хяналтын тоо батлагдсан. Төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх хаврын элсэлтэд 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн улсын төсвийн	100

	санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	санхүүжилтээр суралцаж байна. Үндсэн мэргэжлийн сургалтад-4 их эмч, төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх намрын элсэлтэд 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна.	
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Байхгүй	
<b>Хэсгийн дундаж хувь</b>			<b>100</b>
<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>			<b>99,3</b>

ХЯНАСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  Д.ЖАВЗАНДУЛАМ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ  
МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ЦАГААНЦЭНД

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮНЭЛГЭЭНД ХАМААРАХ ЗААЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ**

ЭМС-н 2022 оны 346 тушаалын 3.1.4

Өмнөговь аймгийн ЭМГ

2024.12.05

№	Үйл ажиллагааны нэр	Хэрэгжилт	Хүрсэн үр дүн
<b>3.1.4 Эрүүл мэндийн салбарын үнэлгээ</b>			
1	3.1.4.1 Эмнэлзүйн удирдамж, стандартын хэрэгжилтийн байдал.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг сум болон өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгаас 2 сургагч багш бэлтгэгдсэн. Тухайн сургагч багш нар Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 120 эмч, ажилчдад, 9 удаагийн сургалт зохион байгуулсан. Мөн 10 сумын эрүүл мэндийн төв, 3 хувийн эмнэлэгт 3 бүлэг, 55 шалгуур үзүүлэлтээр стандартын хэрэгжилтийг үнэлэхэд 95 хувь байсан ба цаашид хэрэгжүүлэх ажлын талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.	Эрүүл мэндийн байгууллагууд үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлснээр сэтгэл ханамжийн судалгаагаар сөрөг сэтгэгдэл гараагүй.
2	3.1.4.2 Эмнэлзүйн удирдамж зааврын хэрэгжилт	Анхан шатны тусламж үйлчилгээнд өргөн хэрэглэгдэж буй тус тоног төхөөрөмжийг урьдчилан сэргийлэх үзлэг, сэргийлж болох нас баралтыг бууруулах төлөвлөгөөт, болон төлөвлөгөөт бус арга хэмжээтэй уялдуулан ашиглалтыг сайжруулж байна. Өнгөрсөн оны тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгаанд үндэслэн ЭМЯ-аас 4 сумын ЭМТ-д шинээр мобайл технологийн тоног төхөөрөмжийг дахин нийлүүлж ашиглалтын болон эмнэлзүйн сургалтыг зохион байгуулсан.	Эмнэлзүйн удирдамж, зааврыг дагаж мөрдсөнөөр эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оношийн зөрүү гараагүй.

		<p>1.Жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай (ЭМС-н 2019 оны А/563 дугаар тушаал) 2024-01-09 А/11</p> <p>2.Эрүүл мэндийн тусламж үйлчигээтэй холбоотой үүсэн тохиолдлыг бүртгэх мэдээлэх хариу арга хэмжээ авах ЭМС-ын 2024.03.05 тушаал А/112</p> <p>3.Тохиолдол эрсдэлийн мэдээллийн нэгдсэн санг ашиглах журам ЭМС-ын 2024.03.05 тушаал А/112</p> <p>4.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө боловсруулах үнэлэх тайлагнах заавар ЭМС-ын 2024.03.05 тушаал А/112</p> <p>5.Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам)А/292 2024-06-24</p> <p>6.Цусны байнгын болон амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журам)А/2072024-05-03</p> <p>7.Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар) А/256 2024-06-03</p> <p>8.Хүүхдэд тохиолдох томуу, томуу төст өвчний эмнэлзүйн заавар батлах тухай А/2862024-06-14</p> <p>9.Чих, хамар, хоолойн өвчний эмнэлзүйн заавар батлах тухай А/157 2024-04-02</p> <p>10.Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журамА/259, А/173, А/94 2024-06-04</p> <p>11.Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын 2024-2026 оны арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай А/147 2024-03-29</p> <p>12.Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм батлах тухай А/320 2024-07-08</p> <p>13.Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, хяналт тавих, гэрээг сунгах, дуусгавар болгох журмыг батлах тухай А/122 2024-03-15</p>	
--	--	---	--

		<p>2024 онд шинэчлэн батлагдсан дээрх 13 эмнэлзүйн удирдамжийг татан авч анхан шат болон лавлагаа шатлалд мэдээллэж эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөн ажиллаж байна.</p> <p>Мөн өнгөрсөн онд батлагдсан</p> <p>Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам 2023 оны А/240, “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд танхим болон цахимаар сургалт арга зүйг зохион байгуулсан..</p>	
3	3.1.4.3 Эрүүл мэндийн технологи, инноваци	<p>2024 онд нэвтрүүлсэн шинэ технологи:</p> <p>1. Молекул биологийн лабораторит BIO RAD ПСР аппарат, BIO NEER ялгах аппаратыг нэвтрүүлсэн. Тус аппаратаар доорхи нэр төрлийн шинжилгээ хийгдэж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>-Бэлгийн замын далд халдвар илрүүлэх STI-14 ийн шинжилгээ - 473 хүнд</li> <li>-Хүний хөхөнцөр вирусийн 29 генотипийг илрүүлэх HPV, 200 хүнд</li> <li>-Элэгний ачаалал үзэх HBV, HDV, HCV, 1,029 хүнд</li> <li>-Улаан бурхан улаануудын шинжилгээ, 3 хүнд</li> </ul> <p>2.Хавдрын маркерийн шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэн. Одоогоор 6 төрлийн хавдрын маркерийн шинжилгээг хавдар илрүүлэх, оношлох, тавиланг таамаглах, эмчилгээний үр дүнг хянах болон хавдрын дахисан эсэхийг илрүүлэх зорилгоор эмнэлзүйн практикт ашиглаж байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>-AFP- Элэгний эсийн хорт хавдар, үр хөврөлийн эсийн хавдрын маркери.</li> <li>-CA125 - Өндгөвчний хавдрын эмчилгээ, оношлогооны гол маркери.</li> <li>-CEA - Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын маркери.</li> <li>-CA19-9 - Нойр булчирхайн хавдрын гол маркери.</li> </ul>	<p>Шинэ технологиудыг орон нутаг нэвтрүүлж, нутагшуулснаар иргэд орон нутагтаа эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй авах боломж нөхцлийг бүрдүүлсэн.</p>

		<p>-CA15-3 - Хөхний хавдрын маркери.</p> <p>-CA-72-4 - Ходоодны хавдарын маркери.</p> <p>3.Дотор болон хөнгөвчлөхийн тасгийн үйлчлүүлэгчдэд эмчилгээний зорилгоор төвийн венийн гуурсыг цээжний болон хэвлийн хөндийд байршуулж байна. 2024 онд нийт 8 хүнд цээжний гуурс байрлуулсан. 20 хүнд хэвлийн гуурс байрлуулж эмчилгээ хийсэн.</p> <p>4.Ангиографийн тусламж үйлчилгээг зүрх судасны, мэдрэлийн, хэвлийн, хавдрын чиглэлээр үзүүлж эхэлсэн. ЭМЯ-наас томилогдсон Үндэсний багийнхныг эмч, мэргэжилтнүүд дагалдан суралцаж, орон нутагт нутагшуулахаар ажиллаж байна.</p>	
4	3.1.4.4 Зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, эмийн чанар, аюулгүй байдал	<p>Сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах [ӨМАЭМГ/20240102007]-ын тендер шалгаруулалтыг 1 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 13 тендерт оролцогчийн 51 багцын үнэлгээнээс 10 эм ханган нийлүүлэх байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж, 14 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвд эм, эмнэлгийн хэрэгслийг тогтвортой татан авч ханган ажилласан.</p> <p>Мөн ерөнхий гэрээний нөхцлөөр, цахим дэлгүүрээс 6 удаа нэгдсэн худалдан авалтыг зохион байгууллаа. 2024 оны тендерийн гэрээний гүйцэтгэл 89 хувь, ерөнхий гэрээний гүйцэтгэл 98 хувьтай хэрэгжсэн.</p> <p>Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр БОЭТ, 5 сумын эрүүл мэндийн төвд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг үнэлэн ажилласан.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эм зүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, эм зүйн тусламж үйлчилгээтэй холбоотой батлагдсан заавар журам тушаалын хэрэгжилтийг сайжруулах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагад эм, эмнэлгийн хэрэгсэл хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах зорилгоор цахим</p>	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг 85-аас дээш хувьтай тасралтгүй хангаснаар тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх нөхцөл хангагдсан.

		<p>сургалтыг АШУҮИС-тай хамтран зохион байгуулж, сургалтад 11 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>ДЭМБ -аас жил бүр зарладаг Эмийн зохистой хэрэглээний 10 хоног болон бичил биетний тэсвэржилтийн дэлхийн 7 хоногийн үйл ажиллагаануудыг зохион байгуулж, аяны хугацаанд 129 эмнэлгийн мэргэжилтэн, 448 иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалт суртачилгааг зохион байгуулж, 77 удаагийн постер, богино бичлэг, видео бичлэгийг цахим орчинд байршуулж, хуваалцах зэргээр цахим орчинд мэдээллийг түгээсэн. Иргэдэд зориулсан өдөрлөгийн үйл ажиллагааг Даланзадгад сумын 17 эмийн сангаас 436 иргэнд Антибиотикийн зохистой хэрэглээ, Эмийн гаж нөлөө, эм хэрэглэх 5 зөвийн зарчим зэрэг мэдээ мэдээллийг хүргэж, витаминжуулалт амны хаалтыг иргэдэд түгээж ажилласан.</p> <p>Иргэдийн Зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Гурвантэс, Цогтцэций суманд ажиллаж байгаа эмийн сангуудад олгож, эмийн сангийн мэргэжилтнүүдэд өндөр эрсдэлт эмэнд холбогдох тушаал журмын хэрэгжүүлэн ажиллах чиглүүлэх арга зүйн сургалтыг 1 удаа зохион байгуулсан.</p>	
5	<p>3.1.4.5 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүн</p>	<p>Аймгийн ЗДТГ, НБХ, ЭМГ хамтран аймгийн БОЭТ, СЭМТ, ӨЭМТ, хувийн эмнэлэг, сувиллын газар, Говь дент шүдний төв зэрэг 26 байгууллагуудын халдварын сэргийлэлт хяналтын багийн 45 эмч, мэргэжилтэнд 2 өдрийн, 16 цагийн онол, дадлага, хосолсон сургалтыг зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан 45 эмч, мэргэжилтнийг “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежмент, халдвараас өөрийгөө хамгаалах” сургалтын гарын авлагаар хангасан.</p> <p>Мөн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тусламж үйлчилгээг сайжруулах үйл ажиллагааг тогтмолжуулах мэргэжлийн ЗӨВЛӨХ БАГ ажиллуулах удирдамжийн дагуу ГОХДС-ийн санхүүжилт, ЭМХТ-ийн дэмжлэгээр ЭМТҮЧАБА, ХСХ-ын албаны үйл</p>	<p>Эмнэлгээс шалтгаалсан халдвар бүртгэгдээгүй.</p>



		<p>ажиллагаанд үнэлгээ хийлгэж, чанар, халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах чиглэлээр ажлын байрны сургалт зохион байгуулагдаж байна. АШЭМБ-уудад дараах чиглэлээр цахим сургалт зохион байгуулсан.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Халдварын талаарх ойлголт</li> <li>2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар</li> <li>3. Дахин хэрэглэгддэг багажийн угаалга цэвэрлэгээ</li> <li>4. Эмнэлгийн орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл</li> <li>5. Хог хаягдлын ангилан ялгалт, тээвэрлэлт хадгалалт ариутгал халдваргүйтгэл</li> <li>6. ЭТҮХХ-ын лабораторийн баталгаажилт, чанарын хяналт</li> <li>7. Халдваргүйтгэлийн бодист тавих шаардлага, хэрэглэх</li> </ol> <p>Аймгийн 17 эрүүл мэндийн байгууллагын мэс заслын дараах шархны халдварын тандалтыг 198 үйлчлүүлэгчдэд, судасны гуурстай(уян зүү) холбоотой халдвар илрүүлэх тандалтыг 154 үйлчлүүлэгчдэд, төрсний дараа эх, нярайг эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэх болон гэрийн эргэлт хийх үед халдвар илрүүлэх тандалтыг 115 үйлчлүүлэгчдэд, шээлгүүртэй холбоотой шээсний замын идэвхтэй тандалтыг 18 иргэнд хийсэн байна.</p> <p>Тандалтад хамрагдсан байгууллагын тоо-18 Бэлтгэгдсэн халдвар хяналтын ажилтны тоо-45</p>	
6	3.1.4.6 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой гомдлын шийдвэрлэлт	<p>2024 онд нийт 31 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн.</p> <p>Үүнд: Засгийн газрын 11-11 утсанд 24 70530001- утсанд -2 Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд утсаар хүсэлт-1</p>	Гомдол гаргасан иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэснээр тухайн иргэн дахин гомдол гаргаагүй.

		<p>Бичгээр эмчилгээний төлбөрийн дэмжлэг хүссэн хүсэлт -1</p> <p>Бичгээр гомдол-3</p> <p>Мөн өргөдөл гомдлын тайланг 4 удаа улирал бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-т хүргүүлсэн.</p> <p>Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ЭМБ-ын үйлчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 30 санал гомдол энэ онд бүртгэгдэж, тухайн ЭМБ-тай холбогдож, тодруулга, мэдээлэл авсны дагуу иргэнд, хугацаанд нь хариуг хүргүүлж, шийдвэрлэж ажилласан. Нийт өргөдөл гомдлын 70хувь нь БОЭТ-тэй холбоотой байсан тул давтан өргөдөл, гомдол гаргахгүй байх талаар удирдлагын багтай 2 удаа уулзалт, хэлэлцүүлэг, мэргэжлийн дэмжлэгт хяналт үнэлгээ 1 удаа, эмч, мэргэжилтний ёсзүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалт 2 удаа зохион байгуулж, албан бичгээр зөвлөмж 1 удаа хүргүүлсэн.</p>	<p>Мөн тухайн тусламж үйлчилгээний асуудлаарх гомдол давтаж гараагүй.</p>
7	<p>3.1.4.7 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн</p>	<p>Эрүүл мэндийн яамны Ёс зүйн хяналтын хорооноос “Эрүүл мэндийн байгууллагын соёлд хувь хүний хөгжил, үйлчилгээний стандартыг хэвшүүлэх нь” сэдэвт сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр танхим болон цахим хослуулан зохион байгуулж нийт 126 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон. АШУҮИС-ийн сувилахуйн сургуулийн багш нар 2024.04.22-23-ны өдрүүдэд сувилагч тусгай мэргэжилтнүүдэд “Харилцааны урлагт суралцахуй”, “Хувь хүний хөгжлийн хандлага”, “Сувилагчийн ёс зүйн зарим асуудал” сэдвүүдээр сургалт зохион байгуулж нийт 205 сувилагч, тусгай мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <p>2024.05.2-3 өдрүүдэд Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн хяналтын хорооны дарга О.Оюунбилэг эрүүл мэндийн байгууллагын дарга, удирдлагуудад удирдлагын манлайлал, ёс зүй сэдвээр сургалтыг орсон.</p> <p>2024.11.04-ний өдөр эрүүл мэндийн салбарт шинээр ажилд орсон эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд баримжаа олгох сургалтыг зохион байгуулж тус сургалтад Эрүүл</p>	<p>Эмнэлгийн ажилчдын харилцаа хандлага болон Хөтөч сувилагчийн иргэдэд үйлчлэх арга барил сайжирсан.</p>

		<p>мэндийн яамны ёс зүйн хяналтын хорооны дарга Ц.Оюунбилэг “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийг танилцуулж сургалтад БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон 40 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.</p> <p>Эрүүл мэндийн салбарын жолооч, үйлчлэгч, туслах ажилчдыг хөгжүүлэх, ёс зүй харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалтыг 2024.11.04-ний өдөр зохион байгуулж тус сургалтад ЭМГ-ын НЭМТ-ийн Сэтгэцийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Б.Ганцэцэг ёс зүй, харилцаа хандлага, super jump-н сургагч багш Г.Өлзийбүрэн амьдралаас та юу хүсдэг вэ? зэрэг ёс зүй, харилцааны сургалтыг зохион байгуулж сургалтад 55 туслах ажилчид хамрагдсан юм.</p> <p>эмч мэргэжилтнүүдийн дунд ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан тоо-496</p>	
8	<p>3.1.4.8 Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээний болон нөхөн сэргээх үеийн төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал</p>	<p>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, эрүүл мэндийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж бэлтгэл бэлэн байдлыг хангасан. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож бэлэн байдал, хариу арга хэмжээг төлөвлөх төлөвлөгөөний хүрээнд томуугийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилтын 73 арга хэмжээг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 95,6 хувьтай хэрэгжсэн. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, онцгой байдлын үеийн бэлэн байдал хангах, хариу арга хэмжээг төлөвлөж ажиллах чиглэлээр сумдын засаг дарга, сумын эрүүл мэндийн төвүүдэд 2 удаагийн зөвлөмж чиглэлийг хүргүүлэн ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 08 сарын 05-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар "Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний" улаан бурхан өвчнөөс сэргийлэх, сэжигтэй тохиолдлыг илрүүлэх, тандах баг байгуулж чиглэлийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, зөвлөмжөөр хангаж ажилласан. Аймгийн хэмжээнд цочмог халууралттай тууралттай сэжигтэй 2 тохиолдлыг бүртгэн сорьцыг ХӨСҮТ-ийн лабораторид хүргүүлсэн. Шинжилгээний хариу сөрөг гарч сэжигтэй тохиолдол</p>	<p>Жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 95,6 хувьтай хэрэгжсэн</p>

		үгүйсгэгдсэн.	
9	3.1.4.9 Байгууллагын эрсдэлийн удирдлага, эрсдэл бууруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн байдал	<p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумдын эрүүл мэндийн төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлын хүрээнд 2024 онд Номгон, Сэврэй сумдын ЭМТ-ийг 220/380В-ийн 5,5-6 КВт хүчин чадал бүхий дизель хөдөлгүүрээр тус тус хангаж, ашиглалтад оруулсан. Ингэснээр БОЭТ, 14 сумын Эрүүл мэндийн төвүүд, 3 Өрхийн эрүүл мэндийн төв цахилгаан тасарсан үед найдвартай нөөц цахилгааны эх үүсвэрээр бүрэн хангагдсан.</p> <p>- Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар сумдыг ойрын болон холын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашинаар хангах нийт төсөвт өртөг 1,280,000,000/нэг тэрбум хоёр зуун наян сая/, Багц-1: Эмнэлгийн түргэн тусламжийн автомашин- 1ш /Landcruiser-76/, Эмнэлгийн түргэн тусламжийн тоноглогдсон автомашин-4ш /Landcruiser 78/ төсөвт өртөг: 1,040,000,000 /Нэг тэрбум дөчин сая/ төгрөг, Багц-2: Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай туулах чадвар сайтай автомашин /Landcruiser 300 GX-R Leather/ төсөвт өртөг: 240,000,000 /Хоёр зуун дөчин сая/ төгрөг байхаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж байна.</p> <p>- 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 680 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн Landcruiser 78 автомашиныг Булган, Ханхонгор, Цогт-Овоо сумын эрүүл мэндийн төвд,</p> <p>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 71,800,000 сая төгрөгийн үнэ бүхий УАЗ-Фургон автомашиныг Эрүүл мэндийн газарт, ЭМЯ-с Герман үйлдвэрийн Мер маркын түргэн тусламжийн алсын дуудлагын бүрэн тоноглогдсон автомашиныг БОЭТ-д тус тус хүлээлгэн өгсөн.</p> <p>Автомашинаар хангагдсан ЭМБ-ын тоо-5 Худалдах авах ажиллагааны тендэр зарлагдсан-8</p>	<p>Цахилгааны эх үүсвэрийн хангалт 100 хувь</p> <p>Автомашины Стандарт хангалт хангалт -80 хувь</p> <p>Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дунджаар 99,1% байна.</p>

		<p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем Tender.gov.mn цахим дэлгүүрээс 9 удаагийн худалдан авалтаар 23 Эм ханган нийлүүлэх байгууллагатай ерөнхий гэрээний дагуу 118 удаа гэрээ байгуулж давхардсан тоогоор 611 нэр төрлийн 468,168,675₮-н эм, эмнэлгийн хэрэгслийг татан авч Эрүүл мэндийн байгууллагуудын захиалгын дагуу түгээлт хийж зайлшгүй шаардлагатай эмийн хангамж хүртээмжийг тогтвортой хангасан.</p> <p>Эргэлтийн эмийн сангуудад нийт 13637 жор ирсний 41,5% /5663/ нь ЭМДаатгалын, 0,9%/136/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 57,5% /7838/ нь энгийн эмийн жор байсан байна.</p>	
10	<p>3.1.4.10 Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүн</p>	<p>Эрүүл мэндийн газрын Үйлдвэрчний Хороо нь 2019 онд хамт олны хурлаар сонгогдсон 3 гишүүнтэй ажиллаж байгаад 2 гишүүн /өндөр насны тэтгэвэр болон өөрийн хүсэлтээр/ ажлаас чөлөөлөгдсөн шалтгаанаар 2024 онд 1 хүний бүрэлдэхүүнтэй болсон.</p> <p>2024 онд Өмнөговь аймагт зохион байгуулагдсан Хөдөлмөрлөх эрх бүсийн сургалтад үйлдвэрчний хорооны тэргүүлэгч гишүүн хамрагдаж, сургалтаас авсан мэдээ мэдээллийг байгууллагын гишүүдэд танилцуулж ажилласан.</p> <p>Үйлдвэрчний хорооны гишүүдийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хуримтлалыг зарцуулах журам болон цаашид хийх үйл ажиллагаанд санал авч ажилласан.</p> <p>Байгууллагын эмэгтэйчүүдэд зориулсан өдөр тутмын арьс арчилгаа, нүүр зөв будах сургалтыг мэргэжлийн гоо сайханчтай хамтран 1 удаа зохион байгуулсан.</p>	<p>Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороо ажилчдын 100 хувийн саналыг тусган ажилласан</p>
11	<p>3.1.4.11 Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн</p>	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцын хяналт үнэлгээг хийж 89,7 хувьтай үнэлэгдсэн. Хяналт үнэлгээний дүнд зөвлөмж ирүүлсний дагуу төлөвлөгөө гарган хэрэгжилтийн тайланг хүргүүлсэн.</p> <p>УИХ-ын тогтоол- 2, Монгол улсын хууль-3 Ерөнхийлөгчийн зарлиг-2 Засгийн газрын тогтоол-12</p>	<p>Эрүүл мэндийн Газрын ХШҮМХэлтэс нь ХШҮМХ дарга, статистикч их эмч-1, мэдээний сан хариуцсан ажилтан-1, мэдээлэл технологийн</p>

		<p>Засгийн газрын албан даалгавар-1  Сайдын тушаал-47  АИТХ-ын тогтоол-9  ЗДҮАХ-ийн заалт-26  Засаг даргын захирамж-1  Засаг даргын албан даалгавар-3  Дэд хөтөлбөр -5  Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний заалт-17  Бусад-2 заалтыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг тайлагнасан.  Эрүүл мэндийн газрын 22 албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт тайлагналдтад хяналт үнэлгээг 2 удаа, ажлын байрны эмх цэгц, эмийн нөөц хадгалалт, вакцины нөөц хадгалалтад зэрэгт дотоод хяналт үнэлгээг 1 удаа хийж аргагүйн зөвлөгөөг өгсөн.  ЗӨСТ-10 ажилтан, 17 Эрүүл мэндийн байгууллагын 21 ажилтан, Эрүүл мэндийн салбарт шинээр ажилд орсон 45 ажилтанд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх журмын талаарх сургалт 1 удаа хийсэн.  Эрүүл мэндийн газрын даргын удирдамжийн дагуу 12 Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээг хийж 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Мандал-овоо, Номгон, Ноён, Ханхонгор, Хүрмэн, Ханбогд, Цогтцэций сумын эрүүл мэндийн төвүүд, Зоонозын өвчин судлалын төв, Тэгшдүүрэн, Аминбулаг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад хийж зөвлөмжөөр хангасан. Мөн 2023 оны зөвлөмжийн хэрэгжилтийг нотолгоонд тулгуурлан үнэлж аргагүйн зөвлөгөө өгч сайжруулах арга хэмжээг зөвлөмжөөр хүргүүлсэн.  2024 онд нийт 31 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн.  Үүнд: Засгийн газрын 11-11 утсанд 24  70530001- утсанд -2  Байгууллагын өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэнд утсаар хүсэлт-1  Бичгээр эмчилгээний төлбөрийн дэмжлэг хүссэн хүсэлт -1  Бичгээр гомдол-3  Мөн өргөдөл гомдлын тайланг 4 удаа улирал бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-т хүргүүлсэн.  Цогтцэций сумын эрүүл мэндийн төвд иргэнээс ирсэн өргөдөл гомдлын дагуу хяналт хийж өргөдлийг шийдвэрлэсэн.</p>	<p>инженер-1 нийт 4 орон тоотойгоор ажиллаж, байгууллагын дотоод болон гадаад хяналтыг хариуцан бодлогын баримт бичиг, архив албан хэрэг хөтлөл стандарт хангалт, байгууллагын ил тод байдал, шилэн дансны мэдээлэл, хувийн хэргийн бүрдэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, Эрүүл мэндийн байгууллагуудын дэмжлэгт хяналт зэргийн хариуцан хяналт тавьж зөвлөмжөөр ханган ажиллаж байна. тайлант онд</p>
--	--	--	---

			<p>шинэчлэгдэн гарсан тогтоол шийдвэрийг дотоод программд хяналтад авч хэрэгжилтийг хагас бүтэн жилд тайлагнан хяналтын үнэлгээг хийж 88,3 хувьтай үнэлэн ажилласан.</p> <p>2024 оны 1 сард байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр сургалт хийсэн нь албан хаагчид оновчтой байдлаар төлөвлөж сурсан байна.</p>
--	--	--	---

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ  
ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Эрүүл мэндийн газар

2024 он

**ХҮНИЙ НӨӨЦИЙН НИЙГМИЙН ХАМГААЛАЛ АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ  
САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ЗАРЦУУЛСАН МӨНГӨ.

- Аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжиж байгаа “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг дэмжих тусламж үйлчилгээ үзүүлэх журам”-ын хүрээнд 42 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 288 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгт хамруулж амьдрах орчинг сайжруулж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн ба 1 эмчид сургалтын зардалд 2 сая, 2 хүнд эмчилгээний зардалд 7 сая төгрөгийн дэмжлэг нийт 46 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд 297 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна. Мөн нэн шаардлагатай хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор БОЭТ-ийн 3 эмчид амьдрах орчноо сайжруулахад нь 18 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Даланзадгад СЗДТГ-с “Оюуны үр хөтөлбөр”-ийн хүрээнд өрхийн эрүүл мэндийн төвийн 2 эмнэлгийн ажилтанд орон сууцны дэмжлэгт 6 сая төгрөг олгосон байна. Даланзадгад сумын ЗДТГ-аас ЭМГ-ын НЭМТ-ийн дарга Б.Амгаланд сургалтын төлбөрт 2 сая төгрөгөгсөн. Мөн ажилчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгаас Эрүүл мэндийн газрын 3 албан хаагчийн хүүхдийг оюутны тэтгэлэгт хамруулж 9 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.
- Эмч нарын баярыг тохиолдуулан Баян-Овоо сумын залуу эмчид амьдрах орчин нөхцөлөө сайжруулахад АЗДТГ-аас дэмжлэг болгож 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 1 сувилагчид таван ханатай гэр чип дулаалгын хамт 2 сувилагчид гэрийн чип дуулаалга олгож амьдрах орчин нөхцөлийг сайжруулсан байна. 2024 онд нийт **54** эмч, эмнэлгийн ажилчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, сургалт болон эмчилгээний зардалд нийт **324 сая** төгрөгийн дэмжлэгт хамруулсан.
- Эрүүл мэндийн салбарт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилчдад эрүүл мэндийн тухай хуулийн дагуу **146 эмч, эмнэлгийн ажилчдад 1,4 тэрбум** төгрөгийн тэтгэмж олгосон.
- Аймгийн Засаг даргын “Нутгийн хишиг хөтөлбөр”-ийн хүрээнд төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Нутгийн дэм” хөтөлбөрийг хэрэгжүүлж эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа ийт эмч, эмнэлгийн ажилчдад сар бүр 400.000 төгрөг олгодог ба 2024 онд 758 эмнэлгийн ажилчдад 303,2 сая төгрөг олгосон байна. Мөн орон нутгийн төсвөөс бүх төрийн байгууллагын албан хаагчдад орон нутаг ажилласаны нэмэгдлийг 25 хувиар тооцон олгож байна.
- Аймгийн 9 алдартанд 7 хүн, Даланзадгад сумын 9 алдартанд 5 нийт 12 хүний материалыг хүргүүлж аймгийн 9 алдартан 1, Даланзадгад сумын 9 алдартан 2 тодорсон. Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан ЭМЯ-ны шагналаар 19 эмч, эмнэлгийн ажилтан, аймгийн шагналаар 13, АИТХ-ын шагналаар 7 эмч, эмнэлгийн ажилчид шагнагдсан. Сувилагч нарын баярыг тохиолдуулан шагналын материал хүлээн авч Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор 2, ЭМЯ-ны шагнал 29, орон нутгийн шагналд 23 хүн шагнагдсан. Төрийн шагналаар шагнуулах албан хаагчдын материалыг хүлээн авч 24 хүний материалыг АЗДТГ-т хүргүүлснээс хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор-2, алтан гадас одонгоор-1, хөдөлмөрийн хүндэт медалиар-3 хүн нийт 6 хүн төрийн шагналаар шагнуулсан. Үндэсний статистикийн хорооны 100 жилийн ойг тохиолдуулж ЭМБ-уудын статистикчид, ахмад ажилчид нийт 21 хүний шагналыг материалыг аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлсэн бүгд Статистикийн тэргүүний ажилтнаар-19, жуух бичиг-2 хүн шагнагдсан. Эмнэлгийн



ажилчдын баярыг угтаж 9 хүний материалыг хүргүүлж Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан-4, ЭМЯ-ны жуух бичиг-2 шагнагдсан. 3-р улирлын байдлаар нийт 139 хүний материал хүргүүлснээс 121 хүн буюу 87.1 хувь нь шагнагдсан.

- Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа жолоо, үйлчлэгч, туслах ажилчдын сургалтын үеэр 18 туслах ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

## **ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР:**

### **Дотоод сургалт:**

-2024-2025 оны төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтад-7, төрөлжсөн мэргэшлийн сургалтад-12, мэргэшил дээшлүүлэх сургалтад 13 их эмч, 7 сувилагч, тусгай мэргэжилтэн суралцахаар эрүүл мэндийн сайдын А/125 дугаар тушаалаар хяналтын тоо батлагдсан. Төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх хаврын элсэлтэд 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр суралцаж байна. Үндсэн мэргэжлийн сургалтад-4 их эмч, төрөлжсөн болон мэргэшил дээшлүүлэх намрын элсэлтэд 19 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна.

-Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэшүүлэх чиглэлээр ЭТҮХ-ийн дарга Ж.Отгонбайгал, мэргэжилтэн М.Цэцэгсүрэн, мэргэжилтэн Б.Цагаанцэнд, ХШХ-ийн улсын ахлах байцаагч Б.Оюунсүрэн нар Удирдлагын академийн “Эрүүл мэндийн удирдлага”-ын богино хэмжээний сургалтад суралцаж амжилттай төгссөн. Мөн залуу боловсон хүчнийг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор НЭМТ-ийн мэргэжилтэн Тархвар судлагч А.Анударь ХӨСҮТ-ийн тандалт судалгааны албанд мэргэшил дээшлүүлэх сургалт, ХШҮМХ-ийн статистикч Ш.Нарандалай ЭМХТ-ийн Эрүүл мэндийн бүртгэл мэдээлэл, ХШХ-ийн Эрүүл ахуйн халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч З.Билгүүдэй нь АШУҮИС-ийн хүнсний эрүүл ахуйн чиглэлээр мэргэшил дээшлүүлэх, НЭМТ-ийн мэргэжилтэн А.Одмаа АШУҮИС-ийн НЭМС-д хөдөлмөрийн эрүүл ахуй мэргэшил дээшлүүлэхээр суралцаж байна.

-Монголын экспорт импортыг дэмжих үндэсний төвийн харьяа Потеншил сургалтын төвтэй хамтран төр, хувийн хэвшилд ажиллаж байгаа 25 эмнэлгийн мэргэжилтнүүдийг “Туслах сувилагч”-ийн 3 сарын сургалтад хамруулж мэргэжлийн үнэмлэхтэй болсон.

- Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоотой хамтран 12 сумын эрүүл мэндийн төвийн дарга нарыг Удирдлагын академийн “Сумын эрүүл мэндийн төвийн удирдлагын хөгжил” сэдэвт богино хугацааны сургалтад хамруулахаар хүсэлтийг хүргүүлж 2-р ээлжинд сурахаар төлөвлөгдсөн.

-БОЭТ, 14 СЭМТ, хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын эмнэлзүйн хоолны 20 тогооч нарт эмнэлзүйн хоолны нэр төрлийг олшруулах, амт чанарыг сайжруулах, тогооч нарын ажлын байрны чадамжийг нэмэгдүүлэх онол, дадлага хосолсон 3 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

-“Эрүүл Өмнөговь зорилтын хүрээнд” эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор АНУ-ын Монгол дахь элчин сайдын яамны "Иргэн цэргийн харилцааны дэмжлэгийн бүлэг", Монголын яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран "Эмнэлэг хүртэлх гэмтэгсдийг аврах тусламж" сэдэвт онол, дадлага хосолсон 3 хоногийн сургалтыг Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллагууд, уул уурхайн бүсэд яаралтай тусламж үйлчилгээ үзүүлдэг 24 эмч, мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан.

-УНТЭ-ийн Зүрхний төвийн Зөвлөх эмч, зүрх судас, судсан дотуурх мэс заслын эмч, тоног төхөөрөмжийн инженерийн баг 2024 оны 5-8 сарын хооронд 7 удаа Өмнөговь аймагт ирж БОЭТ-ийн эмч, сувилагч, тоног төхөөрөмжийн инженер, техникч, туслах сувилагч нарын багтай хамтран үзлэг, оношилгоо, эмчилгээ хийж, мөн эмч мэргэжилтнүүдийг ажлын байран дээр сургасан.

-“Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд Франц улсын “ACTIONS MONGOLIE” ТББ-тай хамтран Франц улсын нүдний эмч, тоног төхөөрөмжийн инженер нар БОЭТ-д ажиллаж шаардлагатай иргэдэд дурангийн мэс засал, нүдний эмчийн үзлэг, эмч нарыг ажлын байран дээрх дагалдан сургалтыг зохион байгуулсан.

- "Нутгийн Хишиг" хөтөлбөрийн хүрээнд эмч, эмнэлгийн ажилчдыг өөрсдийн ажлын байр, тоног төхөөрөмжид нь лавлагаа шатлалын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар дагалдуулан чадваржуулах, улмаар орон нутагт хийгддэггүй шинэ оношилгоо, эмчилгээний аргыг нутагшуулах зорилтыг тавин ажиллаж энэхүү ажлын хүрээнд ХБНГУ-ын Анагаах ухааны доктор, эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын их эмч Хенниг Риттер нь 15 хоногийн хугацаанд БОЭТ-ийн хавдрын их эмч, дүрс оношилгооны их эмч, эмэгтэйчүүдийн их эмчтэй хамтран 100 гаруй иргэдэд үзлэг, оношилгоо хийж, эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээр дагалдан сургаж ажилласан.

-ЭМС-ын тушаалаар томилогдсон Үндэсний баг болох УНТЭ, УГТЭ, ХСҮТ, УХТЭ-ийн Зүрх судасны ангиографи, мэдрэлийн ангиографи, хэвлийн хөндийн ангиографийн эмч нар БОЭТ-д 2 удаа томилогдон ажилласан. Ингэснээр Өмнөговь аймагт эмнэлгийн тусламж үйлчилгээний шинэ технологийг нэвтрүүлж, мэдрэлийн ангиографи, хэвлийн ангиографи эмчилгээнүүдийг анх удаа хийж, цаашид нутагшуулахаар эмч, мэргэжилтнүүдийг ажлын байран дээр дагалдуулан сургасан.

-Канад Улсын Бритиш Колумбиагийн их сургуулийн профессор, Лаурел мэс заслын сангийн УЗ-ийн гишүүн, төслийн удирдагч Хью Парсонс, Лаурел мэс заслын сангийн УЗ-ийн нарийн бичгийн дарга Кристин Туано нар ШУГТЭ, УНТЭ-ийн нүдний эмч, резидент эмч нар Өмнөговь аймгийн БОЭТ-ийн нүдний эмч, сувилагч нартай хамтарсан үзлэг оношилгоог хийж, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулж ажиллаа.

-“Эрүүл Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд АШУҮИС-ийн хүүхдийн тэнхимийн эмч нар орон нутгийн эмч, сувилагч нарыг чадваржуулах зорилгоор “Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгийн үеийн менежмент” сургалтыг ЭМГ болон БОЭТ дээр зохион байгууллаа. Сургалтад БОЭТ, 14 сум, 3 ӨЭМТ, ХХЭМБ-ын нийт 50 эмч, 26 сувилагч хамрагдлаа. Мөн АШУҮИС-ийн харьяа Монгол-Япон эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар БОЭТ-ийн эмч нартай хамтарсан үзлэг хийж эмч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулсан.

- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс хүний нөөцийн бодлого, сургалт, магадлан итгэмжлэл, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, халдвараас сэргийлэх хяналт, эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөл, эмнэлгийн программ хангамж, статистик мэдээллийн талаар Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 34 алба хаагчдад ажлын байрны чиглүүлэх дадлага сургалтыг зохион байгуулан арга зүйгээр ханган ажилласан.

Ажлын байран дахь сургалт-15

Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо-181

Орон нутгаас эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ЭМЯ, ЭМХТ, НЭМҮТ, АШУҮИС, ХӨСҮТ, ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ, УХТЭ-ээс эмч,

багш нарыг урьж танхимын 22 удаагийн сургалтуудыг зохион байгуулж нийт 1154 эмч, эмнэлгийн ажилчдыг хамруулсан. Эрүүл мэндийн газраас Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилийн хүрээнд 29 аж ахуй нэгж байгууллага, 1541 иргэд олон нийтэд нийгмийн эрүүл мэндийг тухай хуулийг сурталчилах, нийгмийн эрүүл мэндийн 8 чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулсан. Мөн Нийгмийн эрүүл мэндийн төвөөс эрүүл мэнд, боловсролын салбарын 495 мэргэжилтэн ажилтанд 13 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.

Нийт зохион байгуулсан сургалтын тоо- 64

Сургалтад хамрагдсан хүний тоо- 3190

### **УЛААНБААТАР ХОТ, ОРОН НУТАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД:**

- Олон улсын эмч нарын өдөрт зориулсан “ЭМЧ ТАНААРАА БАХАРХЪЯ” арга хэмжээ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж энэхүү арга хэмжээнд аймаг дүүргийн нийт 2500 гаруй эмч эмнэлгийн ажилтан оролцсон ба Өмнөговь аймгаас 45 удирдлага, эмч, мэргэжилтнүүд оролцсон.
- Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдрийн угтан АШУҮИС-ийн харьяа сувилахуйн сургуультай хамтран “БАГШ ШАВИЙН ЭРДМИЙН УУЛЗАЛТ-2024” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Сургалтад БОЭТ, сум, өрх, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нийт 170 гаруй сувилагч, тусгай мэргэжилтнүүд 2 өдрийн сургалтад хамрагдсан. Сургалтаар Сувилахуйн удирдлага манлайлал, Амилуулах суурь тусламж, Төрөлжсөн сувилахуй, Харилцааны урлагт суралцахуй, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сэдвүүдийн хүрээнд амжилттай зохион байгуулсан.
- "Төрийн бүтээмжийн сэргэлт - Цахим эрүүл мэнд" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад бүх шатны эрүүл мэндийн салбарт ажиллаж буй удирдах ажилтан, эмч, мэргэжилтэн нийт 356 хүн хамрагдлаа. Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан сургалтын зорилго нь Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн шинэчлэл болон мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд учрах чирэгдлийг бууруулах, төрөөс баримталж буй бодлого чиглэлийг эрүүл мэндийн салбарын ажилтан албан хаагчдад танилцуулах юм.
- “НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ-2024” хүрээнд 21 аймгийн Эрүүл мэндийн газруудын чуулга уулзалт зохион байгуулагдаж, уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгийн газрын “Эрүүл Монгол хүн” төсөл хөтөлбөр хариуцсан албаны дарга, Эрүүл мэндийн яамны албаны дарга, Эрүүл мэндийн Хөгжлийн төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дарга нар илтгэл тавьж, нийслэлийн Эрүүл мэндийн газар, 21 аймгийн Эрүүл мэндийн газар болон орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд нийт 500 гаруй эмч, мэргэжилтнүүд оролцож, эрүүл мэндийн чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлого, шийдвэрийн талаар мэдээ, мэдээлэл авч, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцож, туршлагаа хуваалцсан юм.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, Монголын эмч нарын VII Их хурал, багийн эмч нарын зөвлөгөөнд Өмнөговь аймгаас удирдах ажилтан 20, эмч-25, багийн эмч-25 нийт 70 удирдах ажилтан, эмч, багийн эмч нар хамрагдсан.

Арга хэмжээний тоо-5

Оролцсон хүний тоо-1141

## Гадаад сургалт:

-Эрүүл мэндийн сайдын “Гадаад сургалтад суралцуулах тухай” 199 дүгээр тушаалын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод зохион байгуулагдах богино хугацааны гадаад сургалтад сумдын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, сувилагч, багийн эмчийн мэдээллийг авч сургалтад хамруулж байна. 1,2-р ээлжид 3 сувилагч богино хугацааны гадаад сургалтад хамрагдсан. 3 сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч 3-р ээлжид явуулахаар хүсэлт хүргүүлсэн.

-Эрүүл мэндийн газар, Улаанбаатар Их Сургуультай хамтран БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 7 сувилагчийг БНСУ-д туршлага судлах 7 хоногийн богино хугацааны дадлага сургалтад хамруулсан.

-Нутгийн хишиг хөтөлбөрийн хүрээнд БНХАУ-Төв Ази болон Шанхай хотын хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудыг оролцуулан Urumqi хот дахь Шянжаны Анагаах Ухааны Их Сургуультай хамтран зохион байгуулсан “Умайн хүзүү болон хөхний хорт хавдрын урьдчилан сэргийлэлт ба хяналт” сэдэвт олон улсын конференцэд 2024 оны 07 сарын 05-ны өдрөөс 07 сарын 19-ны хооронд Х.ШБОЭТ-ийн эх барих, эмэгтэйчүүдийн 2 эмчийг хамруулсан.

-Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад орноос туршлага судлах, ажлын байрны дагалдан сургалтыг Даланзадгад сумын ЗДТГ-ын “Оюуны үр” хөтөлбөрийн санхүүжилтээр Япон улсын эрт илрүүлгийн төвийн үйл ажиллагаатай танилцах, орчин үеийн эмнэлгийн тоног төхөөрөмж судлах ажлаар 27 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Даланзадгад сумын засаг даргын “Дэвшилтэд Даланзадгад” хөтөлбөрийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлага, холбогдох эмч, мэргэжилтэн 8 хүнийг Солонгос улсын Жонжу хотын Дизайн эмнэлэг дээр туршлага судлуулсан

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020-2024 оны “Нутгийн хишиг” мөрийн хөтөлбөр, Эрүүл Өмнөговь зорилтын хүрээнд Япон улсад “Хүүхдийн өвчний менежмент, тусламж үйлчилгээг сайжруулах” зорилгоор БОЭТ болон Сум, Өрхийн ЭМТ-ийн хүүхэд, нярайн 6 эмч нарыг туршлага судлах гадаад сургалтад хамруулсан.

-Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын 22 албан хаагч Бүгд найрамдах Хятад ард улсын Хөх хотын Олон улсын эмнэлгийн хороонд туршлага судласан.


-“ГОВИЙН ОЮУ” хөгжлийг дэмжих сан, Аймгийн Засаг даргын Тамгын газрын хамтын ажиллагааны “Өмнөговь аймгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр” болон БНСУ-ын Чонжү хотын “ДИЗАЙН” эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд “Уламжлалт, Сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах” зорилгоор богино хугацааны эмнэлзүйн сургалтад хамруулах, туршлага судлан ажлын байранд суралцуулахаар 11 эмч, сувилагчийг хамруулсан.

Гадаад, дотоод сургалтын дэмжлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн ажилчдын тоо-115

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ШАЛГУУР**

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин /Өмнөх оны түвшин/	Хүрсэн түвшин
1	Засгийн газар, төрийн байгууллага бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо	54	1116
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	6	388
			Мэргэшүүлэх сургалт	13	63
			Туршлага солилцох арга хэмжээ	5	42
			Бусад	30	595
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	3000	7619
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	2500	6684
			Эрэгтэй албан хаагч	500	906
			Удирдах албан тушаалтан	400	956
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	2600	6609
1.3	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал; Нийт албан хаагчдад эзлэх хувь	90	88%		
2	Албан хаагчдыг хөгжүүлэх мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	5	6
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	40	115
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	25	99
			Эрэгтэй албан хаагч	15	12
			Удирдах албан тушаалтан	10	24
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	30	86
2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал; Нийт албан хаагчдад эзлэх хувь	15	18		
3	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ	60 сая	236,9 сая
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	10	15%
4	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	62%	63%
			Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл(мян.төг)	446,7 сая	508,6 сая

5	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл		Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн(Албан хаагчдын сэтгэл ханамж)	50%	84%
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, үндчил	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг(Жилд)	379	638
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	80 хувь	84 хувь
7	Албан хаагчдын нийгмийн баталгаа	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ(сая.төг)		1,1 тэрбум

Тайлан хянасан: ЭМГ-ын дарга  Ц.Жавзандулам

Тайлан гаргасан: УТСХ-ийн дарга  Б.Ганшагай

УТСХ-ийн мэргэжилтэн  Ж.Наранжаргал

## 2024 оны үйл ажиллагааны зурган тайлан

**Зураг -1** Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын байран дахь мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх

Ажлын байран дахь сургалт-15

Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо-181





**Зураг-2** 2024 онд зохион байгуулсан томоохон арга хэмжээнүүдийн зарим зураг





**Зураг- 3** Эрүүл мэндийн газрын албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх тайлангийн танилцуулга хурлыг зохион байгууллаа. Мэргэжилтнүүд хагас бүтэн жилийн хэрэгжилт талаар танилцуулга мэдээллийг нийт алба хаагчийн дунд тайлагналсан.



**Зураг-4** Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024 арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн газар, Говь дент шүдний эмнэлэг, Ахмадын чөлөөт холбоо, Ахмадын хороотой хамтран Даланзадгад сумын 10 багийн 80 гаруй ахмадад шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгээр 63 ахмад настан шүд ломбодуулах, буйлны үрэвслийн эмчилгээ, шүд авхуулах, хиймэл шүд хийлгэх шаардлагатай байлаа. Ахмад настны тухай хуулийн 8.1.1-д заасан үйлчилгээ болон эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг 2025 оны төлөвлөгөөндөө тусгаж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.





**Зураг-5 АЙМГИЙН “ЭРҮҮЛ ШҮД” ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ДАЛАНЗАДГАД СУМЫН ЕБС-ИЙН СУРАГЧДЫН ДУНД “ШҮД УГААЛТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН” АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.**

“Эрүүл Өмнөговь” зорилтын хүрээнд “Эрүүл шүд” хөтөлбөр хэрэгждэг бөгөөд Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-12 насны сурагчдын дунд “Шүд угаалтын аварга шалгаруулах тэмцээн” шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж, 6 сургуулийн 17 багийн 144 сурагч амжилттай оролцлоо.



**Зураг-6 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, КОМПЬЮТЕР ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ ГАРДУУЛАН ӨГЛӨӨ.**

Орон нутгийн төсвийн 400 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 12 эрүүл мэндийн байгууллагад 33 нэр төрлийн 64 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг хуваарилан хүлээлгэн өгсөн.

Мөн улсын төсвийн 396,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 20 эрүүл мэндийн байгууллагад суурин-38ш, зөөврийн-100ш компьютер, техник хэрэгслийг хүлээлгэн өгөв. НҮБ-ын Хүүхдийн сан, Өмнөговь аймгийн Засаг даргын #Нутгийн\_хишиг хөтөлбөрийн хүрээнд 15 сумын Эрүүл мэндийн төвд яаралтай түргэн тусламжийн багц, тус бүр 3 ширхэг зөөврийн компьютер, хүчилтөрөгчийн баллон зэрэг тоног төхөөрөмж эд зүйлсийг шийдвэрлэж, хүлээлгэн өгсөн.





**зураг-7** АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

НҮБ-аас Ерөнхий Ассамблейлаас жил бүрийн 12 дугаар сарын 09-ний өдрийг “Авлигын эсрэг олон улсын өдөр” болгон тэмдэглэж байгаа шийдвэрлэсэн байдаг. Үүний хүрээнд Эрүүл мэндийн газраас Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч, эмнэлгийн ажилчдад “Авлигын эсрэг хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхол зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн талаар ерөнхий мэдлэг олгох сургалтыг Монголын хуульчдын холбооны Өмнөговь аймаг дахь салбарын тэргүүн Э.Дөлгөөн, Авлига, ашиг сонирхлын гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Өмнөговь аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн гишүүн өмгөөлөгч И.Оюунгэрэл нар сургалт хийлээ.







**зураг -8** Хүний папиллома вирусийн эсрэг вакцин ба дархлаажуулалттай холбоотой иргэдийн дунд үүсээд буй буруу ташаа мэдээлэлтэй холбоотойгоор ард иргэдэд зөв мэдээлэл түгээх, шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв эх сурвалжуудаас мэдээллийг өгч ажилласан.



**зураг -9 СУМДАД ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА.**

Аймгийн ЗДТГ-ын дэмжлэг, “Говийн оюу” хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр сумдад олон нийтийн эрүүл мэндийн ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулсан.

ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН нь тухайн нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагаас алслагдсан цэгт байгаа бага насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүрч үйлчлэх зорилгоор бэлтгэгдсэн.

Энэхүү сургалтын үр дүнд эрүүл мэндийн байгууллагын хүрч үйлчилж чадахгүй байгаа зорилтот иргэдэд тусламж үйлчилгээг ойртуулах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.





**Зураг 10** Эрүүл мэндийн газрын даргын удирдамжийн дагуу 12 Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт үнэлгээг хийж гүйцэтгэж зөвлөгөө зөвлөмжөөр хангасан.




**Зураг-11** Ангиографийн оношилгоо, эмчилгээг орон нутагтаа өргөжүүлэн, хөгжүүлхээр ажилласан.





2025 онд Фэйсбүүк хуудсаар нийт 154 видео мэдээлэл, 210 пост оруулсан.

Нийт давхардсан тоогоор 654,886 хандалт авсан байна





Зураг -13 Зуны сувилал

